



Санхүүгийн
Зохицуулах Хороо



Нээлттэй Нийгэм
Форум

САНХҮҮГИЙН ХӨТӨЧ

Иргэдэд зориулсан
гарын авлага

Анхны хэвлэл

Улаанбаатар, 2010



Нээлттэй
Нийгэм
Форум

“САНХҮҮГИЙН ХӨТӨЧ ” ГАРЫН АВЛАГЫГ БЭЛТГЭСАН БАГ

Зохиогчид: **Л.ОЮУН**, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн
Санхүүгийн тэнхимийн багш, доктор (PhD), профессор

Б.АЮУШ, Санхүүгийн зохицуулах хорооны даргын зөвлөх,
мэргэшсэн нягтлан бодогч, доктор (PhD), профессор

Б.ГАНБОЛД, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын
орлогч дарга, Бизнесийн удирдлагын магистр

Д.ДҮГЭРЖАВ, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн бөгөөд дэд
дарга, хууль зүйн магистр, докторант, дэд профессор

П.ЦЭРЭНДЭЖИД, Санхүүгийн зохицуулах хорооны
Даатгалын газрын орлогч дарга, Төрийн бодлогын магистр

Б.ОЮУНБИЛЭГ, Санхүүгийн зохицуулах хорооны
Бичил санхүүгийн газрын орлогч дарга

Ш.ЭРДЭНЭЦЦЭГ, Санхүүгийн зохицуулах хорооны
Бичил санхүүгийн газрын ахлах хянан шалгагч, улсын байцаагч,
магистр, докторант

М.БОЛОРТУЯА, Санхүүгийн зохицуулах хорооны Санхүүгийн
тайлан, аудит, үнэлгээний чанарын хяналтын газрын дарга,
мэргэшсэн нягтлан бодогч, Бизнесийн удирдлагын магистр

Ө.ГАНЗОРИГ, “Прайм даатгал” компанийн гүйцэтгэх захирал,
Санхүүгийн удирдлагын магистр

Зөвлөх: **Б.МӨНХСОЁЛ, Ч.ОТГОЧУЛУУ**

Хянан тохиолдуулсан: **Д.ДҮГЭРЖАВ, Б.АЮУШ**

Хэвлэлийн эх бэлтгэгч: А.Чинбат

Зураач: Ц.Хатанбаатар

DDC
336'023
C-325

ISBN 978-99929-64-33-2

Агуулга

I БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ТАНЫ ОРОЛЦОО

Б.Ганболд

II БҮЛЭГ. ТА ОРЛОГО ОЛСОН БОЛ...

Л.Оюун, Ш.Эрдэнэцэцэг, Т.Ганзориг, Д.Дүгэржав

III БҮЛЭГ. ТАНД МӨНГӨ ШААРДЛАГАТАЙ БОЛ...

Л.Оюун, Ш.Эрдэнэцэцэг, Б.Оюунбилэг, Т.Ганзориг

IV БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ НЬ

М.Болортuya, Б.Аюуш

V БҮЛЭГ. ЭРСДЛИЙН ТУХАЙ

Б.Ганболд, П.Цэрэндэжид

Гарчиг

| | |
|---|----|
| ИРГЭН ТАНЫГ ХӨТЛӨХИЙН УЧИР..... | 8 |
| ӨМНӨХ ҮГ | 9 |
| I БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ТАНЫ ОРОЛЦОО | 11 |
| 1.1. Санхүүгийн зах зээл гэж юу вэ? | 11 |
| 1.1.1. Ерөнхий ойлголт..... | 11 |
| 1.1.2. Санхүүгийн зах зээл | 13 |
| 1.1.3. Иргэд хөрөнгийн зах зээлд хэрхэн оролцох вэ? | 15 |
| 1.1.4. Хөрөнгийн зах зээлд оролцогч иргэд, хөрөнгө оруулагчдыг төрөөс хэрхэн хамгаалдаг вэ?..... | 18 |
| 1.1.5. Санхүүгийн зах зээлд оролцогч –хувь хүний хариуцлага... <td>19</td> | 19 |
| 1.2. Хувийн санхүүгээ төлөвлөх | 21 |
| 1.2.1. Төлөвлөлтийн ач холбогдол | 21 |
| 1.2.2. Төлөвлөх, хэрэгжүүлэх үе шат | 23 |
| 1.2.3. Орлогын эх үүсвэр бүрдүүлэх | 24 |
| 1.2.4. Хуримтлал бий болгох | 26 |
| 1.2.5. Хөрөнгө оруулалт хийх..... | 27 |
| II БҮЛЭГ. ТА ОРЛОГО ОЛСОН БОЛ..... | 29 |
| 2.1. Мөнгөн хадгаламж: Банк | 30 |
| 2.1.1. Мөнгөн хадгаламж гэж юу вэ? | 30 |
| 2.1.2. Хадгаламжийн давуу тал | 30 |
| 2.1.3. Хадгаламжийн сул тал..... | 31 |
| 2.1.4. Хадгаламж хийхдээ юу анхаарах вэ? | 31 |
| 2.1.5. Хадгаламжийн төрлүүд..... | 32 |
| 2.2. Мөнгөн хадгаламж: Хадгаламж зээлийн хоршоо | 35 |
| 2.2.1. Хадгаламж, зээлийн хоршооны талаарх ерөнхий ойлголт. | 36 |
| 2.2.3. Хадгаламж, зээлийн хоршооны давуу болон сул тал..... | 36 |
| 2.2.4. Хадгаламж, зээлийн хоршооны мөнгөн хадгаламжийн үйлчилгээ | 37 |
| 2.2.5. Хадгаламж зээлийн хоршоонд гишүүнээр элсэхэд анхаарах зүйл | 39 |

| | | |
|--------|--|-----------|
| 2.3. | Хөрөнгө оруулалт: Хувьцаа | 39 |
| 2.3.1. | Та хувьцаа эзэмшдэг үү? | 39 |
| 2.3.2. | Хувьцаа эзэмшихийн давуу болон сул тал | 42 |
| 2.3.4. | Шинээр гаргаж буй хувьцааны онцлог..... | 45 |
| 2.4. | Хөрөнгө оруулалт: Бонд..... | 46 |
| 2.4.1. | Бонд эзэмшихийн давуу болон сул тал | 48 |
| 2.4.2. | Бонд худалдан авахад анхаарах зүйл..... | 48 |
| 2.4.3. | Бондын хүү | 49 |
| 2.4.4. | Бондын өгөөж | 50 |
| 2.5. | Хөрөнгө оруулалтын сан | 51 |
| 2.5.1. | Ерөнхий ойлголт..... | 51 |
| 2.5.2. | ХОС-гийн төрлүүд..... | 52 |
| 2.5.3. | ХОС-гийн давуу ба сул тал..... | 52 |
| 2.6. | Ирээдүйдээ хийх хөрөнгө оруулалт буюу даатгалын тухайд | 53 |
| | III БҮЛЭГ. ТАНД МӨНГӨ ШААРДЛАГАТАЙ БОЛ..... | 55 |
| 3.1. | Санхүүжилт: Зээл | 56 |
| 3.1.1. | Банкны сектор | 56 |
| 3.1.2. | Арилжааны банкны зээл..... | 57 |
| 3.1.3. | Банкны зээлийн төрлүүд | 57 |
| 3.1.4. | Зээл авахад анхаарах зүйл | 62 |
| 3.1.5. | Зээл авахад бүрдүүлэх материал | 65 |
| 3.1.6. | Зээлээ төлөөгүйгээс үүсэх эрсдэл..... | 66 |
| 3.1.7. | ББСБ, ХЗХ-ны зээлийн онцлог..... | 67 |
| 3.2. | Санхүүгийн үйлчилгээний бусад төрлүүд..... | 68 |
| 3.2.1. | Лизинг..... | 68 |
| 3.2.2. | Факторинг..... | 70 |
| 3.2.3. | Төлбөр тооцоо | 73 |
| 3.3. | Санхүүжилт: Үнэт цаасаа нийтэд санал болгох (IPO) | 74 |
| 3.3.1. | Ерөнхий ойлголт..... | 74 |
| 3.3.2. | Андеррайтер (хөрөнгө оруулалтын банк) –ын үүрэг | 75 |

IV БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ НЬ..... 79

| | | |
|--------|---|----|
| 4.1. | Харилцагч санхүүгийн байгууллагаа сонгох нь | 79 |
| 4.2. | Рейтинг буюу зээлжих чадварын үнэлгээ | 81 |
| 4.3. | Аудит | 82 |
| 4.3.1. | Ерөнхий ойлголт..... | 82 |
| 4.3.2. | Аудитын үйл ажиллагаанд оролцогч талууд | 83 |
| 4.3.3. | Аудитын тайлан | 83 |
| 4.4. | Хөрөнгийн үнэлгээ..... | 86 |
| 4.4.1. | Аргачлал | 86 |
| 4.4.2. | Үнэлгээний зүйл | 86 |
| 4.4.3. | Үнийн төрлүүд | 87 |
| 4.4.4. | Хараат бус үнэлгээчин..... | 87 |
| 4.4.5. | Үнэлгээний тайлан..... | 88 |
| 4.5. | Компаний засаглал | 89 |

V БҮЛЭГ. ЭРСДЛИЙН ТУХАЙ..... 93

| | | |
|---------|--|-----|
| 5.1. | Санхүүгийн эрсдэл..... | 93 |
| 5.1.1. | Ерөнхий ойлголт..... | 93 |
| 5.1.2. | Хөрөнгө оруулалтын эрсдэл, түүний ангилал | 94 |
| 5.1.3. | Эрсдлээс сэргийлэх ба эрсдлийг бууруулах | 96 |
| 5.2. | Даатгалын тухай..... | 97 |
| 5.2.1. | Ерөнхий ойлголт..... | 97 |
| 5.2.2. | Даатгалын зарчим | 99 |
| 5.2.3. | Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалт | 100 |
| 5.2.4. | Даатгалын зуучлагч, төлөөлөгч | 101 |
| 5.2.5. | Даатгалын хэлбэр | 101 |
| 5.2.6. | Давхар даатгал | 102 |
| 5.2.7. | Бичил даатгал..... | 102 |
| 5.2.8. | Малын индексжүүлсэн даатгал | 103 |
| 5.2.9. | Авто машины даатгал | 103 |
| 5.2.10. | Урт хугацааны буюу амьдралын даатгал | 105 |
| 5.2.11. | Даатгалын бүтээгдэхүүнээ сонгох нь..... | 108 |

| | |
|---|-----|
| ХАВСРАЛТ | 113 |
| Хавсралт 1. Хувийн санхүүгийн зорилгоо тодорхойлох хүснэгт..... | 113 |
| Хавсралт 2. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын мэдээлэл | 114 |
| Хавсралт 3. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй аудитын компаниудын жагсаалт..... | 119 |
| Хавсралт 4. Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээний компаниуд | 122 |
| Хавсралт 5. Арилжааны банкуудын вэб хаяг..... | 124 |
| Хавсралт 6. Тусгай зөвшөөрөлтэй даатгалын компаниудын хаяг | 124 |
| Хавсралт 7. Даатгалын зуучлагч компаниуд | 125 |
| Хавсралт 8. Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд | 125 |
| Хавсралт 9. Хөрөнгө оруулалтын үндсэн шалгуурууд | 126 |
| Хавсралт 10. СЗХ-д хандах жишээ | 129 |
| Хавсралт 11. Орон сууцны зээл авах үе шат | 130 |
| Хавсралт 12. ХЗХ: Зээл хүссэн өргөдлийг шийдвэрлэх..... | 131 |
| Хавсралт 13. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа | 132 |
| Хавсралт 14. Интернетээр арилжаанд оролцох нь..... | 133 |
| Хавсралт 15. Компаний засаглалын тухай | 135 |
| Хавсралт 16. Салбарын хуулийн холбогдох заалтууд..... | 140 |

Иргэн таныг хөтлөхийн учир

Нээлттэй Нийгэм Форумаас бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой сэдвүүдээр иргэдэд зориулсан цуврал гарын авлага боловсруулан гаргадаг билээ. Эдгээр цуврал номын нэг болох “Санхүүгийн хөтөч” гарын авлагыг Танд өргөн барьж байна.

Энэхүү гарын авлага нь санхүү, эдийн засгийн нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж буй энэ үед иргэдэд санхүүгийн зах зээлд оролцох, хувийн санхүүгээ арвижуулах, санхүүгийн хувьд аливаа эрсдэлтэй алхам хийхээс зайлсхийхэд хэрэг болох мэдлэг мэдээллийг агуулсан болно. Гарын авлагыг иргэдийн эдийн засаг, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийж байгаа ажлын хүрээнд бидний саяхан орчуулсан “Эдийн засаг энгийнээр” хэмээх номын дараагийн цуврал болгон хэвлүүлж байгаа бөгөөд санхүүгийн зэх зээл, түүний үр өгөөж, ач холбогдлыг иргэдэд ойлгомжтой, энгийн хэлбэрээр хүргэхийг зорьсон болой.

“Санхүүгийн хөтөч” гарын авлагыг хамтран санаачилж, гардан бичиж Таны гарт хүргэх бололцоо олгосон Д. Дүгэржав ахлагчтай багт гүн талархлаа илэрхийлье. Монгол Улсын санхүүгийн зах зээлээр мэргэшсэн эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн хамтарч бичсэн уг гарын авлага нь уншигч Танд үр өгөөжөө өгөх болно гэдэгт найдаж байна.

Гарын авлагын чанар, агуулгатай холбогдсон санал хүсэлтийг osf@forum.mn хаягаар бид хүлээн авах болно.

П. Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал

Өмнөх үг

Аливаа улсын эдийн засгийг амьд организмтай зүйрлэвэл түүний зүрх, судасны системийг санхүүгийн зах зээл гэж үздэг. Тиймээс санхүүгийн зах зээлийн талаар орчин үеийн иргэд анхан шатны ойлголттой байж, улмаар өдөр тутмын амьдралдаа хэрэглээ болгон төлөвшүүлбэл чинээлэг, хангалиун амьдрах боломжкоо өсгөж нэмэгдүүлэх нь тодорхой. Энэхүү зорилгын үүднээс бид санхүүгийн анхан шатны мэдлэг олгоход тус нэмэр болохуйц “Санхүүгийн хөтөч” гарын авлагыг уншигч Танд анх удаа өргөн барьж байгаадаа баяртай байна.

Энэхүү гарын авлагад хувийн санхүүгийн зорилгоо тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, олсон орлогоо хэрхэн хадгалж аввижуулах боломж буюу төрөл бүрийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тухай өгүүлэх болно. Түүнчлэн бизнесээ санхүүжүүлэх мөнгө хэрэгтэй байгаа бол санхүүгийн ямар төрлийн байгууллагын, ямар үйлчилгээг ашиглаж болох тухай, мөн өөрт буй мөнгөө аль нэг компанийй үйл ажиллагаанд хөрөнгө оруулах замаар аввижуулахыг хүсч байвал юу анхаарах талаар өгүүлнэ.

Санхүүгийн аливаа шийдвэр гаргахдаа зөвхөн ашиг төдийгүй, түүний эрсдлийг харгалзаж үзэх шаардлагатай. Гарын авлагад эрсдлээ хэрхэн тодорхойлох, түүнээс хэрхэн сэргийлэх, эрсдлийг зохицтой удирдах хүрээнд даатгалын ач холбогдол, сонголт, хэрэглээний талаар мөн товч дурдсан болно. Түүнчлэн санхүүгийн зах зээлд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх учиртай төрийн байгууллагын чиг үүргийн тухай толилуулав.

Хавсралтад санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хаяг болон тухайн асуудлаар илүү дэлгэрэнгүй унших мэдээлэл, салбарын хуулийн холбогдох заалтуудыг оруулсан болно.

Энэхүү гарын авлагыг санхүүгийн боловсролоо дээшлүүлэхийг хүссэн хэн бүхэн, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэдээллийг түгэх чиг үүрэгтэй боловсролын болон төрийн байгууллага, эсвэл харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ санхүүгийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх нь үйл ажиллагааны маркетингийн зорилгод нь нийцэж байдаг бүх байгууллага үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглах боломжтой.

Д. Дүгэржав
Санхүүгийн зохицуулах хорооны
гишүүн бөгөөд дэд дарга

I БҮЛЭГ.

Санхүүгийн зах зээл ба таны оролцоо

Энэ сэдвийг судалснаар Та:

- Зах зээлийн талаар ойлголттой болж, түүний дотор санхүү, мөнгөний болон хөрөнгийн зах зээлийн талаар суурь мэдлэг олж авна.
- Хөрөнгийн зах зээлд жирийн иргэн хэрхэн оролцох, Хөрөнгийн биржийн үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хэрхэн хамгаалагддаг талаар ойлголтой болно.
- Хувийн санхүүгийн төлөвлөгөө зохиох, хэрэгжүүлэх, түүний ач холбогдлын талаар мэдэх болно.

Энэ бүлэгт санхүүгийн зах зээлийн мөн чанарыг тайлбарлаж, уг зах зээлд иргэд хэрхэн оролцох талаар өгүүлнэ. Санхүүгийн зах зээлийн ажиллах зарчмыг сайтар ойлгож, хариуцлагатай хандан, ажлаа бодитой төлөвлөж чадсан нөхцөлд оролцогч-иргэн бүр үр шимийг нь илүү хүртэх боломжтой.

1.1. Санхүүгийн зах зээл гэж юу вэ?

1.1.1. Ерөнхий ойлголт

Зах зээлийг нэг талаас эрэлт, нөгөө талаас нийлүүлэлт үүсч буй талбар гэж энгийнээр ойлгож болох юм. Чөлөөт зах зээлийн онцлог нь худалдагч, худалдан авагчдын чөлөөт сонголт, итгэлцэл дээр суурисан байдаг. Социалист буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт “чөлөөт зах зээл” гэсэн ойлголт байсангүй. Учир нь Улсын төлөвлөгөөний комисс энгийн иргэд юу хэрэглэх, үйлдвэрүүд ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг батлаад өгчихдөг байв. Социалист систем ийнхүү иргэдийн жам ёсны эрх буюу ашиг олох, бүтээлчээр сэтгэх, чөлөөт сонголтыг хязгаарлаж байсан учир 1990-ээд онд нуран унасан билээ.

Зах зээлийг бүтээгдэхүүнээр нь төрөлжүүлэн нэрлэдэг. Тухайлбал, зэс, нүүрс, алт зэргийг нэгтгэн уул уурхайн түүхий эдийн зах зээл гэж хэлдэг. Үүнээс гадна Улаанбаатар хотын, Завхан аймгийн зах зээл эсвэл дэлхийн зах зээл гэх зэргээр байршилаар нь нэрлэж болно.

Тэгвэл санхүүгийн зах зээл гэж юу вэ? Санхүүгийн зах зээлийг нэг талаас санхүүжилт шаардлагатай байгаа, нөгөө талаас мөнгөө өсгөх гэж буй хүмүүсийн уулзаж буй талбар гэж үзэж болно. Үүнийг банк болон биржээр төлөөлүүлэн тайлбарлая.


Хуримтлал үүсгэж, хүүгийн орлого олох зорилгоор иргэд банкинд мөнгөө хадгалуулдаг бол бизнесийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх хүсэлтэй иргэд банкинд хандаж зээл хүсдэг. Банк нь харилцагчдын итгэл дээр оршин тогтнож, үйл ажиллагаагаа явуулдаг санхүүгийн зуучлагч байгууллага юм. Үүний адилаар хөрөнгийн бирж дээр санхүүжилт хэрэгтэй байгууллагууд хувьцаа, бонд зэрэг үнэт цаас гаргадаг бол нөгөө талаас, мөнгөө өсгөж ашиг олох гэсэн иргэд тухайн хувьцаа, бондыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийдэг. Энэ үйл ажиллагаа нь хөрөнгийн биржээр дамжих хэрэгжинэ.

Хөрөнгийн бирж нь хөрөнгө оруулагч, санхүүжигчдийн хооронд үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн арилжаа солилцоо гүйцэтгэх орчныг бүрдүүлдэг. Манай оронд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа бусад орнуудтай харьцуулахад төдийлөн сайн хөгжөөгүй байна. Хөрөнгийн зах зээлийг сонгомол утгаар нь хөгжүүлэхийн тулд манай улсад уг зах зээлтэй холбоотой хууль эрх зүйн системийг бүрдүүлэх асуудал юу юунаас чухал ба хууль эрх зүйн зөв систем үйлчилснээр иргэдийн идэвхитэй оролцоо нэмэгдэж, ингэснээр хөрөнгийн зах зээл хөгжих бодит боломж бий болно.

Өнөөдөр санхүүгийн зах зээл дэвшилтэй технологи ашиглан цахим хэлбэрт шилжин орон зайд, цаг хугацаанаас үл хамааран дэлхийн зах зээлд оролцох бололцоо сайжирсаар байна. Энэ бүхэнтэй холбоотойгоор ойрын ирээдүйд Монгол Улсын хөрөнгийн зах зээл асар хурдтай хөгжинө гэсэн таамаглалыг гадаад, дотоодын мэргэжлийн шинжээчид дэвшүүлсэн байдаг.

1.1.2. Санхүүгийн зах зээл

Санхүүгийн зах зээл нь үнэт цаасны зах зээл, банкны зээлийн зах зээл гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Санхүүгийн зах зээлийн бүтцийг схемчлэн харуулья.



A. Мөнгөний зах зээл

Энэ зах зээлийн гол оролцогчид нь:

- Төв банк
- Арилжааны банкууд юм.

Төв банк (Монголбанк) нь төгрөгийн худалдан авах чадварыг хамгаалах, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах замаар төрийн мөнгөний бодлогыг тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлдэг институци юм.

Арилжааны банкууд нь санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлж, ашгийн төлөө ажилладаг. Өөрөөр хэлбэл, арилжааны банкууд харилцагчиддаа мөнгө зээлж, зээлийн хүүгээр нь орлого олдог. Зээлдэгчдээс авч байгаа зээлийн хүү, хадгаламж эзэмшигчдэд төлж буй хадгаламжийн хүүгийн зөрүү нь банкны үйл ажиллагааны зардлыг нөхөөд ашиг олох гол эх үүсвэр нь болдог. Иймд хадгаламжийн хүү нь зээлийн хүүгийн суурь болно. Зээлийн хүүг бууруулах үндэс нь хадгаламжийн хүү бага байх явдал юм.

Богино хугацаатай үнэт цаас арилжаалдаг банк хоорондын захыг мөнгөний зах зээл гэж нэрлэдэг. Мөнгөний зах зээлд ихэвчлэн Засгийн газар, Төв банк, арилжааны банкууд болон томоохон хөрөнгө оруулагч байгууллагууд оролцдог. Мөнгөний зах зээлд арилжаалагддаг үнэт цаас нь харьцангуй бага эрсдэлтэйд тооцогддог ба ихэвчлэн нэг жил хүртэл хугацаатай, хөрвөх чадвар сайтай байдаг ч бусад үнэт цаастай харьцуулахад хүү буюу өгөөж багатай байдаг (Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 8 -аас үзнэ үү.).

Хөгжингүй орнуудад хувь хүмүүс ихэвчлэн Засгийн газрын үнэт цаас худалдаж авах, эсвэл хамтын санд хөрөнгө оруулж, түүгээр дамжуулан мөнгөний зах зээлд оролцдог. Манай улсад мөнгөний зах зээл төдийлөн сайн хөгжөөгүй байгаа бөгөөд одоогоор иргэд энэхүү зах зээлд оролцох боломжгүй байна. Зөвхөн Монголбанк болон арилжааны банкууд мөнгөний зах зээлд арилжаа хийж байна. Цаашид санхүүгийн зах зээл хөгжсөнөөр иргэд мөнгөний зах зээлд оролцох боломж бий болох юм.

Б. Хөрөнгийн зах зээл

Монголчууд бид “хөрөнгийн зах зээл” болон “үнэт цаасны зах зээл” гэсэн нэр томьёог ижил утгатайгаар ойлгож, хэрэглэж хэвшсэн. Гэтэл үнэндээ хөрөнгийн зах зээл нь илүү өргөн утгатай бөгөөд үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой зуучлалын үйл ажиллагааг ч давхар агуулж байдаг ойлголт юм. Гэхдээ энэхүү номонд уламжлалыг даган, хөрөнгийн зах зээл гэсэн нэр томьёог явцуу утгаар нь буюу үнэт цаасны зах зээл гэдэг нэр томьёотой адилтган хэрэглэсэн болно.


Засгийн газар болон хувийн компаниуд тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, бизнесээ санхүүжүүлэх мөнгө олох зорилгоор үнэт цаас арилжаалдаг зах зээлийг хөрөнгийн зах зээл гэдэг. Хөрөнгийн зах зээл нь дотроо хувьцааны болон бонд (өрийн бичиг)-ын зах зээл гэж үндсэндээ хоёр хуваагдана. Түүнчлэн арилжаалагдаж буй бүтээгдэхүүний шинэ хуучин эсэхээс хамаарч Хөрөнгийн зах зээл нь

анхдагч болон хоёрдогч гэж ангилагдах нь бий. Анхдагч хөрөнгийн зах зээлд Засгийн газар эсвэл компани бонд болон хувьцаагаа анх удаа шинээр санал болгож, улмаар “босгосон” мөнгөөрөө үнэт цаас гаргасан төслөө санхүүжүүлдэг. Харин хоёрдогч зах зээлд хөрөнгө оруулагчид өмнө нь худалдан авсан үнэт цаасаа хоорондоо арилждаг. Өөрөөр хэлбэл, арилжаалагдаж буй бүтээгдэхүүн нь “хуучирсан” байдаг.

Монголын хөрөнгийн бирж дээр хоёрдогч зах зээлийн арилжаа анх 1995 онд эхэлсэн. Улмаар 2002 он хүртэл биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны хяналтын багцыг эзэмшиж, хяналтаа тогтоохыг эрмэлзсэн томоохон хөрөнгө оруулагчдын идэвхитэй үйл ажиллагааны улмаас үнэт цаасны арилжаа шуурхай явагдаж байв. Гэвч, цөөн хэдэн тоглогчийн гарг гол хувьцаа төвлөрсөн дараагийн жилүүдэд биржийн арилжааны эрч огцом саарсан байна. Харин гадаадын хөрөнгө оруулагчид Монголын зах зээлд идэвхитэй оролцох болсон 2005 оноос дахин өсч, 2007 онд хамгийн өндөр түвшиндээ хүрч байжээ. Дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын улмаас 2008 оноос хөрөнгийн зах зээлийн идэвхи эрс суларсан ба 2009 оны хоёрдуугаар хагасаас аажим сэргэх төлөв ажиглагдаж байна.

1.1.3. Иргэд хөрөнгийн зах зээлд хэрхэн оролцох вэ?

Иргэд, байгууллагууд хөрөнгийн буюу үнэт цаасны зах зээлд оролцохын тулд энэ зах зээлийн ажиллах өрөнхий механизмыг мэдэх хэрэгтэй. Үүнийг доорх зурагт харуулав.



Хөрөнгийн зах зээл дээр явагдах үйл ажиллагааг дараах хүснэгтэд дэлгэрүүлэн тайлбарлав.

| Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа | Оролцогч байгууллагын чиг үүрэг |
|---|--|
| 1. Иргэн Дорж брокерийн "АА" компанид өөрийн хувьцаагаа худалдах, иргэн Дулмаа брокерийн "ББ" компаниас хувьцаа худалдан авах захиалга өгнө. | Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. |
| 2. Брокерийн компаниуд иргэн Дорж, Дулмаа нарын захиалгын дагуу холбогдох мэдээллийг МХБирж, Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТТХТ)-д хүргүүлнэ. | Монголын хөрөнгийн бирж ХК нь хувьцаат компаниудын үнэт цаасыг тодорхой шалгуурын дагуу бүртгэн авч ангилал тогтоох, үнэт цаасны арилжааг ил тод, нээлттэй, шударга явуулж, олон нийтийг үнэт цаасны арилжааны мэдээ, мэдээллээр хангаж, хөрөнгө оруулагчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг. МХБ нь Засгийн газрын 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн шийдвэрээр байгуулагдсан. |
| 3. ҮЦТТХТ нь эдгээр иргэдийн дансанд буй үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн талаарх мэдээллийг МХБиржид өгнө. | Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн гэсэн үндсэн хоёр үйл ажиллагааг дагнан эрхэлдэг бөгөөд Засгийн газрын болон компанийи бонд, хувьцааны төлбөр тооцоог бэлэн, бэлэн бусаар гүйцэтгэдэг. Харин тус байгууллагын хадгаламжийн үйл ажиллагаанд үнэт цаасыг гэрээний үндсэн дээр төвлөрсөн хадгаламжид хадгалан, үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх, төвлөрсөн хадгаламжид данс нээх, хаах, өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах болон үүргийн гүйцэтгэл хангуулахтай холбогдсон үйлчилгээг хамаарч байна. |
| 4. МХБирж нь үнэт цаасны арилжаа явуулж, мэдээллийг ҮЦТТХТ-д өгнө. Худалдан авахад хамгийн бага үнэтэй болон худалдахад хамгийн их үнэтэй захиалгыг, үнэ ижил бол түрүүлж өгсөн захиалгыг биелүүлэх зарчмаар брокер бүр өөрийн харилцагчийн эрх ашгийн төлөө арилжаанд оролцно. | Брокер, диллерийн компани нь үнэт цаасны зах зээл дэх арилжааны үнэ ханшийн талаар мэдээлэл өгөх, тухайн өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг худалдах болон худалдан авах захиалга авч биелүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг. |
| 5. ҮЦТТХТ-өөс иргэн Дорж, Дулмаа нарын дансны мэдээллийг холбогдох брокерийн компаниудад хүргүүлнэ. | |
| 6. Иргэн Дорж өөрийн дансанд орсон мөнгө, Дулмаа өөрийн дансанд байршсан үнэт цаасны мэдээллийг брокерийн компаниасаа авна. | |

Мэдээллийн технологийн хөгжил нь иргэдэд санхүүгийн үйлчилгээг илүү хялбар, хямд, хурдан хүртэх нөхцөл бүрдүүлж байна. Интернетээр үнэт цаасны арилжаанд оролцох боломжийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэ номын Хавсралт 14-өөс уншина уу.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр 2010 оны эхний байдлаар хөрөнгийн бирж 1, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага 1, брокер, диллер, андеррайтерийн 49 компани Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Нийт 353 хувьцаат компаний үнэт цаас бүртгэлтэй байгаа боловч үйл ажиллагаа нь зогсоод гурваас дээш жил болсон 160 гаруй компани байна. Эдгээр компаний хувьцааг хөрөнгө оруулагчид худалдан авч хохирохоос сэргийлж Санхүүгийн зохицуулах хороо арилжаанд оролцохыг нь зогсоосон. Иймд 2010 оны эхний байдлаар бирж дээр 200 орчим компаний үнэт цаас бүртгэгдэн арилжаалагдаж байна. Энэ талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Та энэ номын Хавсралт-2, Санхүүгийн зохицуулах хорооны вэб сайт (www.frc.mn) болон Монголын хөрөнгийн биржийн (www.mse.mn) вэб сайтаар орж үзнэ үү.

Хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” (ҮЦТТТХТ) ХХК-д 2009 оны 12 сарын 1-ний байдлаар нийт 443,761 хувьцаа эзэмшигч бүртгэгдсэн байгаагаас:

- дансаа нээлгэсэн 328,133
- дансаа нээлгээгүй 115,628 хувьцаа эзэмшигч байна.

Дансаа нээлгээгүй хувьцаа эзэмшигчид нь үнэт цаасны арилжаанд оролцох, ногдол ашгаа авах боломжгүй байгаа гэсэн үг юм.

Зөвлөмж. Та дансаа нээлгээгүй бол иргэний үнэмлэх, даалгаврын гэрээ зэрэг бичиг баримтаа аваад ҮЦТТТХТ (Сухбаатарын талбайн баруун талд, Хөрөнгийн Биржийн 2-р давхарт)-д өөрөө очих юмуу аль нэг брокерийн компанийд хандан дансаа нээлгээрэй. Та “даалгаврын гэрээ зэрэг үнэт цаас эзэмшсэн тухай ямар ч баримт байхгүй болохоор миний хувьцаа ч өнгөрсөн байх” гэж бодож магадгүй. Анхдагч зах зээлд оролцон хувьцаа эзэмшсэн хүн бурийн бүртгэл (овог, нэр, регистрийн дугаар гэх мэт) ҮЦТТТХТ-д хадгалагдаж байдаг учраас Та иргэний үнэмлэхээ авч очоод шалгуулж, дансаа нээлгэн арилжаанд оролцох эрх байгаа гэдгийг анхаараарай.

Өмч хувьчлалаар хувьцаа авсан ч арилжаанд оролцохгүй байгаа нь Танд хохиролтой төдийгүй хувьцааны арилжаанд сэргөөр нөлөөлж, хөрөнгийн зах зээлийн жам ёсны хөгжилд саад болно. Хуульд

зааснаар иргэн өөрийн өмчлөлийн зүйлийг арчилж, хамгаалах бүхий л зардлыг хариуцаж, эрсдлээ хүлээх ёстой. Нөгөө талаас эргэлтэд ороогүй, идэвхигүй хувьцааны ханш унаж үнэгүйдсээр байдаг. Ийм хувьцааны тухайд төрөөс шийдвэр гаргаж, зах зээлийн эргэлтэд оруулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж мэргэжилтнүүд үздэг. Иймд Та эзэмшсэн хувьцааныхаа үр шимийг хүртэх санаачлага гаргах уу, төр Таны өмнөөс шийдвэр гаргахыг хүлээсээр байх уу гэдэг сонголт үлдээд байна.

1.1.4. Хөрөнгийн зах зээлд оролцогч иргэд, хөрөнгө оруулагчдыг төрөөс хэрхэн хамгаалдаг вэ?

Хөрөнгийн зах зээлийн гол оролцогчид болох үнэт цаас гаргагч компани, зах зээлийн мэргэжилтнүүдийн хууль бус үйлдлээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор төрөөс хяналт, зохицуулалт хийдэг. Манай улсын хувьд энэхүү төрийн зохицуулагч байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо юм.

Зах зээлийн үйл ажиллагааг ил тод, шударга явуулах үүднээс төрөөс хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомж гаргадаг. Манай улсад одоогоор:

- Үнэт цаасны зах зээлийн тухай
- Компаний тухай
- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай зэрэг хуулийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа явагдаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос эдгээр хууль, тогтоомжид нийцүүлэн нарийвчилсан журмууд гаргаж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Тиймээс иргэн Та үнэт цаас, хөрөнгө оруулалттай холбоотой аливаа хууль бус үйлдлийн улмаас хохирсон бол өргөдөл, гомдлоо Санхүүгийн зохицуулах хороонд гаргах хэрэгтэй. Энэ Хорооны өөр чиг үүрэг нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах явдал байдаг (Хавсралт 10-аас хөрөнгийн зах зээл дээр түгээмэл тохиолддог жишээн дээр хөрөнгө оруулагч эрхээ хэрхэн хамгаалуулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү).

Хөрөнгийн бирж нь өөрийн гишүүд болон бүртгэлтэй компанийхаа үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам баталж мөрдүүлдэг. Эдгээр дүрэм, журам нь хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцаа, бондоо худалдаж байгаа компани болон арилжаанд оролцогч брокер диллерийн компаниуд хуулийн хүрээнд шударгаар ажиллах эрх зүйн

зохицуулалтын нэг хэсэг болдог. Түүнчлэн олон нийтээс санхүүжилт авах зорилгоор хувьцаа эсвэл бонд гаргах компани нь холбогдох хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс гаргасан дүрэм, журмын тодорхой нөхцөл, болзлыг хангасан байх ёстой. Эдгээр нөхцөл, шаардлага нь нийтэд зориулан гаргаж байгаа үнэт цаасны найдвартай, эрсдэл багатай байх нөхцлийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчид болон иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байдаг.

1.1.5. Санхүүгийн зах зээлд оролцогч –хувь хүний хариуцлага

Санхүүгийн зах зээлд хариуцлагатай, ухаалаг оролцогч болохын тулд дараах зөвлөмжийг сайтар тунгааж, үйл ажиллагаандaa хэвшүүлбэл зүйтэй.

Мөнгөө зарцуулах төлөвлөгөө гаргах. Өрхийн зарлагаа төлөвлөх өөрөөр хэлбэл, өрхийн төсвөө зохиох хэрэгтэй. Энэ нь хэцүү ярвигтай зүйл биш бөгөөд олох орлого, гарах зардлаа л нэг бүрчлэн бичих үйл ажиллагаа юм. Төлөвлөгөө бичсэнээр Таны хариуцлага дээшилж, ашиг авчрах эхний алхам болно.

Мөнгөө хэмнэх, хуримтлуулахад цаг зав гаргах. Аливаа зүйлд хариуцлагатай ханддаг хүн ирээдүйд ямарваа мөнгө, төгрөгний яаралтай хэрэгцээ гарахад бэлтгэлтэй, тодорхой хэмжээний мөнгө хадгалж байх нь чухал гэдгийг мэддэг. Хуримтлал гэдэг нь энгийнээр ойлгоход олсон орлогоосоо бага зарцуулахыг хэлнэ. Энэ нь боломжгүй зүйл мэт санагдаж болох ч тохиолдлоор өвдөх, гэнэт мөнгөний хэрэгцээ гарах үед мөнгө хадгалах, хуримтлуулахын ач холбогдол ойлгогдоно. Мэдээж илүү их ажил хийх, чухал шаардлагагүй зүйлд мөнгө үрэхгүй байх нь хуримтлалтай болох хамгийн энгийн бөгөөд хурдан арга зам мөн.

“Хэрэгцээ”, “хүсэл” хоёроо ялгах. Зайлшгүй хэрэгцээтэй зүйлдээ л мөнгө зарцуулж, бусад түр зуурын сонирхол татсан боловч чухал биш зүйлээсээ хэсэг хугацаанд татгалзах нь зүйтэй. Жишээ нь, Та тамхинаас гарлаа гэхэд тэгтлээ муу юм болохгүй ба түүнийг хэрэглэхгүйгээр амьдарсаар л байх болно. Харин ч эрүүл мэндэд тус болохоос гадна тамхинд зарцуулж байсан мөнгөө шууд хуримтлал болгон хадгалбал илүү сэтгэл хангалиун явах болно. Энэ нь хэн бүхний мэддэг энгийн зүйл боловч амьдрал дээр хүн бүр хэрэгжүүлдэггүй, харин хэрэгжүүлсэн хүн үр ашгийг нь хүртдэг билээ.

Мөнгө зээлэхээс аль болох татгалзах. Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх, орон сууцандаа засвар хийх, эсвэл бүр өдөр тутмын хэрэгцээндээ шаардагдах мөнгийг банкнаас, эсвэл хэн нэгнээс хүүтэй зээлэх санаа Танд төрж болно. Эхний удаа зээл авч болох боловч дараагийн удаад дахиад л зээлэх шаардлага гарна. Зээлсэн л бол хүү төлнө. Мөн ямар нэг гэнэтийн зүйл тохиолдож зээлээ хугацаандаа төлж чадахгүйд хүрвэл нэмж торгууль төлнө гэх мэт элдэв эрсдэл учрах магадлалтай. Тиймээс зээл авахын оронд онцын шаардлагагүй зардлаа эртнээс багасгах хэрэгтэй. Жишээ нь, байр сууцаа засахдаа зээл авахын оронд бага багаар засварын ажлаа өөрөө хийж болно. Товчдоо, ирээдүйд ашиг авчрах зүйлээс бусад тохиолдол буюу хэрэглээний зээлээс татгалзсан нь дээр.

Өөртөө л найдах. Зарим тохиолдолд гэр бүлийн гишүүд, найз нөхдөөсөө мөнгөн бэлэг авах таатай боловч тэднээс үргэлж тусламж, бэлэг ирнэ гэж дэмий хүлээж цаг алдах хэрэггүй, зөвхөн өөртөө л найд.

Аливаа гэрээнд гарын үсэг зурахдаа туйлын хариуцлагатай хандах. Аливаа гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурахын өмнө уг гэрээ, хэлэлцээр нь тухайн үед хүчинтэй байгаа хууль, дүрэмтэй нийцэж буй эсэхийг нягтлан шалгаж байх хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд бусдаас зөвлөгөө авч болно. Жишээ нь, банктай зээл болон хадгаламжийн гэрээ байгуулах, брокерийн пүүсээ сонгох, даатгалын гэрээнд гарын үсэг зурах үед иргэд өөрсдийн хайхрамжгүй байдлаас болж хожим нь сөрөг үр дагаварт хүрэх заалт, хэлцлийг анзаарагч гүйцэтгэх тохиолдол байдаг. Түүнчлэн бэлэн маягт, өргөдөл, гэрээний загвар нь тухайн байгууллагын эрх ашгийн үүднээс бэлтгэгдсэн байх магадлалтайг санаж байх нь чухал. Гэрээний нөхцлийг санхүүгийн байгууллагын ажилтны аман тайлбартай харьцуулж үзэхэд илүүдэхгүй. Дүгнэж хэлэхэд:

- Гарын үсэг зурахын өмнө гэрээгээ заавал гүйцэд уншиж ойлгосон байх
- Үйл ажиллагаатай холбогдсон хууль, журам болон үйлчилгээ нь Таны эрх ашигт нийцэж буй эсэхэд дүгнэлт хийх
- Шаардлагатай бол уг баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа илэрхийлж тусгуулах зэргээр санхүүгийн зах зээлд оролцогч--хувь хүний үүрэг, хариуцлагаа ойлгож мэдэх нь чухал.

1.2. Хувийн санхүүгээ төлөвлөх

1.2.1. Төлөвлөлтийн ач холбогдол

Орлого, зарлагаа зөв удирдаж тодорхой хэмжээний хуримтлал бий болгоход хувийн санхүүгээ төлөвлөх нь юу юунаас чухал. Үүнийг дараах энгийн жишээн дээр тайлбарлай.

Таныг төсвийн байгууллагад ажилладаг 25 настай, сарын 400,000 төгрөгийн цалинтай гэж бодъё. Хуулийн дагуу Та цалингийнхаа 10 хувийг хувь хүний орлогын албан татварт төлнө. Дээр нь нийгмийн даатгал болон өөр хэд хэдэн төрлийн шимтгэл бас төлнө. Эдгээрийг таны цалингаас шууд суутгаад авна. Энэ бүхнийг төлөөд Таны гар дээрээ бэлнээр авах мөнгө 350,000 төгрөг болно гэж төсөөлье. Та энэ мөнгийг юунд зориулах вэ.

Мэдээж таны өдөр тутмын хэрэглээнд зардал гарна. Ихэнх Монголчуудын өдөр тутмын хэрэглээ ялгаа багатай байдаг. Таныг гэрлээгүй, ганцаар амьдардаг гэж үзвэл наад зах нь дараах зардлууд гарна.

| Зардлын төрөл | Сарын зардал /төгрөгөөр/ |
|---|--------------------------|
| Байрны түрээс | 100,000 |
| Ус, цахилгааны төлбөр | 10,000 |
| Гар утасны төлбөр | 20,000 |
| Зурагт, кабелийн хураамж | 5,000 |
| Ажилдаа явах, ирэх зардал ойролцоогоор | 30,000 |
| Хувцас худалдан авахад | 20,000 |
| Хоол, унд үзвэр үйлчилгээ гэх мэт бусад зүйлд | 165,000 |
| Нийт зардал | 350,000 |

Хэрэв нийт зарлага дунджаар иймэрхүү гэвэл сарын орлого, зарлага чинь тэнцүү байх нь. Гэтэл хэрэг дээрээ үүнээс гадна олон зүйлд мөнгө зarah хэрэгцээ гардаг. Жишээ нь:

- Найз нөхөд, хамаатан садан өвдөх, нас барахад тодорхой хэмжээний мөнгөн тусламж өгөх хэрэгтэй болно. Өөрөө өвдөхийг ч үгүйсгэх аргагүй.
- Зурагт, тавилга гэх мэт шинээр эд зүйлс худалдаж авах хэрэгцээ, шаардлага ч бий болж мэднэ.

- Аав, ээж, ах дүү, найз нөхдийн төрсөн өдөр болон баяраар бэлэг авч өгөх эсвэл ресторанд урьж баярлуулах зэрэг хүсэл, мөрөөдөл ч төрж болно.

Энэ үед Та хэн нэгнээс зээл аваад хүссэнээ биелүүллээ гэхэд дараа нь өртэй үлдэнэ. Буцааж төлөхгүй л бол өр өөрөө хорогдохгүй, харин ч хүү торгууль гээд өсч байдаг. Тиймээс хэрэглээний зарлагаа зээлээр нөхөхөд өр л нэмэгдэнэ. Өр нэмэгдэх тусам асуудал улам л хүндэрнэ.

Дээрх тохиолдолд хуримтлал, хадгаламж, эсвэл тэтгэврийн талаар яриагүй байгаа билээ. Өөрөөр хэлбэл, Танд одоогоор санхүүгийн ямар нэг зорилго байхгүй. Ямар нэг санхүүгийн эрсдлээс өөрийгөө хамгаалах арга замаа ч бодож төлөвлөөгүй байгаа. Яг иймэрхүү дүр зураг бидний олонхид байгаа. Түүнчлэн өнөөдөр 30, 40 настай хувиараа хөдөлмөр эрхэлдэг, эсвэл гадаадад хууль бусаар амьдарч байгаа олон хүмүүс нийгмийн даатгалгүй явж байна. Тэд нийгмийн даатгалд хамрагдаагүй учраас тэтгэврийн насанд хүрч, орлого олох чадваргүй болсон үедээ ямар нэг тэтгэврийн орлогогүй болох эрсдэлтэй. Мөн тэтгэвэр авдаг ч тэр нь амьдралын наад захын хэрэгцээг дөнгөж хангахуйц, эсвэл ерөөс хүрэлцэхгүй байдаг. Залуу насандаа ирээдүйн санхүүгийн талаар төдийлөн санаа тавилгүй, болж бүтнэ гэсэн өөдрөг боловч бодитой бус байдлаар асуудалд хандаж байснаас тэтгэврийн насны хүмүүс ийм хүндхэн амьдралыг туулах нь бий. Тиймээс хүн бүр аль болох залуу наснаасаа эхлэн ирээдүйн амьдралдаа санаа тавьж, гавьяаны амралтаа эдлэх үедээ хөрөнгө, санхүүгийн хувьд санаа зовох зүйлгүй хэрхэн амьдрах талаар бодох нь чухал.

Та хувийн санхүүгээ төлөвлөснөөр:

- Мөнгө олох, түүнийгээ зөв ашиглах, хадгалах, өсгөж арвижуулах талаар илүү ухаалаг шийдвэр гаргаж сурна.
- Санхүүгийн байдлаа бодитойгоор хянах бололцоотой болж санхүүгийн ямар нэг эрсдэл учирахаас сэргийлнэ. Санхүүгийн хувьд бусдаас хараат байдлаа багасгаж түүнээс ангижирахад тус дөхөм болно.
- Ирээдүйдээ итгэлтэй, өөдрөг, сэтгэл зовохгүй амьдрах болно.

1.2.2. Төлөвлөх, хэрэгжүүлэх үе шат

Хувийн санхүүг дараах үе шаттайгаар төлөвлөж, хэрэгжүүлнэ.

1. Одоогийн нөхцөл байдлаа үнэлэх. Хувь хүн, эсвэл өрх гэр орлого, зарлагын тайлан гаргаж санхүүгийн өнөөгийн нөхцөл байдлаа үнэлэх нь чухал. Балансыг хоёр баганатай хүснэгтээр гаргаж болно. Нэг баганад бэлэн мөнгө, хувцас, үнэт эдлэл, бусад эд хогшил, үл хөдлөх хөрөнгө тус бурийн мөнгөн дүн, нөгөө баганад өр төлбөр, бусдын өмнө хүлээсэн үүргийн мөнгөн дүнг харуулна. Харин орлого зарлагын тайланг долоо хоногоор, сараар, эсвэл жилийн орлого, зарлагаа нэг бүрчлэн бичиж хүснэгтээр гаргана. Энэ хоёр хүснэгтээс Та юуны өмнө зардлаа хэрхэн багасгах талаар эхний дүгнэлт хийж болно. Цаашлаад ирээдүйд олох орлогоо нэмэгдүүлэх боломжийг аль болох бодитой тооцоолж харах нь чухал.

2. Зорилгоо тодорхойлох. Юуны өмнө өөрийн хуримтлал хийх хэрэгцээ, шаардлагaa сайтар бодож тунгаах хэрэгтэй. Тухайлбал, Та ирэх 5 жилд ямар хэмжээний мөнгө хуримтлуулах хүсэлтэй байна вэ? Ирэх 30 жилд өөртөө ямар амлалт өгөх вэ? гэдгийг өөрөөсөө асууж хариулт ав. Тэгээд санхүү, мөнгөний талаар тодорхой зорилго тавина. Жишээ нь, “би 60 нас хүрч тэтгэвэрт гарах үедээ 50 сая төгрөгийн хадгаламжтай болно”, эсвэл “З жилийн дотор өөрийн унаатай болно” гэх мэт. Насанд хүрсэн ихэнх хүмүүст хүүхдийнхээ цэцэрлэг, сургууль, их дээд сургуулийн төлбөрийн мөнгийг хуримтлуулах, эсвэл их, дээд сургуулийн төлбөрт Төрийн сангаас авсан зээлээ төлөх, машин авах, орон байртай болох зэрэг нь санхүүгийн нийтлэг зорилго болдог. Та хэд хэдэн зорилго зэрэг тавьж ч болно. Эдгээр нь урт, богино хугацааны зорилт байж болно. Зорилгоо тодорхойлсноор Та санхүүгийн төлөвлөгөөгээ гаргах боломжтой болно. Санхүүгийн зорилго тодорхойлох загвар хүснэгтийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

3. Санхүүгийн төлөвлөгөө зохиох. Төлөвлөгөө нь санхүүгийн зорилгоо хэдийд, хэрхэн, ямар арга замаар хэрэгжүүлэхийг тодорхойлсон баримт юм. Жишээ нь, чухал шаардлагагүй зүйлд мөнгөө үрэхгүй байх, орлогоо нэмэгдүүлэх талаар хэдийд, юуг, хэрхэн хийх, мөнгөн хуримтлалтай болсон үедээ ямар хөрөнгө оруулалт хэзээ, хэрхэн хийх гэх мэтээр төлөвлөгөө зохионо. Уг төлөвлөгөө нь хэрэгжих боломжтой, бодит байдлаараа хүсэл мөрөөдлийн жагсаалтаас ялгагдана.

4. Хэрэгжүүлэх, хянах. Санхүүгийн төлөвлөгөөгээ хэрэгжүүлэх эсэх нь хувь хүний сахилга, хариуцлагаас ихээхэн шалтгаална. Өөрөөр хэлбэл, төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхэд хүчин чармайлт

гаргаж, замын дундаас ухарч няцахгүй, тууштай байх чадвар Танд зайлшгүй хэрэгтэй. Санхүүгийн төлөвлөгөөний биелэлтдээ хяналт тавьж ажиллах нь бизнесийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжихийн үндэс болдог. Ийм учраас бодит судалгаанд тулгуурласан, хэрэгжих боломжтой санхүүгийн төлөвлөгөөтэй байх нь Таны хувийн санхүүгийн төлөвлөгөө амжилттай хэрэгжих үндэс болно.

5. *Санхүүгийн төлөвлөгөөний биелэлтээ явцын дунд хянах, залруулах*. Цаг хугацааны явцад урьдчилж тооцоогүй, Танаас хамаарахгүй гэнэтийн явдлууд гарч төлөвлөгөөг өөрчлөхөд хүргэж болох юм. Энэ үед анхны төлөвлөгөөгөө өөрчлөх, залруулах шаардлага гарна. Нэгэнт сайн боловсруулж бичигдсэн санхүүгийн төлөвлөгөөтэй байх нь биелэх магадлал өндөр бөгөөд бичигдээгүй төлөвлөгөө биелдэггүй гэдгийг санах нь зүйтэй.

1.2.3. Орлогын эх үүсвэр бүрдүүлэх

Бизнесээ амжилттай эрхэлж яваа хүмүүс болон өөрийн шургуу хөдөлмөр, ухаан, авьяас чадлаараа баяжсан хүмүүсийн туулж өнгөрүүлсэн амьдралын туршлага, алдаа оноон дээр үндэслэн эдийн засагчид орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд дараах ерөнхий зөвлөмжийг гаргасан байдаг. Үүнд:

1. *Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хуулийг өөрийн давуу тал болгон ашиглах*. Аль ч зах зээлд аливаа бараа, үйлчилгээ элбэг дэлбэг буюу нийлүүлэлт их байвал түүний үнэ хямдарч эсрэгээрээ ховор хомс бараа, үйлчилгээний үнэ өндөр байдаг. Бараа, үйлчилгээний хангамж, нийлүүлэлт ихсэх, багасах, түүний үнэ өсөх, буурахад маш олон хүчин зүйл нөлөөлдөг. Харамсалтай нь, бид амьдралдаа ялангуяа ажил, хөдөлмөр эрхлэхдээ зах зээлийн энэхүү эрэлт, нийлүүлэлтийн хуулийг тэр бүр ашигладаггүй. Жишээ нь, эргэн тойрондоо байгаа олон хүмүүсийн хийж байгаа зүйлтэй адилхан бизнес эрхлэх сонирхолтой байгаа бол ахиухан мөнгө олох, орлогоо нэмэгдүүлэх зорилго тань улам л хүндэрнэ. Нөгөө талаас, ихэнх хүмүүсийн эрхлэхийг хүсдэггүй ажил, үйлчилгээг Та хийвэл ахиухан мөнгө олох боломж гарч болох юм. Үүнээс гадна Танд ямар нэг зүйл хийх онцгой авьяас байгаа бол түүнийгээ хөгжүүлж, ажил хэрэг болгон орлогоо нэмэгдүүлж болно. Яагаад гэвэл тэрхүү бүтээгдэхүүн болон үйлчилгээ ховор бөгөөд нийлүүлэлт нь бага учир зах зээл дээр тухайн зүйлийн эрэлт болон үнэ нь өндөр байдаг.

2. *Өнгөрч байгаа цаг минут бүр мөнгө гэдгийг сайтар ойлгох*. Цаг, хугацааг үр бүтээлтэй ашиглах нь мөнгө олох ур чадварын үндэс

гэж хэлж болно. Ямар ажил хийдэг, хэн бэ гэдгээсээ үл хамааран ихэнх цагаа ямар зүйлд зарцуулж байгаагаа үргэлж бодож, хянаж байх нь чухал. “Би юу хийхэд илүү мөнгө олж байна, ямар зүйлд цагаа дэмий үрж байна” хэмээн өөрөөсөө үргэлж асуу. Ердөө л ахиу орлого олж байгаа зүйлдээ илүү их цаг зарцуулж, дэмий өнгөрүүлж буй цагаа багасгавал Та орлогоо нэмэгдүүлнэ гэсэн энгийн зарчим баримталж сурх хэрэгтэй. Цаг хугацаа хязгаартай гэдгийг үргэлж санаж байгаарай.

3. *Өөрийн үнэлэмж, үнэ цэнээ дээшлүүлэх*. Та эрэлт хэрэгцээтэй ховор бараа үйлдвэрлэдэг, эсхүл чухал үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ихээхэн ур чадвар шаардсан ажил хийдэг бол бусдаас илүү орлого олдог байх учиртай. Харамсалтай нь ихэнх хүмүүс тэрхүү ховор ур чадвараа үнэлж мэддэггүй, эсвэл бусдад илэрхийлж чаддагүйгээс илүү их орлого олох боломжоо алддаг. Ийм тохиолдолд Та ямар нэг компанид ажилладаг бол цалин хөлсөө нэмэгдүүлэхийг шаардах хэрэгтэй. Харин хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол бараа, үйлчилгээнийхээ үнийг зохих түвшинд хүртэл нэмэгдүүлж болохгүй нь юу билээ.

4. *Хянуур, хашир байх*. Аливаа бизнес хийхдээ аль болох олон удаа тунгаан бодож, буруу зүйл хийх, алдаа гарч болзошгүй зүйлийг урьдчилан тооцоолохыг хичээх хэрэгтэй. Аз болон тохиолдлын зүйлд бүү найд. Ямар ч үед эрсдэл гарч болохыг тооцоолж, түүнд бэлтгэлтэй байх хэрэгтэй. Жишээ нь, бизнес төлөвлөгөө боловсруулахдаа бизнес хийхд гарах бүх зардлаа тооцож үз. Түүн дээрээ урьдчилж тооцоогүй, гарч магадгүй гэнэтийн зардлыг төлөвлөж оруулах хэрэгтэй.

5. *Хөрөнгө, орлого хоёрыг ялгах нь чухал*. Саятнуудын туршлагаас үзвэл тэдний ихэнх нь даруухан амьдардаг байна. Тэд том компаний захидал, эсвэл барууны хөгжсөн орны орлого ихтэй мэргэжилтэн буюу эмч, хуульчид шиг хувийн том байшин, үнэтэй тансаг машин худалдаж авдаггүй. Харин хэрэглээнээс илүү гарсан орлогоо ирээдүйд ашиг авчрах бизнест л хөрөнгө оруулдаг. Өөрөөр хэлбэл, эргээд ихээхэн урсгал зардал шаарддаг том байшин, эсвэл бензин их хэрэглэдэг тансаг машин худалдан авахаас татгалздаг. Эндээс харахад их орлоготой л бол их баялаг, хөрөнгө эзэмшинэ гэсэн үг биш юм. Тодорхой хугацаанд их ашиг олоод түүнийгээ үр ашиггүй зарчихалгүй ирээдүйд орлого олох зүйлд хөрөнгө оруулах нь эргээд орлогыг тань нэмэгдүүлэх эх сурвалж болно гэдгийг анхаараарай.

1.2.4. Хуримтлал бий болгох

Мөнгө хуримтлуулна гэдэг хэлэхэд амархан боловч хийхэд амаргүй зүйл. Хэр их хэмжээний мөнгө хуримтлуулах, хаана хадгалах, эсвэл юунд оруулах, хадгалсан, оруулсан газар нь хэр найдвартай, бас ашигтай байх гэх мэт олон асуудал гарч ирнэ. Хуримтлалтай болохын тулд зөвхөн зардлаа багасгах нь хангалтгүй. Мөнгө хуримтлуулж, хадгалахад хэрэг болохуйц дараах зөвлөмжийг толилуулъя.

1. *Хуримтлалтай болоход тодорхой зорилго тавьж байж амжилтанд хүрнэ.* Хүн зорилгогүйгээр мөнгө хуримтлуулна гэж байхгүй ч зорилго нь маш тодорхой, хэмжиж болохуйц, цаг хугацаатай байх учиртай. Зурагт, хөргөгч, эсвэл машин худалдаж авахын тулд мөнгөө хуримтлуулна гэвэл энэ нь ойрын зорилго болно. Иймэрхүү ойрын зорилгыг хэрэгжүүлэхэд харьцангуй хялбар байж болох юм. Харин тэтгэвэрт гарсны дараа гачигдаж дутагдахгүй боломжийн хэмжээнд амьдрахын тулд хэрхэн хуримтлалтай болох вэ гэвэл илүү нарийн тооцоо, судалгаа шаардсан урт хугацааны зорилго болно.

2. *Тодорхой хугацаа товлох хэрэгтэй.* Зорьсон зорилгодоо хүрэх хугацааг зөв тооцоолох нь чухал. “Хоёр жилийн дотор машин худалдаж авна” гэх мэт тодорхой хугацаанд хүрэх хатуу зорилго тавьж болох юм. Мэдээж хэрэг огт боломжгүй зүйлийг зорилгоо болгох нь утгагүй. Харин тавьсан зорилгодоо хүрэх боломжит хугацааг бодитой товлох хэрэгтэй.

3. *Долоо хоногт эсвэл сард хэдий хэмжээний мөнгө хуримтлуулахаа тооцож үз.* Тооцоолсон хуримтлалаа долоо хоног, сар бүр ягштал баримтлан хурааж сурах нь чухал. Долоо хоногт, эсвэл сард 20,000 төгрөг гэх мэт тогтмол хэмжээний мөнгө хуримтлуулах зорилго тавих нь илүү үр дүнтэй байдаг байна.

4. *Сар бүрийн зардлаа тооцож, бүртгэл буюу тэмдэглэл хөтөлж сур.* Мэдээж хэрэг сард хэдий хэмжээний мөнгө хадгалж чадах вэ гэдэг нь тухайн хүний сарын орлого, зарлагын зөрүүгээр илэрхийлэгдэнэ. Та олох орлогоосоо илүү гарах зарлагаа сайн хянаж, удирдах боломжтой тул гарч буй зардалдаа илүү анхаарал хандуулах нь зөв. Долоо хоног бүр үрсэн мөнгө, гаргасан зардлаа нэг бүрчлэн бичиж хэвших хэрэгтэй. Гаргасан зардлаа Та сарын дараа, эсвэл хоёр сарын дараа эргэж хараад гайхаж ч мэднэ. Жишээ нь, нэг сард сугалаа худалдаж авахад 20,000 төгрөг, эсвэл гар утасны төлбөрт 100,000 төгрөг зарцуулсан байж ч мэдэх юм. Иймээс бүх зардлаа бичиж чадвал тэндээс ямар зардлаа багасгаж, хэмнэж болохоо хялбархан харж болно.

5. Банкинд хүүтэй хадгаламжийн данс нээх. Мэдээж хэрэг харилцах дансанд мөнгөө байрлуулснаас хадгаламжийн дансанд хийх нь ашигтай. Заавал сарын эцэст мөнгөө хадгалуулах гэж хүлээндийн хэрэггүй. Хуримтлал хийх боломж гарах бүрт мөнгөө хадгаламжид хийх хэрэгтэй. Ингэснээр Та илүү зүйлд мөнгө үрэхгүй, харин ч хадгаламжийн хүү нь нэг өдрөөр ч гэсэн өсөх болно. Ажил хийдэг олон хүмүүс цалингаасаа тодорхой хэмжээний мөнгийг шууд хадгаламжийн данс уруугаа шилжүүлэхийг зөвшөөрдөг. Энэ бол мөнгө хуримтлуулах үр дүнтэй аргуудын нэг мөн.

6. Хуримтлал хийхэд ашиг тустай бусад зөвлөгөө. Урьдчилж тооцоогүй орлогыг шууд хадгалах нь дээр. Жишээ нь, хэн нэгнээс бэлгэнд авсан мөнгө, эсвэл ажлын газрын мөнгөн шагнал гэх мэт. Мөн томилолтоор ажиллаад ирэхэд тодорхой хэмжээний хэмнэлт гарах нь түгээмэл байдаг. Нэгэнт зорилго тавьсан бол энэ мэт урьдчилж тооцоогүй мөнгийг хадгаламжиндаа хийх болно. Ингэснээр Та хуримтлалын зорилгоо илүү хурдан хугацаанд биелүүлнэ.

1.2.5. Хөрөнгө оруулалт хийх

Энгийнээр хэлэхэд, хөрөнгө оруулалт гэдэг нь мөнгөө өсгөж арилжуулах зүйлд байршуулна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өөрт байгаа мөнгийг өөрийнхөө төлөө ажиллуулахыг хэлдэг. Хөрөнгө оруулалт хийх маш олон арга, хэлбэр байдаг. Тухайлбал, хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, эсвэл хувийн бизнесээ эхлүүлэх нь хөрөнгө оруулалтын жишээ болно. Түүнчлэн өөрөө амьдрах болон түрээслүүлж ашиг олохоор сууц худалдаж авах нь өнгөц харахад ижилхэн үйлдэл боловч хоёрдахь нь ашиг олох зорилготой үйл ажиллагаа буюу хөрөнгө оруулалт юм. Хөрөнгө оруулалтын үндсэн зорилго нь мөнгөө өсгөх явдал. Энэ талаар дараагийн бүлэгт илүү дэлгэрэнгүй тайлбарлах болно.

1 ДҮГЭЭР БҮЛЭГ. МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ АСУУЛТУУД

Эхний бүлгээс уншиж судалсан санхүүгийн болон хөрөнгийн зах зээл, хөрөнгийн биржийн тухай мөн хувийн санхүүгийн төлөвлөгөө зохиож хэрэгжүүлэх нь хувь хүнд ямар ач холбогдолтой болохыг Та дараах асуултын хүрээнд эргэн санаж бататгана уу.

1. Таны ойрын таван жилийн санхүүгийн зорилго юу вэ?
/Байртай болох, машин авах, гадаадад сурах, хүүхдээ их дээд сургуульд сургах г.м/ Зорилгоо биелүүлэх талаар хувийн санхүүгийн төлөвлөгөө бий юу?
2. Та өртэй юу? Хэрэв тийм бол юунд зориулж мөнгө зээлсэн бэ? Мөнгө зээлэхээс өөрөөр тухайн асуудлыг шийдэх арга байсан ўу?
3. Найз чинь машин худалдаж авчээ. Энэ нь хөрөнгө оруулалт мөн ўу?
4. Нарantuул болон Эмээлт зэрэг бараа, түүхий эд зардаг захаас Хөрөнгийн биржийн ялгарах гол онцлог юу вэ?
5. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд хувь хүн оролцож болох ўу? Хэрэв тийм бол яаж, ямар зорилгоор оролцож болох вэ?

II БҮЛЭГ.

Та орлого олсон бол...

Энэ сэдвийг судалснаар Та:

- Орлогоо хэрхэн зохистой удирдах талаар мэдэх болно.
- Банк, Хадгаламж зээлийн хоршооны бүтээгдэхүүний гашиглан хуримтлал үүсгэх боломж, ач холбогдлыг ойлгоно.
- Хадгаламжийг хөрөнгө оруулалтын бусад хэлбэртэй харьцуулах чадвартай болно.
- Үнэт цаасанд хөрөнгө оруулах боломж нөхцөл, үнэт цаасны төрөл, тэдгээрийн давуу болон сул талыг мэддэг болно.
- Хөрөнгийн зах зээлийн тухай ерөнхий ойлголтой болж уг зах зээлд оролцох ур чадварыг эзэмшинэ.
- Орлогоосоо даатгалын шимтгэл төлөх замаар ирээдүйдээ хөрөнгө оруулах боломжийг судалж мэднэ.

Тодорхой хэмжээний орлого олсны дараа түүнийгээ хэрхэн хуримтлуулах, улмаар хэрхэн өсгөж аввижуулах вэ гэсэн асуудал тулгарна. Энэхүү бүлэгт Монгол Улсын банк, санхүүгийн зах зээл өнөөдөр иргэдэд ямар боломж олгож байгааг өгүүлэх болно.



Бүлгийн эхний хэсэгт мөнгөн хуримтлал үүсгэх боломжуудыг Банкны болон Хадгаламж Зээлийн Хоршоо /ХЗХ/-ны үйлчилгээтэй холбон тайлбарласан ба харин сүүлийн хэсэгт хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулан орлогоо нэмэгдүүлж болох илүү идэвхитэй арга замуудыг авч үзлээ. Үүнд хувьцаа, бонд болон Хөрөнгө оруулалтын сан /ХОС/ гэсэн хувилбаруудыг эхний ээлжинд сонгосон болно. Мөн түүнчлэн орлогын тодорхой хэсгээ даатгалд зориулах нь ямар ач холбогдолтой болохыг товч дурьдав.

2.1. Мөнгөн хадгаламж: Банк

2.1.1. Мөнгөн хадгаламж гэж юу вэ?

Өмнөх бүлэгт хувийн санхүүгээ сайтар төлөвлөн цалингаасаа илүүчлэх замаар, мөн гэнэтийн орлого зэргээс хэрхэн хадгаламж үүсгэж, цаашид өсгөх арга зам байгааг тайлбарласан билээ.

Банкны хадгаламж. Хадгаламжийн гэрээгээр хадгалуулагч-иргэн буюу хуулийн этгээд мөнгөө тодорхой хугацаагаар, эсвэл хугацаагүйгээр хадгалуулах, банк уг мөнгийг гэрээнд заасан хугацаанд хадгалж, тохиролцсон хэмжээгээр хүү төлөх, эргүүлэн олгох үүргийг харилцан хүлээдэг.

Харин Та хуримтуулсан мөнгөө гэртээ, ажил дээрээ, эсвэл хэн нэг найдвартай хүний сейфэнд хадгалуулж болно. Энэ нь зүгээр л хэрэгтэй, хэрэггүй зүйлд мөнгөө үрчихсэнтэй харьцуулбал нэг дэвшилтэт алхам мөн боловч Та мөнгөө зүгээр л хуримтуулж байна гэсэн үг. Гэхдээ ингэж хадгалсан мөнгө нэмэгдэхгүй, тэр ч бүү хэл инфляциас болоод үнэ цэнэ нь буурч байдаг сүл талтай. Харин хадгаламжийн гэрээ байгуулж мөнгөө банкинд хадгалуулбал банк хүү төлөх бөгөөд тэрхүү хүүгийн хэмжээгээр Таны мөнгө өсөх болно. Мөн хадгаламж зээлийн хоршоонд гишүүнээр элсэж мөнгөө хадгалуулж болно.

2.1.2. Хадгаламжийн давуу тал

Мөнгөө банкинд хадгалуулах нь дараах давуу талтай:

- Хүүгээрээ өснө.
- Найдвартай буюу хаях гээх, хулгайд алдах зэргээс сэргийлнэ.
- Инфляциас хамаарч хадгалсан мөнгө үнэ цэнээ алдах нь багасна.
- Өөрийн бизнес эрхлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгоно.

2.1.3. Хадгаламжийн сүл тал

- Хадгаламжийн өгөөж нь хэрэглээний зээлийн хүүнээс харьцангуй доогуур.
- Банк дампуурсан тохиолдолд алдагдал үүсэх эрсдэлтэй.
- Өндөр инфляциас шалтгаалж үнэ цэнэ буурах хандлага бий.

Банк нь бусдын мөнгийг өөрийн нэрийн өмнөөс зээлдүүлдэг учир хадгаламж эзэмшигчид бүгд нэг зэрэг мөнгөө татвал банк дампуурна. Хадгаламж эзэмшигчид энэхүү бизнесийн мөн чанарыг зөв ойлгож хүлээцтэй байхаас гадна хадгаламж хийх гэж байгаа банкныхаа найдвартай байдлыг анхааралтай судалж сонголтоо хийх нь зүйтэй.

Инфляци өндөр үед хадгаламж үнэ цэнээ алдах аюултай. Инфляци нь үнийн өсөлттэй холбоотой ойлголт бөгөөд инфляци өндөр үед мөнгөний үнэ цэнэ буурдаг. Үүнийг дараах жишээгээр тайлбарлая. Иргэн А таван жилийн өмнө 45 сая төгрөгөөр гурван өрөө орон сууц худалдан авах боломжтой байсан боловч түүнийгээ банкинд хадгалсан бөгөөд энэ хугацаанд орон сууцны үнэ өссөөр 95 сая төгрөг болсон гэж үзье. Энэ таван жилийн хугацаанд иргэн А-ийн хадгаламж дахь мөнгө жил бүрийн хүүгээрээ өссөөр 85 орчим сая төгрөг болсон ч гурван өрөө байр авахад хүрэлцэхгүй болжээ. Үүнийг бид инфляцийн улмаас хадгаламжийн үнэ цэнэ буурлаа гэж үзнэ.

2.1.4. Хадгаламж хийхдээ юу анхаарах вэ?

1. Банкаас зөв сонгох. 1990-ээд оны дунд үеэр зарим банк дампуурч хадгаламж эзэмшигчид нь жагсаал цуглаан хийж байсныг зарим хүмүүс санаж байгаа байх. Төлбөрийн чадваргүй болсон банкинд мөнгөө хадгалаулбал алдах эрсдэл байдгийг энэ явдал нотолсон. Банкууд улирал бүр хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан тайлан балансаа олон нийтэд зориулан нийтэлж, мэдээлэх үүрэгтэй байдаг. Тэр мэдээллийг өдөр тутмын сониноос, тухайн банкны вэб хуудаснаас олж үзэж болно. Тухайн банкны тайлан балансаас олон чухал мэдээллийг олж харах боломжтой. Тухайлбал, нийт активын дүнгээс бусдаас татсан хөрөнгө /хадгаламж, харилцах/-ийг хасахад хэдий хэр хөрөнгө үлдэж байна вэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Тэрхүү үлдэгдэл нь тухайн банкны өөрийн хөрөнгө юм. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкуудын вэб хаягийг хавсралт 5-аас үзнэ үү.

2. Санхүүгийн зөвлөгөө авч болно. Хэрэв Та өөрийгөө санхүүгийн зохих мэдлэггүй гэж үзэж байгаа бол харилцагч банкны ажилтнууд зэрэг мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч болно. Түүнчлэн иргэдийн санхүүгийн боловсролд зориулсан “Санхүүгийн лавлах мэдээ” сонинг захиалж үзэх, эсвэл www.Finance-Mongolia.com вэб сайтаас дэлгэрэнгүй мэдээлэл, ашигтай зөвлөгөөг унших боломжтой. Мөн 1963 дугаарын утас руу залгаж санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл авч болно. Гэхдээ зөвлөгөө өгч байгаа хүн Таны өмнө баталгаа гаргахгүй тул өөрөө л эцсийн сонголтоо, мөн түүнчлэн түүнтэй холбогдох эрсдлээ хариуцна.

3. Банкуудын хадгаламжийн төрөл, нөхцөл өөр өөр байдаг. Үүнийг бас судлах хэрэгтэй.

Банкууд хадгаламжийн хүү, хугацаа, төрөл зэрэг нөхцлүүдээ өөрийн бодлогод нийцүүлэн хэрэгжүүлдэг тул хадгаламж хийхдээ банкуудын вэб хуудас болон тэдгээрийн харьцуулсан судалгааг үзэж байж сонголтоо хийхэд илүүдэхгүй.

Өгөөж өндөртэйг нь гол шалгуур болгон хамгийн өндөр хүү санал болгож байгаа банкинд мөнгөө хадгалулахаар шийдэж болох ч өгөөж, эрсдэл хоёр ямагт шууд хамааралтай байдгийг бүү мартаарай. Иймээс өгөөжөөс гадна санхүүгийн чадавхийг нь зайлшгүй харгалзаж үзэх нь зүйтэй. Сонгосон банкныхаа санхүүгийн чадавхид нь эргэлзэж, эсвэл дэлгэрэнгүй мэдээлэлгүй байгаа бол богино хугацаагаар хадгалуулж болно.

Хадгаламжийг үндэсний валют болох төгрөгөөр хийхээс гадна чөлөөтэй хөрвөдөг бусад валютаар хийнэ. Банкууд валютын төрлөөс нь хамааруулж хугацаа, хүү зэрэг нөхцлөө өөр өөрөөр тогтоосон байдаг тул Та хадгалаламжаа чухам ямар валютаар хийхээ тооцоолж сонгоорой.

2.1.5. Хадгаламжийн төрлүүд

Арилжааны банк бүрийн хадгаламжийн нөхцөл нь өөр өөр байдгийг дээр дурдсан. Зарим хугацаатай хадгаламжид орлого нэмж, зарлага гаргаж болдог байхад заримд нь эдгээр гүйлгээг зөвшөөрдөггүй. Мөн зарим хугацаатай хадгаламжийн хүүг хугацааны эцэст авдаг бол заримдаа урьдчилан, эсвэл хэсэгчлэн авч болдог гэх мэт өөр өөр нөхцөлтэй байдаг. Иймээс хугацаатай хадгаламжийг сонгоходоо түүний нөхцлүүдийг анхаарах нь зүйтэй.

Дараах хүснэгтэд арилжааны банкуудын түгээмэл ашиглаж байгаа зарим хадгаламжийн нөхцлүүдийг харууллаа (Хүснэгт 1.).

Хүснэгт 1. Арилжааны банкны хадгаламжийн нөхцлүүд

| № | Хадгаламжийн төрөл | Нөхцөл |
|-----|------------------------------------|--|
| 1. | "Алтан тулхүүр" хүүхдийн хадгаламж | Өндөр хүйтэй, хүүгийн өчүүхэн бага хэсгийг Голомт банк "Монголын хүүхдийн төлөө" сангаар дамжуулан Дэлхийн Зөн ОУБ-д хандивладаг. |
| 2. | Дэвжих | Орлого зарлагын гүйлгээ хийж болно. |
| 3. | Хуримтлах | Гэрээний хугацаанд орлого хийж болно, зарлагын гүйлгээ хийхгүй. |
| 4. | Ундрах | Гэрээний хугацаанд орлого хийж, зарлагын гүйлгээ хийхгүй. |
| 5. | Насны нүнжиг | Эхний тодорхой хугацаанд зөвхөн орлого хийж, дараагийн жилүүдэд зарлагын гүйлгээ гаргана. |
| 6. | Хас өргөө | Орон сууц, хашаа байшингийн зээлийн урьдчилгаа төлбөрийг хуримтлуулдаг хадгаламж |
| 7. | Хүслийн үндэс | - Өдөр тутмын мөнгийг эрсдлээс хамгаалах хугацаагүй хадгаламж - Бизнесийн эргэлтийн хөрөнгийг дэмжих богино хугацаатай хадгаламж - Ирээдүйд зориулсан урт хугацаат хадгаламжаас бүрдэнэ. |
| 8. | "Postbank" хадгаламж | Орлого хийдэг, зарлагын гүйлгээ хийдэггүй. |
| 9. | "Platinum" хадгаламж | Орлого хийдэггүй, зарлагын гүйлгээ хийдэггүй. |
| 10. | "Алтан боломж" хадгаламж | Хүүгийн орлогыг хадгаламж эзэмшигчийн нэр дээр нээсэн өглөгийн дансанд хийнэ. |

Хадгаламжийн гэрээг хугацаагүй болон тодорхой хугацаатай байгуулснаас хамааран хугацаагүй, эсвэл хугацаатай хадгаламж гэдэг.

Хугацаагүй хадгаламжийн хүү сард дунджаар 0.5-0.6 хувь байдаг бөгөөд хадгалуулагч хүссэн цагтаа мөнгөө авч хэрэглэж болно. Гэсэн хэдий ч сард дөрвөөс дээш гүйлгээ хийвэл хадгаламжийн данс биш харин энгийн харилцах дансны төрөлд орж хүү бодогдохгүй.

Тодорхой хугацаа тохирч хадгаламж хийхэд заасан хугацаанд зарлагын гүйлгээ хийхгүй. Харин орлого хийж болно. Манай банкууд ихэвчлэн

- 3 сарын
- 6 сарын
- 1 жилийн гэх мэт хугацаатай хадгаламж авдаг.

Нэгэнт гэрээнд заасан хугацаанд хадгалуулагч мөнгөө шаардаж авахгүй бол банк уг мөнгийг мөн тийм хугацаанд чөлөөтэй ашиглах боломжтой. Иймээс хугацаатай хадгаламжийн хүү нь хугацаагүй хадгаламжтай харьцуулахад өндөр, мөн хугацаа нь урт байх тутам хүү нь өндөр байдаг. Гэсэн хэдий ч хадгалуулагч гэрээнд заасан хугацаанаас өмнө мөнгөө авах шаардлага амьдралд цөөнгүй тохиолддог. Жишээ нь, Хандаа гадаадад ажиллаж олсон 10.0 сая төгрөгөө “Х” банкинд нэг жилийн хугацаагаар хадгалуулсан байна. Нэг жилийн хугацаатай хадгаламжийн хүү дунджаар 18 хувь байсан учраас харьцангуй ашигтай байлаа. Хадгаламж хийснээс хойш таван сарын дараа найз нар нь компани байгуулж, хамтран бизнес хийе гэсэн саналыг Хандаад тавьсан нь түүнд таалагдсан. Тэгээд байгуулах гэж байгаа компанидаа 7.0 сая төгрөгийн хөрөнгө оруулахаар тохирч, хадгаламжаасаа авна гэж тооцсон боловч хугацаа болоогүй байсан нь Хандаад бэрхшээл учрууллаа. Хандаа гэрээний хугацаа дуусаагүй байхад мөнгөө авч чадах уу?

Банкинд хадгалуулсан 10,0 сая төгрөг нэгэнт Хандаагийн өмч тул тэрээр өмчөө хэдийд ч захиран зарцуулах эрхтэй. Хуулиар хамгаалагдсан энэ эрхийг хэн ч хязгаарлаж чадахгүй. Хэдийгээр Хандаа хадгалуулсан мөнгөө авч чадах боловч гэрээнд заасан хэмжээгээр хүүгийн ашгаа авч чадахгүй. Энэ тохиолдолд банкууд ихэвчлэн өнгөрсөн таван сарын хүүг нь хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцож олгодог. Энэ жишээн дээр нэг жилийн хугацаат хадгаламжийн хүүг 18 хувь, хугацаагүй хадгаламжийн жилийн хүүг 6 хувиар бодож тооцоог нь хийж үзье. Хэрэв Хандаа нэг жилийн дараа гэрээнд заасан хугацаандаа мөнгөө авсан бол 10.0 сая төгрөг дээрээ 1.8 сая төгрөгийн хүү нэмж авах байсан. Гэтэл таван сарын дараа буюу хугацаанаасаа өмнө гэрээгээ цуцалж байгаа тул хүү нь ердөө 250,000 төгрөг болж байна.

Дээрх тооцоог нарийвчлан үзүүльье:

- Хугацаатай хадгаламжийн жилийн дараах хүү:
 $10,000,000 \times 18\% = 1,800,000$ төг
- Хугацаагүй буюу 5 сарын дараах хүү:
 $10,000,000 \times 6\% \times 5/12 = 250,000$ төгрөг.

Таван сарын дараа хугацаанаасаа өмнө гэрээгээ цуцалж байгаа тул хүүг хугацаагүй хадгаламжийнхаар тооцно.

Банкууд хүүгээс хүү боддог, хүүгээ урьдчилан болон сарын эцэст авч болдог хадгаламжаас гадна зорилгоос нь хамааруулж төрөл бүрийн нөхцөлтэй хадгаламжийг санал болгодог. Үүнд:

- Тэтгэврийн /“Насны нүнжиг”/
- Хүүхдийн
- Өрх гэрийн /хадгаламждаа өрхийн насанд хүрсэн хүн бүр гүйлгээ хийж болдог/
- Орон сууцны /Хас өргөө/
- Хонжворт Г.М

Хүүхдийн хадгаламж. Хүүхдийнхээ нэр дээр тодорхой хэмжээний мөнгийг 18 нас хүртэл нь хадгалах хамгийн урт хугацааны хадгаламж юм. Жишээ нь, таван настай хүүхдэд энэ хадгаламжийг нээлгэвэл хадгаламжийн хугацаа 13 жил, 15 настай хүүхдэд нээлгэвэл гурван жил гэх мэтээр хугацааг тогтоодог. Хүүхдийн хадгаламжийн хүү харьцангуй өндөр. Гэхдээ өнөөдөр манай арилжааны банкуудад хүүхдийн хадгаламжийн жилийн хүүг энгийн хугацаатай хадгаламжийн тухайн үеийн хамгийн өндөр хүүгээр тогтоодог практик ажиглагдаж байна.

Хонжворт хадгаламж. Тэмдэглэлт өдөр, ойг тохиолдуулж арилжааны банкууд төрөл бүрийн хонжвортой хадгаламж зарладаг ба зарим банкууд хонжворыг уламжлал болгон тодорхой цаг хугацаанд зарладаг.

2.2. Мөнгөн хадгаламж: Хадгаламж зээлийн хоршоо

Иргэд өөрсдийн санхүүгийн хэрэгцээг хангахын тулд Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ) байгуулах нь түгээмэл. Хадгаламж зээлийн хоршооны гишүүд хоршоондоо мөнгөө хадгалуулж, хүүгээр нь хөрөнгөө арвижуулахаас гадна хоршооноосоо зээл авч бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэж болно.



2.2.1. Хадгаламж, зээлийн хоршооны талаарх өрөнхий ойлголт

Иргэд өөрсдийн эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дурын үндсэн дээр мөнгө болон биет эд зүйлээ нийлүүлж, дундын хөрөнгө бий болгон тэрхүү өмчөө хамтран эзэмшиж, арчилсан удирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагааг нь явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэдэг. Санхүүгийн хэрэгцээгээ хангах зорилгоор байгуулан гишүүдээсээ хадгаламж татаж, мөн гишүүддээ зээл олгох үйлчилгээг дагнан эрхэлдэг санхүүгийн нэгж бол хадгаламж зээлийн хоршоо бөгөөд ийм хоршоо нь зөвхөн гишүүддээ үйлчилдэг.

Хадгаламж, зээлийн хоршооны түүхэн хөгжлийг судалж үзэхэд ихэвчлэн хоорондоо ямар нэгэн холбоотой, бие биеэ сайн мэдэх хүмүүс нэгдэж байгуулсан байдаг. Тухайлбал, ах дүүс, найз нөхөд болон нэг байгууллагад хамтран ажилладаг, мөн нэг дор амьдардаг хүмүүс, өөрөөр хэлбэл харилцан итгэдэг хүмүүс хамтран хоршоо байгуулах нь олонтаа тохиолдоно.

Манай улсад хэдэн жилийн өмнө хэд хэдэн хоршоо дампуурч, цөөнгүй хүмүүс хадгаламжаа алдсан гашуун туршлага бий. Энэ нь радио телевизээр байнга явуулж байсан “өндөр хүү өгнө” гэсэн зар сурталчилгаанд хууртагдаад хэн гэдгийг нь огт мэдэхгүй хүмүүст мөнгөө хадгалуулсны уршиг билээ. Өөрөөр хэлбэл, сайн дурын үндсэн дээр хамтран ажиллах, хөрөнгөө нэгтгэх, удирдлагаа өөрсдөө сонгох гэсэн хоршооны үндсэн зарчмыг ойлгоогүй, баримтлаагүйгээс үүдэлтэй.

2.2.3. Хадгаламж, зээлийн хоршооны давуу болон сул тал

ХЗХ нь гишүүдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн, мэдрэмж сайтай, хүнд сурталгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг давуу талтай.

Хадгаламж, зээлийн хоршооны давуу талыг дараах байдлаар тодорхойлж болно:

- Үйлчилгээг гишүүддээ зардал багатай хүргэдэг.
- Зохих шаардлага хангасан бол гишүүнчлэл нээлттэй, арчилсан удирдлагатай, хяналттай.
- Гишүүд нь тухайн хоршооны үйлчлүүлэгч байдаг тул Хадгаламж, зээлийн хоршоо байнгын харилцагчтай байдаг.
- Гишүүд нь үйл ажиллагаандаа тогтмол оролцож, өөриймсөг сэтгэлээр санаачлагатай хандах, удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой.

- ХЗХ-ны хадгаламжийн хүү нь банкны хүүгээс өндөр байдаг.

Харин хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны сул тал нь:

- Ашгийн төлөө бус байгууллага тул хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаагаа өргөтгөх боломж харьцангуй бага,
- Үйл ажиллагаа нь хязгаарлагдмал, зөвхөн гишүүдийнхээ хүрээнд явагддаг,
- Оруулсан хөрөнгөөсөө үл хамааран нэг гишүүн нэг саналын эрхтэй,
- Хоршооны гишүүдийн мэдлэг, боловсрол, ажлын дадлага туршлага ялгаатай тул хоршооны удирдлагыг сонгоход төвөгтэй байдаг.

2.2.4. Хадгаламж, зээлийн хоршооны мөнгөн хадгаламжийн үйлчилгээ

Хадгаламж, зээлийн хоршоо нь зөвхөн өөрийн гишүүдээс хадгаламж авдаг. Хоршооны мөнгөн хадгаламжийн үйлчилгээ бүх гишүүдийнхээ хурлаар баталсан “Мөнгөн хадгаламжийн үйлчилгээний журам”-ын дагуу явагдана. Энэхүү журамд хоршооны гишүүдийн мөнгөн хөрөнгийг тодорхой гэрээний үндсэн дээр хадгалахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Хадгаламж, зээлийн хоршоо нь Мөнгөн хадгаламжийн гэрээгээр гишүүний мөнгийг хадгалах, хүүг тооцох, бүртгэх, хадгаламж эзэмшигчийн хүсэлтээр мөнгийг нь эргүүлэн олгох зэрэг үүргийг хүлээдэг. Мөнгөн хадгаламжийн гэрээг хоёр хувь үйлдэж, нэгийг нь хадгалуулагчид, нөгөөг нь хоршоонд хадгална.

Хадгаламж, зээлийн хоршооны “Мөнгөн хадгаламжийн дэвтэр” нь тухайн гишүүний хадгаламж эзэмшигч мөн эсэхийг нотлох баримт бичиг юм. Уг дэвтрийн эхний хуудсанд мөнгөө хадгалуулсан гишүүний овог, нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хадгаламжийн дансны дугаар, хадгаламжийн дэвтрийн дугаар, уг дэвтрийг нээсэн ажилтны гарын үсэг, тэмдэг, он, сар, өдөр, хадгаламжийн хүү, хугацаа зэргийг бичнэ. Үүний арын хуудсууд нь гүйлгээ хийсэн он сар өдөр, орлого, зарлагын гүйлгээ болон хүүгийн орлогын тэмдэглэл, гүйлгээ хийсэн ажилтны гарын үсэг зурах, тэмдэг дарах хүснэгтүүдээс бүрдэнэ. Хадгаламж, зээлийн хоршоо нь “Мөнгөн хадгаламжийн дэвтэр”-ийг нэг хувь нээж, хадгалуулагч гишүүнд өгөх бөгөөд ямар ч засваргүй цэвэр бичигдсэн байх шаардлагатай.

Хадгаламж эзэмшигчийн дэвтэрт бичигдсэн гүйлгээнүүд хоршоонд байгаа хадгаламжийн дансны гүйлгээтэй тохирч байх ёстай.

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд энэ тухай гишүүддээ нэг сарын дотор урьдчилан мэдээлсний үндсэн дээр хүүгээ өөрчилдөг. Хадгаламжийн хугацааг дуустал хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр хадгалагч дангаараа хүүгийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах эрхгүй. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд эрсдэл учирч улмаар дампуурахад хүрвэл хадгаламжийн мөнгийг эн тэргүүнд олгоно.

Хадгаламж эзэмшигч нас барсан тохиолдолд хадгаламжийг түүний гэрээслэлийн дагуу, гэрээслэл үлдээгээгүй бол хууль ёсны өв залгамжлагчид шилжүүлнэ. Мөнгөн хадгаламжаа хэн нэгэнд бэлэглэх буюу шилжүүлж болдог. Энэ нөхцөлд бэлэглэлийн гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбар болон бусад шаардлагатай баримт бичгийн хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байх ёстай. Мөн хамтран эзэмшигчтэй бол түүнээс зөвшөөрөл авсан байна.

Хадгаламж эзэмшигч өөрийн биеэр ирж гүйлгээ хийх боломжгүй нөхцөлд итгэмжлэглэгчээр дамжуулан орлого, зарлагын гүйлгээ хийж болно. Гэхдээ тухайн хоршоонд ажиллаж байгаа хүнд итгэмжлэл өгөхийг хориглодог.



2.2.5. Хадгаламж зээлийн хоршоонд гишүүнээр элсэхэд анхаарах зүйл

Хэрэв Та аль нэг хадгаламж зээлийн хоршоонд гишүүнээр элсэх гэж байгаа бол дараах дүрэм, журам болон бусад нөхцөлтэй заавал танилцаарай.

- Хадгаламж, зээлийн хоршооны дүрэм
- Хадгаламж, зээлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа журам, зааврууд
- Хадгаламж, зээлийн хоршооны эрсдлийн удирдлага, зохион байгуулалтын тухай мэдээлэл
- Хоршоо гишүүдийнхээ нийгмийн асуудалд анхаарч байгаа байдал
- Хоршооны удирдлагын мэдлэг боловсрол, ажлын ур чадвар
- Хоршооны түүх
- Санхүүгийн тайлан мэдээнийх нь үнэн бодит байдал, хир хэмжээний ашигтай, эсвэл алдагдалтай ажилласан байдал
- Санхүүгийн тооцоо, судалгаатай ажилладаг эсэх
- Гишүүд нь хоршоондоо хандаж байгаа хандлага зэргийг судалж үзэх нь зүйтэй.

2.3. Хөрөнгө оруулалт: Хувьцаа

2.3.1. Та хувьцаа эзэмшдэг үү?

Манай улс 1990-ээд оны эхээр улсын болон хоршооллын өмчийг хүн бүрт хувьчлахын тулд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг буюу Чингис хааны зурагтай бидний нэрлэдгээр “цэнхэр тасалбар” үнэгүй тараасан. Энэ тасалбар нь үнэт цаасны арилжаанд оролцон өөрийн сонгосон компаний хувьцааг худалдан авах эрх олгосон нэг удаа ашиглах боломжтой төлбөрийн хэрэгсэл байсан юм.

1991 онд Монголын хөрөнгийн бирж байгуулагдаж, иргэд биржээр дамжуулан цэнхэр тасалбараараа хувьцаа худалдан авсан. Тэр үеэс бид үнэт цаас, хувьцааны¹ талаар ойлголттой болж эхэлсэн

¹ Тухайн компанийд хөрөнгө оруулсан, ногдол ашиг авах, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхтэй, компани татан буугдахад түүний бүх үүргийг гүйцэтгэсний дараа үлдсэн эд хөрөнгөөс эзэмшиж байгаа хувьцаатайгаа хувь тэнцүүлэн авах эрхийг гэрчилсэн үнэт цаас юм.

билээ. Харин 1994 онд “Үнэт цаасны зах зээлийн тухай” анхны хууль батлагдсан бөгөөд 1995 оноос цэнхэр тасалбараар худалдан авч эзэмшсэн хувьцаагаа иргэд хоорондоо бэлэн мөнгөөр зарж борлуулах, худалдан авах боломж нээгдсэн. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн.

Үнэт цаасны арилжааны эхэн үед иргэд үнэт цаасны зах зээлийн талаар харилцан адилгүй ойлголттой байсан. Одоо ч энэ байдал хэвээр байна. Бэлэн мөнгөний арилжаа эхэлснээр зах зээлийн зарчмыг ойлгосон зарим хүмүүс тодорхой компанийн хувьцааг худалдан авч, тухайн компанийн хувьцааны томоохон багцыг эзэмшсэнээр, түүний үйл ажиллагааг удирдах эрхтэй болсон. Гэсэн хэдий ч төрөөс үнэ төлбөргүй олгосон цэнхэр тасалбараар авсан хувьцааныхаа талаар ямар ч шийдвэр гаргаагүй, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид дансаа нээлгэж хувьцаагаа арилжих нөхцлөө ч бүрдүүлээгүй 130 гаруй мянган иргэн байна (Хүснэгт 2-оос дэлгэрүүлж харна уу.). Энэ нь үнэт цаасны зах зээлийн талаархи иргэдийн боловсролыг дээшлүүлэх шаардлагатайг харуулдаг.

Хүснэгт 2. Төвлөрсөн хадгаламжид данстай хувьцаа эзэмшигчдийн тоо /2009 оны 5 дугаар сарын 10-ны байдлаар/

| Эзэмшиж байгаа хувьцааны тоо /ширхэгээр/ | Хувьцаа эзэмшигчдийн тоо | | | Нийт хувьцаа эзэмшигчдийн тоонд эзлэх хувь |
|--|--------------------------|-----------------|----------|--|
| | Данс нээгдсэн | Данс нээгдээгүй | Нийт дүн | |
| 1-10 | 102,438 | 18,293 | 120,731 | 29.76 |
| 11-50 | 71,519 | 38,623 | 110,142 | 27.15 |
| 51-100 | 42,680 | 26,183 | 68,863 | 16.97 |
| 101-500 | 40,873 | 48,696 | 89,569 | 22.08 |
| 501-1000 | 5,836 | 1,814 | 7,650 | 1.88 |
| 1001-5000 | 4,731 | 337 | 5,068 | 1.24 |
| 5001-10000 | 1,046 | 8 | 1,054 | 0.25 |
| 10001-50000 | 1,591 | 5 | 1,596 | 0.39 |
| 50001-100000 | 399 | 5 | 404 | 0.09 |
| 100001-ээс дээш | 515 | 0 | 515 | 0.12 |
| НИЙТ | 271,628 | 133,964 | 405,592 | 100 |

Эх үүсвэр: УЦТТТХТ, ХХК

Хүснэгтээс харахад 1,000 хүртэлх хувьцаатай жижиг хувьцаа эзэмшигчид 97.3 хувийг эзэлж байхад 3,000 орчим том хувьцаа эзэмшигчид хувьцаат компаниудыг удирдан хянаж байна. Компаниуд эзэнтэй болсон нь сайн хэрэг боловч ихэнх компанийн удирдлага жил бүр хувьцаа эзэмшигчдийн хурал хийх, мэдээллээр хангах, зарим

тохиолдолд бусдын хувьцааг худалдан авахад тендер санал² гаргах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, ашигтай ажилласан ч ногдол ашиг хуваарилахгүй байна. Энэ нь олон жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироож байгаа юм. Нөгөө талаас жижиг хувьцаа эзэмшигчдийн өмчлөх эрхээ хэрэгжүүлэх идэвхи нь туйлын хангалтгүй байдаг.

Та энэхүү хүснэгтийн аль хэсэгт хамаарч байна вэ? Хэрэв Та огт хувьцаа эзэмшдэггүй, эсвэл идэвхигүй хувьцаа эзэмшигчдийн эгнээнд багтаж байгаа бол энэ гарын авлагыг судалсны дараа өөрийн байр суурийг эргэн харж, үнэт цаасны зах зээлд идэвхитэй оролцогч болно гэж найдаж байна. Учир нь өмч хувьчлалын үеэр худалдан авсан хэдэн ширхэг хувьцаагаараа яг одоо томоохон хуримтлалтай болж чадахгүй ч ирээдүйд хуримтлалтай болох үндэс сууриа тавих боломжтой.

Зөвлөмж: Та үнэт цаасны зах зээлд оролцох гэж байгаа буюу өмч хувьчлалаар авсан хувьцаагаа өнөөг хүртэл эргэлтэд оруулж чадаагүй байгаа бол дараах алхмуудыг хийгээрэй.

1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээ баталгаажуулж, хувьцаа худалдан авах захиалга өгсөн брокерийн компанийг олох, хэрэв тэр брокерийн компани олдохгүй бол Монголын хөрөнгийн биржид хандах,
2. Харин анх удаа үнэт цаасны арилжаанд оролцох гэж байгаа бол брокерийн компания сонгох,
3. Брокероороо дамжуулан Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд дансаа нээлгэх,
3. Брокероосоо мэдээлэл, зөвлөгөө авсны үндсэн дээр ямар үнэт цаас худалдаж авах шийдвэрээ гаргах,
4. Брокертоо захиалгаа өгөх.

Үнэт цаас нь хэлбэрийн хувьд биет болон биет бус гэж ангилагддаг. Биет үнэт цаас нь хэвлэмэл хэлбэрээр байдаг бол

² Аль нэг компаний нийт хувьцааны хяналтын багц буюу 33.3 хувийг дангаараа эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт өмчилж буй хувьцаа эзэмшигч тухайн компаний бусад жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Компаний хуульд заасан журмын дагуу худалдан авахыг тендер санал гэдэг.

биет бус нь цахим хэлбэрээр хадгалагддаг. Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй бүх үнэт цаасыг анхнаас нь биет бус хэлбэртэй гаргасан нь манай зах зээлийн нэг дэвшилттэй тал гэж хэлж болно. Хөрөнгийн зах зээлийн олон зуун жилийн түүхтэй Япон улсад өнөөдөр хэвлэмэл үнэт цаасаа цахим хэлбэрт шилжүүлэх нүсэр ажил үргэлжилж байна.

Үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийхийн тулд хөрөнгийн зах зээлд арилжаалагддаг хэрэгслийн талаар илүү дэлгэрэнгүй ойлголт авах шаардлагатай.

2.3.2. Хувьцаа эзэмшихийн давуу болон сул тал

Хувьцаа эзэмшихийн давуу тал нь:

- Ногдол ашиг авах,
- Ханшийн өөрчлөлтөөс ашиг олох,
- Саналын эрх эдэлж, компаний удирдлага, шийдвэр гаргах үйл явцад оролцох явдал юм.

Харин сул тал нь:

- Нөхөрлөл, эсвэл цөөн гишүүнтэй ХХК-д хөрөнгө оруулахтай харьцуулахад хувьцаа эзэмшигч өмчийнхөө талаар шийдвэр гаргах боломж нь хязгаарлагдмал буюу өмчөөсөө холдоно.
- Давхар татвар төлнө, өөрөөр хэлбэл, компани ашгийн татвар төлсний дараах цэвэр ашгаасаа ногдол ашиг хуваарилдаг ба хувьцаа эзэмшигч уг ногдол ашгаасаа бас дахин татвар төлдөг.
- Компани дампуурвал компаний бонд эзэмшигч, зээлдүүлэгч зэрэг авлага бүхий бусад этгээдийн өрийг төлсний дараа үлдсэн хөрөнгөөс хувьцаа эзэмшигчдэд хуваарилна. Хэрэв хөрөнгө үлдэхгүй бол хувьцаа эзэмшигч эрсдлээ хүлээнэ.

Хувьцаанд хөрөнгө оруулагч нь банкны хадгаламж, бондоос илүү өндөр ашиг олох зорилготой. Гэхдээ хувьцаа илүү өндөр эрсдэлтэй. Харин хувьцааны бас нэг давуутал нь бизнесийн хувь нийлүүлэгч болох боломж юм. Тухайлбал, иргэн өөрийн дуртай ундааны үйлдвэрийн хувьцааг худалдан авч болно. Хувьцааны хөрөнгө оруулалт хийхэд ногдол ашгаас гадна үнийн өсөлтөөс ашиг олох боломжтой байдаг.

Жишээ: А барилгын компани урт хугацаанд тогтвортой ажиллах бодлого баримталж орон сууцны чанарт ихээхэн анхаарсан. Эн нь олон түмний дунд А компаний нэр хүндийг өсгөжээ. Улс орон даяар орон байрны нөхцлөө сайжруулах хүсэлтэй маш олон иргэн байгаа нь барилгын салбарт хөрөнгө оруулахад ихээхэн ашигтай гэж хөрөнгө оруулагч Б үзээд барилгын компаниудын санхүүгийн чадавхи, боловсон хүчин, нэр хүнд, урт хугацааны бүтээмж зэргийг харьцуулж судалсны дунд А компаний хувьцааг нь худалдан авахаар шийдсэн.

2.3.3. Хувьцаа худалдан авахдаа юуг анхаарах вэ?

Олон улсын зах зээл дээр хэдэн мянган компаний хувьцаа арилжаалагдаж байдаг. Монголын хөрөнгийн захаас ч гэсэн хэдэн зуун компаний хувьцааг худалдан авч хөрөнгө оруулалт хийх боломжтой. Энэ олон хувьцаанаас сонголт хийхийн тулд зарим суурь ойлголттой байх хэрэгтэй. Анхаарвал зохих зарим асуудлыг зохих дарааллын дагуу танилцуулъя.

1. **Бизнесийн салбар.** Аль салбарын компаний хувьцааг худалдаж авахаа шийдвэл Таны сонголтын тоог үлэмж цөөрүүлнэ. Өөрийн мэддэг салбарыг сонговол шийдвэр гаргахад хялбар байх нь ойлгомжтой. Эдийн засаг дахь бизнесийн салбаруудыг ерөнхийд нь:

- Уул уурхай /Багануур, Тавантолгой/
- Барилга /Нийслэл өргөө /
- Хүнд үйлдвэр /Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр,
Хөтөлийн цемент/
- Хүнсний үйлдвэрлэл /Талх чихэр/
- Жижиглэнгийн худалдаа /Улсын их дэлгүүр/ гэж ангилж болно.

Бизнесийн аль салбар илүү ирээдүйтэй гэж бодож байна түүнийгээ сонгох нь зөв. Нэг, эсвэл хэд хэдэн салбарыг сонгосны дараа тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудыг харьцуулан судлах хэрэгтэй.

2. **Компаний бизнесийн ерөнхий хандлага.** Компаний үйл ажиллагааны ерөнхий байдал, түүх, ирээдүйн чиг хандлагыг харьцуулан судалснаар аль нь харьцангуй сайн, ирээдүйтэй байгааг харж болно. Энэ судалгаагаар тухайн компани өөрийн зах зээлд ямар байр суурь эзэлж байгааг тодорхойлох хэрэгтэй.

3. Компаний стратеги, удирдлага. Тухайн компаний ойрын зорилт болон зах зээлд ямар стратегитай ажиллаж байгааг судалж мэдэх хэрэгтэй. Компанийг удирдаж буй хүмүүс туршлагатай, шударга, нэр хүндтэй, чадварлаг эсэх зэрэг олон зүйлийг мэдэх хэрэгтэй.

4. Санхүүгийн үзүүлэлтүүд. Компаний ирээдүйн ашгийг таамаглахын тулд өнгөрсөн үеийн санхүүгийн үзүүлэлтэд анхаарлаа хандуулах нь зөв. Хамгийн багадаа гурван жил, цаашлаад таван жилийн санхүүгийн үзүүлэлтийг харах хэрэгтэй. Ингэхдээ нийт хөрөнгийн хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн, хэр их өртэй байгаа, ашгийн хэмжээ яаж өөрчлөгдсөнийг анхаарах нь зүйтэй³. Ялангуяа сүүлийн жилүүдэд ашиг нь тогтвортой өсөж байгаа компани ихээхэн найдвартай.

5. Ногдол ашиг. Компани ашгаасаа нийт гаргасан хувьцаандаа хувь тэнцүүлэн хуваарилж буй мөнгөн хөрөнгийг ногдол ашиг гэдэг. Ашигтай ажилласан компаниуд ихэвчлэн жилдээ нэг удаа ногдол ашиг хуваарилдаг. Ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэсгийг хувьцааны зах зээлийн үнэтэй харьцуулж үзсэнээр Та хөрөнгө оруулалтын өгөөжөө ямар байгааг мэдэж болно⁴.

6. Хувьцааны ханшийн график. Ханшийн график нь хувьцааны өнгөрсөн үеийн ханшийн өсөлт, бууралтыг харуулдаг. Эндээс Та тухайн хувьцааны үнийн савалгаа хэр байгааг, хувьцааны ханш өнгөрсөн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн зэрэг мэдээллийг харж болно.

7. Үнэ ба ашгийн харьцаа. Үнэ ба ашгийн харьцаа нь тухайн хувьцааны зах зээлийн үнийг хамгийн сүүлд нэгж хувьцаанд төлсөн ногдол ашигт харьцуулсан үзүүлэлт юм. Энэ нь тухайн компанийг бусад компанийтай харьцуулах боломж олгодог. Тухайлбал, А компаний хувьцааны үнэ ба ашгийн харьцаа 15 байсан гэж үзье. Энэ нь хөрөнгө оруулагчид хамгийн сүүлд төлөгдсөн ногдол ашгийг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх үнээр хувьцааг худалдаж авахад бэлэн байна гэсэн үг юм. Энэхүү үзүүлэлтийг үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн хувьд өөр хоорондоо адилгүй компаниудыг харьцуулахад ашиглаж болно.

³ Балансын үнэ, зах зээл дээр арилжигдаж буй үнийн зөрүүг нэмж оруулах

⁴ Ногдол ашиг тараасан компаний судалгааг Хөрөнгийн биржийн www.mse.mn вэб хуудаснаас үзэж болно.

8. Диверсификаци. “Бүх өндгөө нэг сагсанд хийж болохгүй” гэсэн цэцэн үг байдаг. Ийм болохоор эрсдлээ бууруулахын тулд мөнгөө хэд хэдэн хувьцаанд тархаан байршуулах нь зүйтэй⁵. Нийт хөрөнгөө хэд хэдэн салбарын өөр хоорондоо адилгүй компаниудын хувьцаанд тархаан байршуулах нь бүх мөнгөөрөө нэг компаний хувьцаа авснаас эрсдэл багатай байдаг. Ийнхүү хөрөнгөө тараан байршуулахыг эрсдлийг саармагжуулах буюу “диверсификаци” гэж нэрлэдэг байна.

Өгөөж өсөхийн хэрээр эрсдэл бас өсдөг. Ерөнхийдөө өгөөж өндөр байх тусам эрсдэл өндөр байна гэсэн зүй тогтол санхүүгийн зах зээл дээр хадгалагддаг. Хувьцааны хувьд ч мөн адил эрсдэл ба өгөөжийн харьцаа хадгалагддаг. Тухайлбал, олонд танигдсан, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа компаний хувьцааны ханш огцом өсдөггүй ба их хэмжээний ногдол ашгийг гэнэт төлдөггүй. Харин шинээр эхэлж байгаа олон компани нэг бол төсөөлж байгаагүй их хэмжээний ашиг олох эсвэл дампуурах магадлал бараг тэнцүү байдаг. Амжилттай болсон ийм компаниудын жишээ гэвэл *Microsoft* юм. Хэрэв *Microsoft* анх эхэлж байхдаа хувьцаа гаргасан бол түүнийг нь авах хүн олдохгүй л байсан болов уу. Учир нь тэдний бизнес цоо шинэ байсан учир ирээдүйд ашиг олох уу, дампуурах уу гэдэг нь тодорхойгүй, орлогын хэмжээг нь урьдчилан таамаглах боломжгүй байсан.

2.3.4. Шинээр гаргаж буй хувьцааны онцлог

“IPO” гэдэг нь англиар *Initial Public Offering* гэсэн үгсийн товчлол юм. Үүнийг Монгол хэлнээ утгачлан хөрвүүлбэл “хувьцаагаа нийтэд анх удаа санал болгох” гэсэн үг болно. Өмнө нь цөөхөн хувьцаа эзэмшигчтэй байсан хувийн компани өөрийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг ч мөн ийнхүү нэрлэдэг байна. Эрх зүйн талаас нь авч үзвэл, хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл зэрэг хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээд хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдаж буй хэрэг юм.

Одоо дэлхийд тэргүүлэгч, та бидний сайн мэддэг том корпорациуд бүгд хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр нь анхандаа бүгд л хязгаарлагдмал хариуцлагатай компани, эсвэл нөхөрлөл байснаа үйл ажиллагаа нь тэлж, олон нийтэд танигдахын хэрээр нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай болж хувьцаагаа нийтэд санал болгон хувьцаат компани болсон байна.

⁵ Портфел дэлгэрүүлэх

Үндэстэн дамнасан дэлхийн том банкуудаас хамгийн сүүлд Америкийн *Goldman Sachs* 2000 он хүртэл нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаад хувьцаагаа нийтэд санал болгосноор хувьцаат компани болсон байна.

Анх удаа олон нийтэд санал болгож буй хувьцааг худалдан авах нь эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтад тооцогддог. Компани олон нийтэд хувьцаагаа санал болгож, нээлттэй компани болсны дараа олон тооны хөрөнгө оруулагчид, менежментийн өөрчлөлт, шинээр орж ирсэн хөрөнгө оруулалтаа хэрхэн үр ашигтай зарцуулах вэ гэх зэрэг баагүй сорилттой тулгардаг. Олон улсын хөрөнгийн зах зээлийн сүүлийн 60 жилийн практикаас үзэхэд шинээр гаргасан хувьцааны ханш хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж эхэлснээсээ хойш ихэнх тохиолдолд огцом өсдөг байна. Иймд орлогоороо хөрөнгө оруулалт хийж болох бас нэг сонголт бол шинээр гаргаж буй хувьцаанд хөрөнгө оруулах явдал юм.

2.4. Хөрөнгө оруулалт: Бонд

Бонд нь нэг төрлийн өрийн бичиг юм. Банкны зээлээс ялгаатай нь тус өрийг өөр хүнд худалдах боломж нээлттэй. Бонд гаргагч нь үндсэн төлбөр буюу нэрлэсэн үнийг хүүгийн хамт тохирсон хугацаанд буцааж төлөх баталгааг өгдөг. Өөрөөр хэлбэл, бонд гаргагч нь хөрөнгө оруулагчдаас мөнгө зээлж буй хэрэг юм. Харин бонд худалдан авагч нь хүүгийн орлого олж мөнгөө арвижуулах гэж буй хөрөнгө оруулагч, мэдээж мөнгөө банкинд хадгаламж хэлбэрээр байршуулснаас илүү өндөр ашиг олох тохиолдолд бондыг худалдаж авдаг.

1996 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газраас төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор хямдруулсан бондыг гаргаж эхэлсэн. 1996-2008 онд нийт 170.2 тэрбум төгрөгийн бонд гаргасны 95 орчим хувийг арилжааны банкууд худалдан авсан байна. Иргэд болон бусад хөрөнгө оруулагчид эрсдэл багатай санхүүгийн хэрэгсэл болох Засгийн газрын хямдруулсан бондыг худалдан авах сонирхолтой байдаг. Одоогийн практикт уг бондын нэрлэсэн үнэ өндөр бөгөөд үнэ хаялцуулах, багцаар, дуудлага худалдааны зарчмаар арилжаалж байгаа тул зөвхөн цөөн тооны арилжааны банкууд худалдан авч байна. Цаашид Засгийн газрын бондыг олон түмэнд хүртээлтэй болгох боломжтой юм.

Тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвшөөрөлтэйгээр аймаг, нийслэлийн Засаг дарга бонд гаргах эрхтэй. Энэ эрхээ

хэрэгжүүлсэн Засаг дарга одоогоор байхгүй байна. Ийм үнэт цаасыг орон нутгийн бонд гэж нэрлэдэг.

Ихэнх бонд тогтмол хүүтэй байдаг ба хүү нь тодорхой хугацаанд, үндсэн төлбөр нь хугацааны эцэст бүхэлдээ төлөгддөг.

Жишээ: Монгол Улсын Засгийн газрын бондын нэрлэсэн үнэ 100,000 төгрөг бөгөөд хугацаа нь нэгээс 18 сар хүртэл байдаг. Хэрэв Та хагас жилийн хугацаанд 1,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл 6 сарын хугацаатай 10 ширхэг бонд худалдаж авна гэсэн үг.

Бондыг хугацаанаас нь өмнө хоёрдогч зах зээл дээр худалдах боломжтой байдгаараа хадгаламжаас давуу талтай. Хадгаламжаа хугацаанаас нь өмнө цуцлах үед банк хүүгийн торгууль (хүүг бууруулж тооцдог) боддог бол бондыг хугацаанаас нь өмнө худалдахад ийм алдагдал хүлээхгүй.

Харин зах зээл дээрх хүүгийн өөрчлөлт нь бондын худалдах үнэд нөлөөлнө. Тухайлбал, бонд анх худалдаж авсан өдрөөс хойш зах зээл дээр хүү буурсан бол бондын үнэ өсч Та нэмэлт ашиг олно. Учир нь бондын хүүг анх гаргах үед тогтоосон хувиар боддог. Өөрөөр хэлбэл, зах зээлийн хүү буурлаа гээд бондын хүүгээ бууруулдаггүй. Тэгэхлээр зах зээлийн дундаж хүүгээс илүү өндөр хүүгийн орлого олж болох бондын үнэ харьцангуй өснө гэсэн үг. Эсрэгээр хүү өссөн бол зах зээлийн дундаж хүүгээс бага хүүгийн орлого олох учраас бондын үнэ буурч Та алдагдал хүлээх болно.

Жишээ: Таны авсан бонд 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 15 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаатай байсан гэж бодъё. Зургаан сарын дараа гэнэт мөнгөний хэрэгцээ гарсан тул Та бондоо худалдахаар шийдсэн. Энэ үед зах зээл дээрх хүү өсч 20 хувь болжээ. Тэгэхээр таны бондыг худалдан авагч бондын үлдсэн зургаан сарын хугацаанд 20 хувийн хүү шаардах болно. Нэгэнт бонд өөрөө 15 хувийн хүүтэй учир Та үлдсэн 5 хувийн хүүгийн зөрүүг бондын үнийг хямдруулах замаар нөхөж шинэ худалдан авагчид өгнө.

2.4.1. Бонд эзэмшихийн давуу болон сул тал

Бонд эзэмших нь дараах давуу талтай:

- Хөрөнгө оруулалтын өгөөж буюу бондын хүү нь эхнээсээ тодорхой байдаг.
- Бондын хүү нь хадгаламжийн хүүгээс гол төлөв өндөр байдаг.
- Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд тэрээр хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд үндсэн төлбөр, хүүгээ нэхэмжлэн авах давуу эрхтэй.
- Бондоо чөлөөтэй арилжих боломжтой.
- Бондыг хугацаанаас өмнө худалдахад хугацаат хадгаламжтай адил алдагдал хүлээхгүй.

Бонд эзэмших нь дараах сул талтай байдаг:

- Бонд гаргагчийн тухайд саналын эрх эдэлдэггүй, удирдлагад оролцдоггүй.
- Ихэнх тохиолдолд бонд гаргагчийн төлбөрийн чадварыг гуравдагч этгээд хариуцдаггүй.

2.4.2. Бонд худалдан авахад анхаарах зүйл

Та бонд худалдан авснаар үндсэндээ бонд гаргагчид зээл олгож буй хэрэг юм. Тэгэхээр бонд худалдан авагчдад зээлийн эрсдэл учирна. Мэдээж зээлийнхээ хариуд хүүгийн орлого олно.

Бонд худалдан аваходаа бонд гаргасан компаний санхүүгийн чадавхи, зээлжих чадварын үнэлгээтэй анхааралтай танилцаж, ийм үнэлгээ байхгүй бол санхүү, төлбөрийн чадварыг нь анхаарах хэрэгтэй. Зээлжих чадвар буюу рейтингийн талаар энэ номын дөрөвдүгээр бүлгээс дэлгэрүүлэн уншаарай.


Монголын Үнэт цаасны зах зээл дээр анх 2001 онд Барилга корпорациас “Шинэ зуун” бондыг гарган арилжаалсан. Түүнээс хойш нийт 9 компани бонд гарган амжилттай арилжаалсан бөгөөд эдгээр бондыг гол төлөв барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд гаргасан байдаг. Бонд гаргасан нийт 9 компаний 4 нь ХХК байгаа нь хаалттай компани ч бонд гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хямд эх үүсвэр татах боломжтойг нотолж байна.

2.4.3. Бондын хүү

Засгийн газраас гаргасан бондын хүү бага байдаг бол компаниудын гаргасан бондын хүү өндөр байдаг. Бондын хүү нь ерөнхийдөө банкны хадгаламжийн хүүгээс өндөр байдаг. Учир нь банкууд зах зээл дээрээс мөнгө татах нь компаниуттай харьцуулахад амархан байдаг. Мөн банкуудын хадгаламж ихэвчлэн даатгагдсан байдаг тул хадгаламжийн хүү бондын хүүгээс бага байх зүй тогтолтой.

Компаний бондын хүү нь бонд гаргагчийн санхүүгийн байдал, мөнгөний хэрэгцээ шаардлагатай шууд хамааралтай байдаг. Бонд гаргагч нь нэр хүндтэй, санхүүгийн чадвар сайтай том компани байвал хүү нь харьцангуй бага байна. Харин жижиг, олонд төдийлөн танигдаагүй бөгөөд богино хугацаанд мөнгө олох хэрэгцээтэй байгаа бол хүү нь өндөр байдаг.


Манай хөрөнгийн зах дээр арилжаалагдсан компаниййн бондын хүүг банкны хадгаламж, зээлийн хүүтэй харьцуулсан судалгааг дараах графикаас харж болно.



Дээрх графикаас харахад манай зах зээл дээр компаниййн бондын хүү нь банкны зээлийн хүүгээс бага, хадгаламжийн хүүгээс өндөр байдаг нийтлэг жишиг ажиглагдаж байна. Компаниуд сард дунджаар 1.64, бонд гаргах зардлаа нэмээд сарын 1.85 хувийн хүүтэйгээр урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрээ олох боломж байгааг энэ график харуулж байна. Харин бонд гаргахын оронд банкны зээл авбал сард 2,1-3,1 хувийн хүүгийн зардал гаргахаар байгаа тул бондыг сонгох нь

ашигтай. Хөрөнгө оруулагчдын зүгээс авч үзвэл тэд мөнгөө банкинд хадгалуулахын оронд компаний бонд худалдан авбал сар бүр 0,44 хувиар илүү өгөөжтэй хөрөнгө оруулалт авах болно.

"40 мянган айлын орон сууц" хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газраас гаргасан 60.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэл болох 20.0 тэрбум төгрөгийн бондыг 2008 онд арилжихаар санал болгосон хэдий ч дөнгөж 1.5 тэрбум төгрөгийн бонд арилжаалагджээ. Энэ нь өнөөгийн инфляцийн түвшин болон банкуудын хадгаламжийн хүүгийн өсөлт, мөн Төв банкны бодлогын хүүгийн өсөлт зэргээс шалтгаалан хөрөнгө оруулагчид, ялангуяа Засгийн газрын бондын үндсэн худалдан авагч болох банкуудад энэхүү бондыг худалдан авах нь ашиггүй болсонтой холбоотой.⁶



2.4.4. Бондын өгөөж

Хөрөнгө оруулагч бондыг хугацаанаас нь өмнө худалдах тохиолдол гардаг. Энэ үед бондын анх гаргасан хүү ба тухайн худалдах/худалдан авах үеийн зах зээлийн хүүгийн харьцаанаас шалтгаалан үнэ тогтдог. Хэрэв зах зээл дээрх хүү өссөн бол бондын өгөөж дагаж өснө. Энэ үед бондоо худалдаж байгаа хүн хохирол амсана. Харин зах зээлийн хүү буурсан бол бондоо худалдаж байгаа хүнд ашигтай. Өөрөөр хэлбэл, бондын өгөөж нь авсан зарсан үнийн зөрүүгээр

⁶ Хорооны 2008 оны жилийн эцсийн тайланд орсон.

тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн үеийн зах зээлийн хүүгийн түвшингээс шалтгаална.

Жишээ: А компаний нэг жилийн хугацаатай бондын нэрлэсэн үнэ 1,000,000 төгрөг, хүү нь 18 хувь байжээ. Зургаан сарын дараа хөрөнгө оруулагчид мөнгө хэрэгтэй болсон тул бондоо брокероор дамжуулан худалдах захиалга өгөв. Брокер судалж үзсний эцэст хүмүүс энэхүү бондыг 25 хувийн өгөөж олох нөхцөлд л худалдан авахад бэлэн байгааг тогтоов. Учир нь нэг сарын өмнө Төв банк бодлогын хүүгээ өсгөсний улмаас уг бондтой төстэй бондуудыг зах зээл дээр 25 хувийн хүүтэйгээр гаргаж эхэлсэн байна. Манай хөрөнгө оруулагч бондыг хугацааг нь дуустал хадгалахад 1,180,000 төгрөг авах байсан. Гэвч одоо хөрөнгө оруулагчид 25 хувийн өгөөж шаардаж байгаа тул манай хөрөнгө оруулагч өөрийн авах байсан хүүгийн орлогоос нөхөж энэхүү нэмэлт 7 хувийг гаргах хэрэгтэй болно.

2.5. Хөрөнгө оруулалтын сан

2.5.1. Ерөнхий ойлголт

Хамгийн анхны Хөрөнгө оруулалтын сан /ХОС/ 1774 онд “Эвтэй бол хүчтэй” нэртэйгээр Голланд улсад байгуулагдаж байснаас хойш даруй 230 орчим жил өнгөрчээ. Энэхүү сангийн үндсэн зорилго нь олон жижиг хөрөнгө оруулагчид нийлж нэгдсэн сан үүсгэн хөрөнгийн зах зээл дээр хувьцаанд хөрөнгө оруулалт хийхэд чиглэгдэж байсан.

Хөрөнгө оруулалтын сан нь иргэд, байгууллагын мөнгөн хөрөнгийг нэгтгэн сан бүрдүүлж, түүгээр үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө болон дээр дурьдсан бусад санхүүгийн хэрэгсэл худалдан авах, худалдах зэргээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг. Зарим санд асар их хэмжээний мөнгө төвлөрдөг боловч түүний бүтэц тун хялбар бөгөөд цөөхөн хүн удирддаг. Санд төвлөрсөн хөрөнгийг зөв зохистой хөрөнгө оруулалт хийж өсгөх зорилгоор үндсэндээ мэргэжлийн менежерүүд удирдан ажиллуулдаг.

Сангийн менежерүүд ихэвчлэн өмнө нь олон жил хөрөнгийн зах дээр ажиллаж байсан диллерүүд эсвэл банкирууд байдаг. Олон улсын практикаас харахад өнгөрсөн 10 жилд хөрөнгө оруулалтын сангийн өгөөж нь хадгаламжийн хүүгээс 20 орчим хувиар илүү байсан байна.

Сангийн менежерүүд нь өөр хоорондоо адилгүй зах зээлийг судалж, хөрөнгө оруулалтын ашигтай боломжийг хайдаг. Түүний зэрэгцээ аливаа болзошгүй эрсдлийг үнэлж, түүнээс хамгаалах арга хэмжээ авдаг. Ийнхүү хөрөнгийг удирдахдаа тэд эдийн засгийн, зах зээлийн, компаний гэсэн гурван түвшинд хувьцаа, бонд болон бусад хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг тогтмол судалдаг. Ингээд хамгийн тохиромжтой гэж үзсэн хэрэгслүүдийг сонгож, хөрөнгө оруулдаг байна. Сангууд ихэвчлэн зах зээл эсвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнээр төрөлжсөн байдаг.

Жишээ: “Монгол үнэт цаас” сангийн менежер Дорж өөрийн сангийн стратегийг “хүнсний үйлдвэрлэлийн хувьцаа” гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, Доржийн удирддаг сан зөвхөн хүнсний чиглэлээр ажилладаг компаниудын хувьцаанд хөрөнгө оруулалт хийдэг. Доржийн санхүүгийн шинжээчид нь хүнсний үйлдвэрлэлийн хандлага, түүний дотор компаниудын өрсөлдөөн, компани тус бурийн бодлого, удирдлагын онцлог, технологи зэрэг олон асуудлуудыг өдөр тутам судалж харьцуулалт хийж байдаг. Дорж одоогийн байдлаар нийтдээ 23 хүнсний үйлдвэрлэлийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийсэн байна. Тэрээр бүх үзүүлэлтийг өдөр тутам хянаж шаардлагатай үед нь хувьцаа нэмж худалдан авах эсвэл худалдах шийдвэр гаргадаг.

2.5.2. ХОС-гийн төрлүүд

Хаалттай, нээлттэй гэсэн хоёр төрлийн хөрөнгө оруулалтын сан байдаг. Нээлттэй санд иргэд хүссэн үедээ, хүссэн хэмжээгээрээ хөрөнгө оруулалт хийж болно. Мөн хэрэгцээтэй үедээ санд оруулсан хөрөнгөе буцаан татаж болно. Харин хаалттай санд орох хөрөнгө оруулагчдын тоо хязгаартай бөгөөд сангаас хүссэн үедээ гарах боломжгүй байна. Хаалттай сан нь ихэвчлэн үйл ажиллагаа явуулах тодорхой хугацаатай байдаг бол нээлттэй сан тодорхой тогтоосон хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулдаг.

2.5.3. ХОС-гийн давуу ба сул тал

Хөрөнгө оруулалт хийх, мөнгөн хөрөнгийг зөв зохистой байршуулахад мэргэжлийн мэдлэг туршлага шаардагддаг. Тухайлбал, эдийн засаг, санхүү, бизнес, маркетинг зэрэг маш олон салбарын өндөр мэдлэгтэй байх ёстой. Тийм ч учраас хөрөнгө оруулалтын

сайн менежер болоход ихээхэн цаг хугацаа шаардагдана. Хөрөнгө оруулалтын сангудыг туршлагатай сайн менежерүүд удирддаг учраас харьцангуй эрсдэл багатай байдаг. Сул тал нь итгэл дааж, хариуцлагатай ажиллах мэргэшсэн сангийн менежер ховор, тогтвортой ажиллах баталгаа бага, өөрийн өмчийн талаар шийдвэр гаргах эрх мэдэл нь хязгаарлагдмал байдаг.

Хувьцаа, бонд болон хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулахдаа тэдгээрийн өгөөж болон эрсдлийг хэрхэн үнэлэх, хөрөнгө оруулалтын шалгуурын талаар илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсч байгаа бол Хавсралт 9-өөс уншаарай.

2.6. Ирээдүйдээ хийх хөрөнгө оруулалт буюу даатгалын тухайд

Энэ бүлгийн өмнөх хэсгүүдэд бид олсон орлогоо хэрхэн өсгөх боломжийн талаар ярилцсан. Харин энэ хэсэгт орлогынхoo бага гэлтгүй хэсгийг зөв зохистой хэрэглэх нэгэн хувилбарын талаар товч танилцуулья. Орлогоо ухаалгаар зарцуулах нэг хэрэгсэл нь даатгал юм.

Энэ нь учирч болох аливаа эрсдлийг хохирол багатай даван туулахад чиглэсэн хөрөнгө оруулалт юм. Хэрэв гэрт хулгай орсон бол даатгал алдсан зүйлийг нөхөж өгнө. Хэрэв Танд эмчилгээ шаардлагатай бол эрүүл мэндийн даатгалаас эмчилгээний мөнгө болон Таны ажиллаж чадаагүй үеийн орлогыг нөхөн олгоно. Хэн нэгэн нас барвал түүний ар гэрт даатгалын мөнгө олгох болно.

Гал түймрийн улмаас 2008 онд 395 гэр байшин, 116 машин техник шатаж иргэд их хэмжээний хохирол амсчээ. Түүнчлэн автозамын ослын улмаас жилдээ 300 гаруй хүн амиа алдаж, 800 гаруй хүн бэртэж гэмтэн хөдөлмөрийн чадвараа тодорхой хувиар алдсан гэсэн тоо баримт байна. Үүний улмаас айл өрх, хувь хүнд учирсан хохирол хэдэн зуун саяар тоологдоно. Хөгжингүй орнуудад иймэрхүү хохирлыг даатгалаас нөхөн төлдөг учраас даатгалын ач холбогдлыг хүн бүр мэдэрдэг.

Өндөр хөгжсөн оронд даатгал айл өрх, албан байгууллага, хүн бүрийн нэн чухал хэрэгцээ болж чадсан байдаг бөгөөд өрхийн төсөв, хувийн санхүүгийн төлөвлөгөө зохиохдоо заавал оруулдаг зардлын нэг зүйл болсон байдаг. Харин манайд даатгал нь харьцангуй шинэ, хүн бүр ач холбогдлыг нь ойлгоогүй байгаа учир даатгалын хэрэгцээ шаардлагын талаар иргэддээ зөв ойлголт өгөх нь нэн чухал асуудал болоод байна. Даатгалын зах зээл, даатгалын байгууллагууд, төрийн зохицуулалтын талаар тавдугаар бүлэгт дэлгэрүүлэн авч үзэх болно.

2 ДУГААР БҮЛЭГ. МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ АСУУЛТУУД

1. Та 1,000,000 төгрөг хуримтлуулж чадсан бол цаашид өсгөхийн тулд ямар хөрөнгө оруулалт хийх боломжууд байгаага жагсааж бичнэ үү?
2. Хадгаламж хийх банкаа сонгохын тулд Та ямар шалгуурыг эхний ээлжинд чухаллах хэрэгтэй вэ? Уг шалгуураа тогтоохын тулд ямар мэдээлэл хаанаас авч болох вэ?
3. Хадгаламжийн хувьд Банкаар эсвэл ХЗХ-оор үйлчлүүлэх хоёр хувилбарыг харьцуулна уу.
4. Компаний бонд, эсвэл хувьцаа худалдан авахын давуу болон сул талыг харьцуулна уу.
5. Шууд хөрөнгийн зах зээлд оролцох, эсвэл хөрөнгө оруулалтын сангаар дамжуулж оролцохын ялгааг тайлбарлана уу.


III БҮЛЭГ.

Танд мөнгө шаардлагатай бол...

Энэ бүлгийг судалснаар:

- Танд мөнгө буюу санхүүжилт шаардлагатай болсон тохиолдолд, санхүүгийн ямар байгууллагад хандахаа,
- Зээлийн үйлчилгээ үзүүлдэг банк, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагуудын олгодог зээлийн онцлог, зээл авахад анхаарах зүйл, бүрдүүлэх материал зэргийг,
- Зээлээ эргэн төлөх хариуцлага, төлөөгүйгээс бий болох эрсдэл, үр дагаврыг;
- Хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргаж хөрөнгө босгох боломжийн тухай мэдэх болно.

Энэ бүлэгт Танд мөнгө эсвэл ямар нэг эргэлтийн хөрөнгө хэрэгцээтэй болсон тохиолдолд асуудлаа шийдвэрлэх хувилбарууд, санхүүгийн байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний төрөл, тэдгээр нь юугаараа ялгаатай байдаг талаар авч үзэх болно.



Бизнесээ эхлэх, өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг Та зээл хэлбэрээр авч болох бөгөөд энэ төрлийн үйлчилгээг банк, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ) үзүүлдэг. Түүнчлэн зөвхөн зээлийн аргаар биш өөр арга замаар худалдан авалт, хөрөнгө оруулалтаа санхүүжүүлэх боломж нь факторинг болон лизингийн үйлчилгээ юм. Эдгээр боломжийг банк, ББСБ болон зарим тохиолдолд лизингийн компаниуд олгодог. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг үнэт цаасаа нийтэд санал болгох (IPO) замаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд энэ тохиолдолд үнэт цаасны мэргэжлийн пүүс компани, тухайлбал, андеррайтерийн үйлчилгээг авч болно.

3.1. Санхүүжилт: Зээл

3.1.1. Банкны сектор

Монгол Улсад 1990-ээд оноос өмнө төрийн мэдлийн ганц банк байв. Тус банкнаас олгогдож байсан зээлүүд нь ихэвчлэн захиргаадлын шинжтэй, мөн үндсэн үйл ажиллагааны нэг нь тухайн үеийн гол зорилт болох аж үйлдвэрийн бааз байгуулах ажлыг санхүүжүүлэхэд чиглэгдэж байжээ. Ерөнхийдөө мөнгө, валютын бодлогын хувьд тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсаас ихээхэн хараат байв.

1990-ээд оны эхээр хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжив. Ингэснээр Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, харин шинээр үүссэн арилжааны банкууд төр болон хувийн хэвшилд хадгаламж, зээл, төлбөр тооцоо гэх зэрэг үйлчилгээг үзүүлнэ хэмээн чиг үүргээрээ ялгарчээ. Хоёр шатлалт банкны тогтолцоо үүсэн бий болсноор Монгол Улсын эдийн засгийн амьдралд цоо шинэ хуудас нээгдсэн юм.

Монгол Улсад 1990-ээд оноос хойш 30 гаруй банк үүсэн байгуулагдаж байсан хэдий ч, эрхзүйн орчны болон удирдлага хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлээгүйн улмаас цөөнгүй банк дампуурч, үүд хаалгаа барьж байв. Өнөөдөр дээрх 30 банкны тал орчим нь хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

2000 оноос эхлэн банкны секторт гадаадын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж банкуудын удирдлага, зохион байгуулалтад ч эергээр нөлөөлж эхэлсэн юм. Тухайлбал, 2000 онд Монголын нийт арилжааны банкууд 2000 хүрэхгүй зээлдэгчдэд 70 орчим тэрбум төгрөгийн зээл олгож байв. Харин 2008 оны эцсийн байдлаар нийт зээлдэгчдийн тоо 530 мянга, нийт зээлийн дүн 2.5 их наяд төгрөгт тус тус хүрсэн байна.

2008-2009 онд арилжааны банкуудын байдал эрс хүндэрсэн нь өмнөх жилүүдийн төрийн төсөв, мөнгөний оновчгүй бодлого, мөн дэлхийн санхүүгийн хямралын сөрөг нөлөөтэй холбоотой гэж мэргэжилтнүүд үздэг. Ойрын ирээдүйд Монголын банкууд нэгдэх, томрох зэргээр хүчээ авч, эдийн засаг, санхүүгийн амьдралд үзүүлэх нөлөө нь улам бүр өсөх хандлагатай байна.

3.1.2. Арилжааны банкны зээл

Банк нь харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг мэдэрч тэдний итгэл дээр тулгуурласан үйлчилгээ үзүүлдэг ашгийн төлөө байгууллага юм. Харин иргэд, аж ахуйн нэгж (ААН)-үүдэд ямар хэрэгцээ шаардлага байдаг вэ? Иргэн, өрхийн хувьд эд зүйл худалдан авах, хүүхэддээ боловсрол олгох, бизнесээ эхлэх, өргөжүүлэх, мөнгө гүйвуулах, төлбөр тооцоог бэлэн болон бэлэн бусаар гүйцэтгэх, мөнгөө хадгалуулах гэх зэргээр төрөл бүрийн хэрэгцээ үүсдэг.

Энэ хэсэгт бид санхүүжилт хэрэгтэй болсон үед санхүүгийн байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний талаар илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

Зээл гэж юу вэ? Хуулийн хэллэгээр зээл нь хоёр этгээдийн хооронд үүсч буй гэрээний харилцаа бөгөөд дараах байдлаар тодорхойлдог. “Зээлдэгч нь тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг гэрээнд заасан хугацаа, нөхцлийн дагуу зээлдүүлэгчээс хүлээн авч, тохиролцсон хугацаанд, хүүгийн хамт зээлдүүлэгчид буцаан төлөх үүрэг хүлээдэг. Өөрөөр хэлбэл, зээлдэгч болон зээлдүүлэгчийн хооронд эрх, үүргийн харилцаа үүсч байна. Зээлдүүлэгч нь ихэнх тохиолдолд банк, ББСБ, ХЗХ, эсвэл хувь хүн, ААН байдаг.

3.1.3. Банкны зээлийн төрлүүд

Банкууд олон төрлийн зээлийн бүтээгдэхүүн санал болгодог хэдий ч тэднийг үндсэнд нь хэрэглээний, бизнесийн гэж хоёр ангилж болно. Иргэд зурагт, хөргөгч, гэрийн тавилга, орон сууц, машин зэрэг өндөр үнэтэй зүйлс худалдан авахын тулд банкнаас зээл авах нь түгээмэл байдаг. Эдгээрийг бүхэлд нь хэрэглээний зээл гэж үзнэ. Харин бизнесийн зээл нь илүү орлого бий болгох аж ахуйн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд чиглэгдэнэ. Тухайлбал, эргэлтийн болон үндсэн хөрөнгө худалдан авах, эсвэл тодорхой нэг төсөл, бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилготой байдаг.

3.1.3.1. Хэрэглээний зээл

а) Цалингийн зээл: Тогтмол орлоготой иргэд цалингаасаа сар бүр тодорхой хувиар төлж барагдулахаар авдаг зээл юм. Иргэн уг зээлийг банкнаас авахын тулд ажиллаж байгаа байгууллагаасаа цалингийн тодорхойлолтоо авах буюу тухайн зээлийг төлөх чадвартай гэдгээ нотлох хэрэгтэй. Сүүлийн үед банкууд үүнийгээ нийгмийн даатгалын дэвтрийн хуулбараар нотлохыг санал болгодог болсон.



б) Боловсролын зээл: Энэ нь ихэвчлэн дунд хугацаатай байдаг бөгөөд нийгэм, эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой зээл юм. Үүнд:

- Энэхүү зээлийг сургалтын төлбөрөө төлөх зорилгоор авах ба тухайн оюутан суралцаж мэргэжил эзэмшсэнийхээ дараа ажил хийж цалингаасаа төлөх нөхцөлтэй байдаг.
- Оюуны өндөр чадавхитай боловч хөрөнгө мөнгөний хүрэлцээгүйгээс сурах боломжгүй залууст сурах боломж олгодог.
- Залууст биеэ дааж, хариуцлага хүлээх дадал чадвар төлөвшүүлдэг.

Боловсролын зээлийг авахад банк-сургууль-оюутан гурвалсан гэрээ байгуулдаг. Сургууль нь тухайн оюутан амжилттай сайн суралцаж байгааг нотлохоос гадна өөр сургуульд шилжих, сургуулиас гарах тохиолдолд банкинд мэдээлэх үүрэг хүлээнэ.



в) *Орон сууцны зээл:* Орон сууц өндөр үнэтэй байдаг учраас банк энэ зээлийг урт хугацаагаар олгодог. Зээлдэгч мөнгөө төлөхгүй байх эрсдлээс сэргийлж орон сууцыг нь барьцаалдаг. 2009 оны 7 дугаар сарын 9-нд Улсын Их Хурал “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хууль баталсан. Орон сууцны зээл авсан тохиолдолд орон сууцыг барьцаалахтай холбогдсон харилцааг энэ хуулиар нарийвчлан зохицуулж байна.

Зээлдэгч нь худалдан авах орон сууцныхаа үнийн дүнгийн тодорхой хэсгийг (тухайн банк мөнгөний хэмжээг тогтоодог) урьдчилан төлсөн байхыг шаарддаг. Зээлээ урт хугацаанд цалин болон түүнтэй адилтгах орлогоосоо сар бүр төлж барагдуулдаг. Сар бүр төлөх үндсэн зээл болон түүний хүүгийн хэмжээ нь тухайн гэр бүлийн амьдралд дарамт болохгүй хэмжээнд тогтоогдох ёстой. Тухайн гэр бүл зээлээ төлөхийн зэрэгцээ амьжиргааны мөнгөөр гачигдахгүй байж чадах орлоготой юу гэдгийг банк сайтар судалж, ихэнх тохиолдолд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ өрхийн сарын орлогын 30-40 хувиас хэтрэхгүй байхаар бодож зээл олгодог.

Жишээ. Шинэхэн гэрлэсэн залуу хос хүүхэдгүй, хоёулаа ажил хийдэг бөгөөд сарын орлого нь 600,000 төгрөг гэж үзье. Тэд эхний ээлжинд нэг өрөө орон сууцтай болох зорилго тавьж, сар бүр орлогынхаа хагасыг буюу 300,000 төгрөгийг банкинд хадгалуулдаг. Хүүгийн орлогыг нь тооцохгүйгээр нийт хуримтлал нь хоёр жилийн дараа 7,200,000 төгрөг болно. Энэ нь 30 сая төгрөгийн үнэтэй нэг өрөө орон сууц авах урьдчилгаа төлбөрийн 20 хувь буюу 6,000,000 төгрөгийг төлөх боломжийн хуримтлал юм. Залуу хос маань 3-4 жилийн турш ийм хэмжээгээр хадгаламж хийвэл илүү том талбайтай ч юм уу, бүр хоёр өрөө байр ч худалдан авч чадна. Сар бүр хуримтлал хийж чаддаг, санхүүгийн хариуцлагатай гэр бүл гэдгээ банкиндаа нотолж чадсан нь зээл олгоход харгалзан үзэх эерэг үзүүлэлт болно. Өөрөөр хэлбэл, хосууд зээлээ төлөхдөө ч бас ийм хэмжээний орлого олж, тийм хэмжээний төлбөр төлж чадахаа банкиндаа харуулсан гэсэн үг. Залуус энэ тохиолдолд ажилдаа ч илүү хариуцлагатай хандаж, цалингаа нэмэгдүүлэхийн төлөө сайн ажиллана, ур чадвараа дээшлүүлж өөрийгөө хөгжүүлнэ. Нэг, хоёр жилийн дараа цалин орлого нь нэмэгдэнэ. Санхүүгийн хувьд бэрхшээлгүй болсон үедээ хүүхэдтэй болохоор гэр бүлээ төлөвлөж болно. Энэ залуу гэр бүл өрхийн санхүүгээ эхнээс нь төлөвлөж чадсан хэрэг. Эхнээсээ л олдсоноо үрээд заншчихсан зарим залуу гэр бүлтэй харьцуулахад энэ хоёр амьдралаа илүү оновчтой зохион байгуулж чадна. Айлын хажууд, эсвэл гэр хороололд амьдарч байгаа бол өнөөдөр ч Та орон сууцтай болох зорилго тавьж, санхүүгээ төлөвлөн энэ залуу гэр бүлээс үлгэр авахад оройтоогүй ээ.

Орон сууцны зээл авахдаа анхаарах зүйлийг энэ номын Хавсралт 11-ээс дэлгэрүүлж уншаарай.

3.1.3.2. Бизнесийн зээл

а) Үндсэн хөрөнгийн зээл: Энэ зээлийг үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгө худалдан авахад зориулж олгодог бөгөөд уг зээл нь урт хугацаатай, хэсэгчлэн төлөгддөг онцлогтой. Үндсэн хөрөнгийг ашиглаж олох орлогоос зээл төлөгднө. Зээл зориулалтаараа ашиглагдах боломж бүрдүүлж байгаа тул эрсдэл багатай зээлд тооцогддог.

б) Эргэлтийн хөрөнгийн зээл: Энэ зээлийг үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд, материал худалдан авахад зориулж олгодог бөгөөд харьцангуй богино хугацаатай, ихэвчлэн нэг мөсөн төлөгддөг онцлогтой.

в) *Худалдааны зээл*: Барааг бөөнөөр аваад бөөнөөр зarah, эсвэл бөөнөөр аваад жижиглэнгээр зarah зориулалтаар зарим нэг банк энэ зээлийг олгодог.



г) *Хөдөө аж ахуйн зээл*: Улирлын шинж чанартай үйлдвэрлэлд олгож байгаагаараа онцлогтой. Газар тариалангийн зээлийг ихэнхдээ хавар авч намар төлдөг. Гэхдээ газар тариалангийн зориулалттай машин, техник худалдан авах тохиолдолд хугацаа нь урт, харин үрийн буудай, ногоо худалдан авч байгаа бол хугацаа нь богино байдаг.

д) *Барилгын зээл*: Орон сууц барих зорилгоор компаниуд зээл авч барилга бариад, түүнийгээ худалдаж зээлээ төлдөг. Тэдгээр компанийн барьсан байрнаас хүмүүс худалдан авахдаа мөн зээлээр авч болно.

Жишээ: Барилгын “Од” компани “Оргил” банкаас зээл авч орон сууцны барилга барилаа гэж бодъё. Тодорхой хугацааны дараа “Од” компани орон сууцаа бариад нийтэд зарлана. Иргэн Надмид энэ орон сууцнаас авахаар шийдсэн бол “Оргил” банкинд хандаж орон сууцны зээл авна. Авсан зээлээрээ орон сууцны төлбөрөө хийхэд “Од” компани банкаас авсан зээлээ эргэн төлнө.

3.1.4. Зээл авахад анхаарах зүйл

Зээл авахдаа анхаарвал зохих зарим зөвлөгөөг толилуулж.

1. Ихэнх арилжааны банкууд эхэлж байгаа бизнесийг санхүүжүүлдэггүй

Иймд өөрийн хөрөнгөөр бизнесээ эхэлсэн байхыг хичээх хэрэгтэй. Бизнес хийдгээ батлахын тулд орлого, зарлагаа тэмдэглэсэн дэвтэр хөтлөх хэрэгтэй. Энэ дэвтэр нь тогтмол үйл ажиллагаа эрхэлдэг гэдгийг батлах ба зээл авбал юунд зориулах гэж байгааг тань мэдэх боломжтой болгодог. Мөн зээл олговол эргэн төлөх орлоготой гэдгийг ч батлах болно. Энэ бол “хар дэвтрийн арга” юм. Харин Та бизнес хийдгээ банкаар нотлуулбал бүр сайн. Үүний тулд харилцах данс болон картандаа өдөр бүр орлого хийх хэрэгтэй. Тэр мөнгөнөөсөө зарлагын гүйлгээ хийж болно. Ингэснээр Та байнгын бизнестэй, орлоготой гэдгээ банкинд дансны хуулгаараа нотлох болно.

2. Эхэлж буй бизнест туслалцаа үзүүлэх төрийн болон төслийн байгууллагууд

Жижиг дунд үйлдвэрийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг төрийн байгууллагууд, мөн нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвүүдээс зөвлөгөө тусlamж авч болно. Зарим аймаг, дүүргүүд дэргэдээ бизнесийн бойжуулах төв буюу инкубатор ажиллуулдаг.

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг, МерсиКор, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Хөгжлийн шийдэл ТББ, Монгол-Японы төв зэрэг байгууллагууд зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд зээлийн баталгаа гаргах зэргээр үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн ХААН, Хас зэрэг арилжааны банкууд хөнгөлөлттэй нөхцөл бүхий бичил зээл олгох нь бий. Дэргэдээ инкубатор болон бизнесийн зөвлөгөө өгөх төв ажиллуулдаг банкуудын тоо өссөөр байна.

3. Орлого бүтээх зүйлд л зээл ав

Дэлхийн зөн олон улсын байгууллагын бичил зээлийн газраас үсчин эмэгтэй зээл авсан бодит жишээ байдаг. Тэр үсчин өдөрт 50-80 мянган төгрөгийн орлоготой хирнээ угаалгын машин авах зорилгоор зээл авах хүсэлт гаргажээ. Зээлдүүлэгч “өдрийн орлогоо хадгалж байгаад угаалгын машин авах боломж байгаа юм биш үү” гэж сонирхоход “Би их үрэлгэн хүн байгаа юм. Олсон орлогоо хэрэгтэй хэрэггүй юм авах, эргүүлж өгдөггүй хүнд зээлүүлэх, ах дүү,

найз нөхөддөө тав гурван төгрөг өгөх зэргээр үрчихдэг. Мөнгөө зорилготой хэрэглэхийн тулд зээлээр угаалгын машин авъя. Тэгвэл зээлээ төлөх гээд элдвийн зүйлд үрэхгүй гэж бодож байна" гэсэн байдаг. Үсчин эмэгтэй зээлээр худалдан авсан угаалгын машинаар үс засахдаа хэрэглэдэг гар нүүрийг алчуур зэргээ угааж үйл ажиллагаагаа хөнгөвчлөн, чанаржуулж тэгснээрээ илүү их орлого олох боломж бий болгосон байна. Дээрх жишээ нь зээлийг орлого бүтээх зориулалтаар авах хэрэгтэйг харуулж байна.

4. Зээлийн үр ашгийн тооцоог заавал хий

Үүний тулд Бизнес төлөвлөгөөгөө сайн хийсэн байх ёстой. Төлөвлөгөөнд:

- Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр
- Үйлдвэрлэх хэмжээ
- Худалдах үнэ
- Гарах зардал
- Тогтмол зардал
- Хувьсах зардал
- Олох орлого
- Цэвэр орлого зэргээ тодорхой хугацаагаар төлөвлөж оруулах нь зүйтэй.

Бизнес төлөвлөгөө нь бодитой, зээлээ төлөөд ашигтай ажиллах боломжийг итгэл үнэмшилтэй тусгасан байвал банк зээл олгохдоо харгалzan үзэх чухал нөхцлийн нэг болно.

5. Барьцаа, батлан даалт зэрэг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах аргаа сонгох нь чухал

Бизнес бүхэн эрсдэлтэй байдаг учраас зээлдүүлэгч хөрөнгийн барьцаа шаарддаг. Зээлдэгч үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд барьцааны зүйлийг борлуулж орлогоос нь төлөгдөөгүй зээл, түүний хүү зэрэг уг гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг ханггуулдаг. Зээлээ төлж дууссан үед барьцааг чөлөөлнө. Барьцаалах хөрөнгийг үнэлүүлсэн байх ёстой. Уг үнэлгээний тодорхой хувиар олгох зээлийн хэмжээг тогтоодог. Энэ хувийг барьцаа хөрөнгийг борлуулах боломж буюу эдийн засгийн хэлээр хөрвөх чадварыг харгалzan тогтоодог.

Тухайлбал, машин барьцаалан зээл авахад ихэнх банк төвөггүй зарагдаж болох үнийх нь 50 хувьтай тэнцэх зээл олгодог. Зах зээл

дээр 6 сая төгрөгийн үнэтэй машины төвөггүй зарагдах үнэ нь 5 сая төгрөг гэвэл уг машиныг барьцаалж 2.5 сая төгрөг зээлж болно. Зээл эргэн төлөгдөх боломжгүй боллоо гэж үзвэл машиныг борлуулж, уг орлогоос зээлийг хүүгийн хамт төлүүлнэ.

Шаардлага хангасан алтан гулдмай барьцаалбал үнийн дүнгийн 95 хувьд нь зээл олгодог. Учир нь энэ нь маш хурдан борлогдож мөнгө болон хөрвөх чадвартай. Өөрөөр хэлбэл, барьцаа хөрөнгийн үнийн хэдэн хувьтай тэнцэх хэмжээний зээл олгох вэ гэдэг нь тухайн хөрөнгийн борлогдох чадвараас хамаардаг.

Хөдөө орон нутагт зээлийн барьцаанд мал авдаг. Мал нь нэг талаас хөдөлмөрийн хэрэгсэл, нөгөө талаас хэрэглээний зүйл учир эрсдэл өндөртэй хөрөнгө гэж үзэж зах зээлийн үнийн багахан хувьд зээл олгодог.



Зээлдэгч үүргээ биелүүлж чадахгүй бол түүний хүлээх үүргийг бүрэн буюу хэсэгчлэн хариуцна гэж гуравдагч этгээд банкны өмнө батлан даалт гаргадаг. Зээлдэгч үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд батлан даагч түүний хүлээх үүргийг банкны өмнө хариуцах ба энэ тухай баримтыг банк түүнд олгоно. Үүний дараа батлан даагч нь тэрхүү баримтыг үндэслэн гүйцэтгэсэн үүргийнхээ хэмжээгээр зээлдэгчээс шаардах эрхтэй байдаг.

6. Зээлийн эргэн төлөлтөө анхаарах

Зээл авахын тулд зээлийн хугацаа, үндсэн өр, хүүгээ ямар хугацаанд эргэн төлж чадахаа аж ахуйн үйл ажиллагааны “Бизнес төлөвлөгөө”-гөө харж байж шийдээрэй. Иргэн Болд 12 сарын хугацаатай, сарын 2 хувийн хүйтэйгээр 5 сая төгрөг зээлсэн байна.

Хувилбар 1: Болд үндсэн төлбөр болох 5 сая төгрөгөө хугацааны эцэст буюу 12 сарын дараа, харин зээлийн хүүд сар бүр 100,000, жилд 1,200,000 төгрөг төлөхөөр болжээ. Болд худалдан авсан тоног төхөөрөмжөө ашиглан бүтээмж нь сайжирч сард 3 сая төгрөгийн орлого олох боломжтой болно. Зээлийн хүүгийн сарын төлбөр 100,000, мөн бусад зардал 2,2 сая төгрөг болно гэвэл сард 700,000, жилд 8,4 сая төгрөгийн ашигтай ажиллах боломжтой. Энэ тохиолдолд зээлийн үндсэн төлбөр 5 сая төгрөгөө төлөөд зогсохгүй, жилийн 3,4 сая төгрөгийн ашигтай ажиллаж, мөн өөрийн гэсэн тоног төхөөрөмжтэй болох юм.

Хувилбар 2: Болд зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр болох 5 саяа 12 сарын дараа бус олсон орлогоосоо сар бүр 400,000 төгрөгөөр төлж чадвал 2 дахь сараас эхлээд сард төлөх зээлийн хүү нь 92,000 ($5,000,000-400,000) \times 2\% = 92,000$) мянган төгрөг болж буурна.

Ийнхүү жилд 1,200,000 төгрөгийн хүү төлөх байсан бол сар бүр орлогоосоо зээлийн үндсэн төлбериийг төлснөөр жилд зээлийн хүүгийн зардалд нийт 680,000 төгрөг төлж 520,000 төгрөг хэмнэх боломжтой болно.

3.1.5. Зээл авахад бүрдүүлэх материал

Банк бүр өөр өөрийн журмын дагуу зээл авахад бүрдүүлвэл зохих материалын жагсаалтыг гаргасан байдаг. Арилжааны банкууд ерөнхийдөө дараах материал бүрдүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Зээл авахыг хүссэн өргөдөл
- Зээлийн барьцаанд тавих хөрөнгө
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа
- Зээлийн үр ашгийн тооцоо
- Зээлдэгч нь аж ахуйн нэгж бол татварын албаар баталгаажуулсан санхүүгийн тайлан

Зээлийн өргөдөл дараах мэдээллийг багтаасан байх ёстой:
Үүнд:

1. Зээл хүсэгчийн товч танилцуулга

Зээл хүсэгч нь иргэн бол овог, нэр, паспорт, регистрийн дугаар, хаана, ямар ажил эрхэлдэг, энэ ажлыг хэдэн оноос эхлэн хэдэн жил эрхэлж байгаа, хэрэв аж ахуйн нэгж бол дээрх зүйлсийг дурьдахын хамт аж ахуйн нэгжийн оноосон нэр, гэрчилгээний дугаарыг заавал бичсэн байна.

2. Зээл авах шаардлага буюу зориулалтын талаар

3. Зээлийн хэмжээ, зээлэхийг хүсч буй хугацаа, хүүгийн талаар

4. Зээлийн барьцаанд тавих хөрөнгийн нэр, түүний эзэмшлийн эрхийг тодорхойлсон гэрчилгээ

5. Гарын үсэг, аж ахуйн нэгж бол тамга дарна.

3.1.6. Зээлээ төлөөгүйгээс үүсэх эрсдэл

Банкны шаардлагыг хангаад зээл авч чадна гэдэг анхны чухал алхам. Дараа нь эргэн төлж чадах уу гэдэг нь санаа зовох гол асуудал. Бизнес төлөвлөгөөгээ хэр бодитой хийсэн нь зээл төлөх үед тод харагдана. Байнгын орлого олж чадах зүйлд зээл авсан бол орлогоосоо тодорхой хугацаанд тогтмол төлж чадна. Тодорхой хугацааны дараа орлого нь бөөнөөр орж ирэх бизнесийн хувьд зээлийг нэгмөсөн төлөх боломжтой. Ихэнх тохиолдолд хүүгийн төлбөрийг тогтмол хийх ёстой байдаг.

Зээл төлөх графикаа зээлийн гэрээнд тусгадаг бөгөөд энэ графикийн дагуу төлөхгүй бол банк бүх төлбөрийг хугацаанаас нь өмнө төлүүлэхийг шаардах эрхтэй байдаг. Тэр ч бүг хэл, зээл болон хүүгээ хугацаа хожимдуулж төлвөл банк нэмэгдүүлсэн хүү тооцож авах эрхтэй. Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ нь үндсэн зээлийн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй байхаар гэрээгээрээ тогтооно гэж хуульд заасан байдаг. Хэдийчинээ урт хугацаагаар үүргээ биелүүлэхгүй хойш тавина, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ төдий хэмжээгээр өснө гэдгийг анхаарах хэрэгтэй. Хугацаандаа төлбөрөө хийхгүй удах тусам Та авсан зээлээсээ илүү, заримдаа нэг хоёр нугалахуйц хэмжээний нэмэгдүүлсэн хүүгийн өрөнд орно.

Бүр төлж чадахгүйд хүрвэл банк барьцаанд тавьсан хөрөнгийг худалдаж, зээл болон хүүгийн төлбөрөө авна. Барьцаалсан хөрөнгийг яаралтай зарвал хүрэх үнээс хамаагүй бага үнээр зarah болно. Ийм л эрсдэл хүлээж байгааг анхнаасаа сайн тооцох нь зүйтэй.

2009 оны 7 дугаар сарын 9-нд батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-д зээлээ төлж чадахгүй, барьцааны зүйлийг худалдахад хүрвэл шүүхээр, эсвэл шүүхээс гадуур шийдвэрлэх үү гэдгээ барьцааны гэрээ байгуулах үедээ тохиролцох ёстойг заасан. Барьцаалагч нь банк, зээлийн эрх бүхий санхүүгийн байгууллага байгаа тохиолдолд л талууд барьцааны хөрөнгөөс төлбөрийг гаргуулахдаа шүүхээс гадуур шийдвэрлэхээр тохиролцож болно. Хэрэв шүүхээс гадуур шийдвэрлэхээр заасан бол дараах хоёр аргын нэгээр барьцааны хөрөнгийг борлуулна:

1. Барьцааны хөрөнгийг талууд тохиролzon шууд худалдана.
2. Дуудлага худалдаагаар борлуулж болно.

Зээлдэгч зээлээ төлж чадахгүй болсон тохиолдолд боломжийн үнээр тохиролzon барьцааны хөрөнгийг борлуулах нь зээлдэгчид илүү тохиромжтой хувилбар юм. Учир нь дуудлага худалдаа амжилтгүй болсон тохиолдолд барьцаалагч барьцааны хөрөнгийн үнийг үлэмж бууруулж өрөндөө тооцож авах боломжтой байдаг. Мөн шүүхийн журмаар шаардлага хангуулахаар тохиролцож болно. Цаг, зардал ихтэй, албадан дуудлага худалдаа амжилтгүй болох магадлал өндөр байдаг. Зээл авах, хөрөнгөө барьцаанд тавихдаа энэ бүгдийг сайтар бодолцож, шаардлагатай бол мэргэжлийн зөвлөгөө авч аль болох эрсдэл багатай байх боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.

3.1.7. ББСБ, ХЗХ-ны зээлийн онцлог

ББСБ нь “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуульд зааснаар зээл олгохоос гадна санхүүгийн олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Энэ талаар Хавсралт 13-аас илүү тодорхой мэдэж болно. Хадгаламж, зээлийн хоршоо нь гишүүддээ зээл олгодог. ББСБ болон ХЗХ-ны зээлийн үйлчилгээ банкныхтай ижил төстэй учир зээлийн нөхцөл, төрлийн талаар энд дахин нурших шаардлагагүй гэж үзлээ.

ХЗХ-г иргэд сайн дурын үндсэн дээр өөрсдийнхөө санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор байгуулдаг. Иймээс ХЗХ-ноос олгох зээлийн үйлчилгээ нь харьцангуй чирэгдэл багатай, шуурхай байдаг. Учир нь гишүүд бие бие сайн мэддэгтэй холбоотой.

ХЗХ нь гишүүддээ зээл олгоходоо дор дурдсан нөхцөл шаардлагыг тавих нь түгээмэл байдаг. Үүнд:

- Үйл ажиллагаагаа тодорхой хугацаанд тогтвортой эрхэлсэн байх
- Бусад хоршоо, байгууллага хүмүүст зээл, өр төлбөргүй байх
- Зээлийг зориулалтын бус зүйлд зарцуулахгүй байх
- Хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх.

Олгох зээлийн хэмжээ, төлөх хугацаа зэргийг зээлдэгч болон зээлдүүлэгч байгууллага харилцан тохиролцож зээлийн гэрээнд тусгана.



Нэг сарын хүү нь:
 $15,000,000 \times 3\% : 100\% = 450,000$. Энэ нь Таны
мөнгөн хөрөнгийн хэрэгцээг
хангаад зогсохгүй үйл
ажиллагааг тань өргөтгөх
боломжтой юм.

Наран хоршооноос 15,000,000
төгрөгийг сарын 3 хувийн хүүтэй,
1 жилийн хугацаатай зээлжээ.

Хадгаламж зээлийн хоршооноос зээл хүссэн өргөдлийг хэрхэн шийдвэрлэдэг талаар илүү дэлгэрэнүй мэдээллийг Хавсралт 12-оос уншина уу.

3.2. Санхүүгийн үйлчилгээний бусад төрлүүд

Банк санхүүгийн байгууллага нь зөвхөн хадгаламж, зээлийн үйлчилгээнээс гадна бусад төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг.

3.2.1. Лизинг

Санхүүгийн түрээс буюу лизинг нь бизнес эрхлэгчдэд тоног төхөөрөмж худалдан авах боломж олгодог. Санхүүгийн түрээсийн зээлээс ялгагдах онцлог нь зээлдэгчийн сонирхсон тоног төхөөрөмжийг зээлдүүлэгч өөрөө худалдан аваад түрээсээр хэрэглүүлдэг. Харин зээлээр худалдан авсан тоног төхөөрөмж нь шууд зээлдэгчийн өмчлөлд шилждэг учраас зээлдүүлэгчийн хувьд илүү эрсдэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, санхүүгийн түрээсийн үед тоног төхөөрөмжийн үнэ төлөгдөж дуусах хүртэл зээлдэгч өөрөө өмчлөгч нь байдгаараа онцлогтой. Иймээс зээлдэгчид учрах эрсдэл нь бага учир зээлийн нөхцөл нь илүү тааламжтай байдаг.

Санхүүгийн түрээс нь компаниудад үндсэн хөрөнгөтэй болох, тоног төхөөрөмжөө шинэчлэх, бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодит бололцоо олгодог.

ББСБ-ын санхүүгийн түрээсийн үйлчилгээ гэдэг нь Таны сонгосон түрээсийн зүйл (жишээлбэл, машин)-ийн үнийг ББСБ-аас нийлүүлэгч (машин борлуулдаг компани)-д шилжүүлж, харин Та түрээсийн төлбөрийг ББСБ-д төлөх нөхцөлтэйгөөр тухайн түрээсийн эд хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэхэд зориулан олгогдох нэг төрлийн зээл юм. Үүнийг схемээр харуулбал:



Энэ үйлчилгээ нь санхүүжүүлэх хэрэгсэл гэдэг утгаараа зах зээл дэх санхүүгийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх төдийгүй, бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн боломж олгож, цаашилбал дотоодын үйлдвэрлэл болон эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох үйл явцыг дэмждэг ач холбогдолтой.

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ нь зээлтэй харьцуулбал түрээслэгчийн (жижиг, дунд үйлдвэрлэгч) хувьд илүү урт хугацаатай, харьцангуй бага зардалтай санхүүжилтийн эх үүсвэрээс хүртэх боломж олгодог үндсэн давуу талтай. Үүнээс гадна санхүүгийн түрээсийн урьдчилсан төлбөр бага байдгийн зэрэгцээ нэмэлт барьцаа хөрөнгө шаарддаггүй тул зээлтэй харьцуулбал илүү боломжийг түрээслэгчдэд олгодог.

Санхүүгийн түрээсийн хугацаа дуусмагц түрээслэгч уг зүйлийг өмчлөх эрхтэй болно.

3.2.2. Факторинг

Факторингийн үйлчилгээ гэдэг нь баталгаажсан тооцооны баримт бичгийг үндэслэн авлагыг хямдруулан худалдан авах юмуу авлагыг барьцаалан зээл олгохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, факторингийн үйлчилгээ үзүүлэгч (Банк, ББСБ) нь өөрийн харилцагчийн худалдсан бараа, үзүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд төлөх ёстой хүлээгдэж буй мөнгөн төлбөр буюу авлагыг хямдруулан худалдаж авахад тэрхүү авлагыг барьцаалан зээл олгох санхүүгийн үйлчилгээний нэг хэлбэр юм. Энэхүү харилцааг доорхи схемээр харуулав. Уг харилцаанд “факторингийн үйлчилгээ үзүүлэгч”, энэ үйлчилгээг хүлээн авагч буюу “худалдагч”, “худалдан авагч” гэсэн 3 субъект оролцдог.



Дээрхи схемээс харахад:

- Худалдагч тал бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчид хүргүүлэх ба төлбөр хийх хугацааг тохирно (жишээ нь 3 сарын дараа);
- Худалдагч тал худалдан авагчаас бараа, бүтээгдэхүүний үнийг нэхэмжлэх эрхийг факторингийн үйлчилгээ үзүүлэгч (Банк, ББСБ)-д шилжүүлнэ;
- Факторингийн үйлчилгээ үзүүлэгч тал бэлтгэн нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний үнийн тодорхой хэсгийг (жишээ нь, 90 хүртэл хувийг) худалдагчид шилжүүлнэ;
- Худалдан авагчийн зүгээс бараа, бүтээгдэхүүний үнийг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид төлнө;
- Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь үлдэгдэл төлбөрийг худалдагч талд шилжүүлэх ба өөрийн үйлчилгээний шимтгэлийг суутган авна.

Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь авлагыг барьцаалан зээл олгохын өмнө хэрэглэгч төлбөрийн чадваргүй болж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж чадахгүй тохиолдол гарч болох эсэхийг харгалзан эрсдлээс хамгаалсан арга хэмжээ авах үүрэгтэй.

Факторингийн давуу тал нь:

- Хугацаанаас нь өмнө авлагаа авснаар хөрөнгийн эргэлтээ түргэсгэж, худалдааны эргэлтээ нэмэгдүүлнэ.
- Мөнгөн хөрөнгийн эргэлтийг хурдасгаж, ашиг орлогоо нэмэгдүүлэх, бизнесээ хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Авлагыг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлснээр цагаа хэмнэнэ.
- Найдвартгүй муу авлага, өр төлбөрөөс урьдчилан сэргийлж, эрсдлийг бууруулна.

Жишээ: Иргэн Туяа "AAA" компанид 50 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн бөгөөд төлбөрийг гурван сарын дараа хийхээр тохиролцжээ. Гэрээ байгуулснаас 10 хоногийн дараа Туяд яаралтай мөнгөний хэрэгцээ гарсан байна. Туяа "AAA" компаниас авах авлагаа ашиглан богино хугацааны санхүүгийн эх үүсвэр олох бололцоотой ю?

Энэ нөхцөлд Туяа "AAA" компаниас авлагаа гэрээнд тохиролцсон хугацаанаас өмнө барагдуулахыг хүсч, нэмэлт гэрээ байгуулахаар хандаж болно. Хэрэв "AAA" компани нь хугацаанаас өмнө төлбөрөө барагдуулж чадахгүй бол Туяа факторингийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хандаж болно.

Энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь Туяагийн "AAA" компаниас авах авлагыг хямдруулан авна. Хямдрал нь Туяд богино хугацааны санхүүжилт олох үйлчилгээ үзүүлсний төлбөр болно.

Энэхүү жишээг схемээр харуулбал:



Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь “ААА” компаниас Туяагийн авах 50 сая төгрөгийн авлагыг барьцаалан түүнд 47.8 сая төгрөгийг олговол факторингийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь урдчилгаа санхүүжилтийн төлбөр болгон Туяагаас 2.2 сая төгрөг авна.

Авлагаа хугацаанаас нь өмнө мөнгөн хөрөнгөд хөрвүүлэх эсвэл хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах зорилгоор факторингийн үйлчилгээг нийлүүлэгч, үйлчлүүлэгчдийн хооронд зуучлахад ашиглах боломжтой. Аливаа бизнесийн байгууллага нь худалдсан бараа, ажил үйлчилгээний төлбөрөө хурдан хугацаанд авах нь бизнесээ цааш хөгжүүлэх, худалдааны эргэлтээ нэмэгдүүлэх, шинэ бизнест хөрөнгө оруулах, түүнчлэн жижиг, дунд үйлдвэрлэл хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

АНХААРУУЛГА: Телевиз, сонинд “Барьцаа хөрөнгийг чөлөөлнө, хугацаа хэтэрсэн зээлийн өрөөс чөлөөлнө” гэсэн зар нэлээд гардаг. Энэ нь хугацаа хэтэрсэн зээлтэй этгээдийн өмнөөс зээлийн өрийг барагдуулан, барьцаа хөрөнгийг чөлөөлж, дараагийн Банк, ББСБ, ХЗХ-ноос арай илүү хэмжээний зээл авахад зуучлан, зуучилсан хөлсөө шинээр авсан зээлээс тодорхой хувиар суутган авах замаар орлого олдог албан бус үйл ажиллагаа юм. Зуучлагч ихэвчлэн ХЗХ-г сонгодог нь ХЗХ-нд тавих хяналт сул, зээлийн мэдээллийн санд мэдээлэл нь байдаггүйтэй холбоотой. Энэ нь төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлбэл зохих санхүүгийн үйлчилгээний нэг төрөл. Гэтэл хувь иргэд зөвшөөрөлгүй эрхэлж байгаа нь хууль бус ажиллагаа юм. Ашиг, хонжoo хайсан хууль бус энэхүү үйлчилгээг хөхиүлэн дэмжихгүй байх нь ухаалаг алхам бөгөөд Та болон танай гэр бүлийг эрсдэлтэй алхам хийхээс сэргийлнэ гэдгийг анхааралдаа авах нь зүйтэй.

3.2.3. Төлбөр тооцоо

Харилцагчдын хоорондын мөнгөн төлбөрийг гүйцэтгэхтэй холбоотой энэ үйлчилгээг банк, банк бус санхүүгийн байгууллага үзүүлдэг. Төлбөр тооцоог:

- Бэлнээр буюу үндэсний мөнгөн тэмдэгт болон валютаар
- Бэлэн бусаар буюу данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр гүйцэтгэдэг.

Төлбөр тооцоо хийх аргыг боловсронгуй болгохын тулд олон улсын хэмжээнд төрөл бүрийн картыг хэрэглэдэг. Манай арилжааны банкууд олон төрлийн карт гарган төлбөр тооцоог түргэн шуурхай, найдвартай байлгах чиглэлээр нэлээд зүйл хийж байна.

Карт ашиглан:

- төлбөр хийх,
- төлбөр хүлээн авах,
- хадгаламж хийх,
- зээл авах,
- бэлэн мөнгө авах гэх мэт санхүүгийн бусад үйлчилгээ авах боломжтой.



Картаар зөвхөн дотоодын оролцогчдын хооронд төлбөр тооцоо хийхээс гадна улс хоорондын гүйлгээнд мөн ашиглах боломжтой. Кartaар үйлчлүүлэх нь таны цаг завыг хэмнэнэ. Кartaа үрэгдүүлж гээгдүүлсэн тохиолдолд бусад этгээд түүнийг ашиглаж мөнгө авах боломжгүй тул аюулгүй талаасаа маш их ач холбогдолтой.

Мөнгөн гүйвуулга. Хөдөө орон нутгаас хот суурин газар байгаа хүүхдүүддээ, эсвэл гадаадаас ар гэр үрүүгээ мөнгө шилжүүлэхэд мөнгөн гүйвуулга өргөн хэрэглэгддэг. Энэ үйлчилгээг банкнаас гадна СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсан ББСБ үзүүлдэг.

Мөнгөн шилжүүлэг. Хүлээн авагчийн карт буюу банкин дахь данс уруу нь мөнгө шилжүүлэх үйл ажиллагааг мөнгөн шилжүүлэг гэнэ.

3.3. Санхүүжилт: Үнэт цаасаа нийтэд санал болгох (IPO)

3.3.1. Ерөнхий ойлголт

Сүүлийн үед компаниуд хөрөнгийн зах дээрээс мөнгө босгосон жишээ цөөнгүй бий. Шинээр байгуулагдсан компаний хувьд бизнесээс олж байгаа ашиг нь өдөр тутам өргөжиж бизнесийн үйл ажиллагааг нь санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй байх явдал цөөнгүй тохиолдоно.

IPO нь англиар *Initial Public Offering* гэсэн үгсийн товчлол бөгөөд монгол хэлнээ утгачилбал “анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох” гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, цөөн тооны хөрөнгө оруулагчидтай байсан компани өөрийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгох үйл ажиллагаа юм. Эрх зүйн талаас нь авч үзвэл, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэрээ өөрчилж, хувьцаат компани (ХК) болж байгаа хэрэг юм.

Дэлхийн хамгийн том IPO-г Хятадын Үйлдвэрлэл, худалдааны банкнаас 2006 онд хийсэн. Хятадын энэ банк нийтдээ 19 тэрбум долларын хөрөнгө татсан бөгөөд хувьцаагаа Хонг Конг болон Шанхайн хөрөнгийн биржүүдэд зэрэг гаргасан. Хятадын иргэд Хятад дахь хөрөнгийн биржүүдээс өөр газар хөрөнгө оруулалт хийх эрхгүй, харин гадаадын хөрөнгө оруулагчид Хятадын бирж дээрээс хувьцаа авах эрх нь хязгаарлагдмал байдаг тул ийнхүү хоёр хөрөнгийн бирж дээр хувьцаагаа зэрэг гаргасан байна.

Монголын компаниудын хувьд ч гэсэн хоёр биржид хувьцаагаа зэрэг гаргах, Монголын хөрөнгийн биржид гаргасан хувьцаагаа гадаадын хөрөнгийн биржид хадгаламжийн бичиг гэж нэрлэдэг санхүүгийн хэрэгслэлийн тусlamжтайгаар зэрэг арилжаалах боломж бий. Харин үүнийг хэрэгжүүлсэн компани одоохондоо алга байна.

Жишээ: НьюКо компани 1997 онд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан. Анхны хөрөнгө оруулагчид нь Бат, Туяа, Дорж нар байжээ. НьюКо компани эхэндээ Өмнөговь аймагт нүүрсний чиглэлээр уул уурхайн хайгуул явуулсан байна. Ингээд геофизикийн судалгаа явуулсны эцэст ихээхэн нөөцтэй байж болзошгүй орд олжээ. Цаашид нарийвчилсан хайгуул хийхэд шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтыг компанийхаа 51 хувийг гадаадын компанийд зарах замаар босгосон байна. Нийтдээ 100 гаруй гүний өрөмдлөг хийж дээжийг судалсны эцэст гарцаагүй ихээхэн хэмжээний нүүрстэй орд газар болох нь тогтоогдсон. Цаашид олборлолт хийхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй. Ийм хэмжээний хөрөнгийг анх үүсгэн байгуулагчид төдийгүй гадаадын хөрөнгө оруулагч ч дангаараа гаргах боломжгүй юм. Иймээс компанийхаа 60 хувийг олон нийтдэд санал болгох замаар хөрөнгө оруулалт татахаар шийдсэн. Ийнхүү хувьцаа шинээр гаргах хэмжээгээр өмнөх хувьцаа эзэмшигчдийн компанийд эзэмших хувь буурдаг. Энэ жишээнд анх Бат, Туяа, Дорж нар тус бүр компаний 33.3 хувийг эзэмшиж байсан гэж үзвэл шинээр хоёр удаа хувьцаа нэмж гаргасны дараа тус бүр 6.5 хувь орчим хувьцаа эзэмших болсон байна.

Үнэт цаас гаргах компаний үнэн зөв мэдээллийг ил тод болгох, хэрэгжих боломжтой бизнес төлөвлөгөөг нийтэд таниулах нь тухайн компаний удирдлагын хувьд хамгийн том хариуцлага, гаргаж буй үнэт цаас хэр амжилттай борлогдохын гол шалгуур болдог. Мөн Хөрөнгийн биржүүд тодорхой ангиллын үнэт цаасны бүртгэлийн шаардлагыг тодорхойлсон байдаг бөгөөд уг шалгуурыг хангах ёстой.

3.3.2. Андеррайтер (хөрөнгө оруулалтын банк) –ын үүрэг

Ихэнх компаний удирдлагууд өөрсдийн явуулж буй бизнесийн талаар сайн мэддэг боловч санхүүгийн зах зээлийн талаар гүнзгий мэдлэгтэй байх нь ховор. Энэ нь цаг минут тутамд хувьсан өөрчлөгддөг санхүүгийн зах зээлийг байнга ажиглаж судлах цаг зав тэдэнд байдаггүйтэй холбоотой юм. Харин санхүүгийн зах зээлийг тасралтгүй судалж, нарийвчилсан мэдээлэл цуглуулж байдаг, илүү гүнзгий мэдлэг эзэмшсэн хүмүүс бол банкир, брокер, диллер, хөрөнгө оруулалтын банкны менежер, андеррайтер, санхүүгийн шинжээчид юм.

Ийм учраас компани хөрөнгийн зах зээл дээр шинээр хувьцаа гаргахдаа андеррайтер, хөрөнгө оруулалтын банкны менежерүүдээс зөвлөгөө авдаг. Хөрөнгө оруулалтын банкинд санхүүгийн шийдвэр гаргах чиглэлээр мэргэшсэн шинжээчид ажилладаг бөгөөд зөвхөн хөрөнгийн төдийгүй бусад санхүүгийн зах зээлийг хамруулан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Хөрөнгө оруулалтын банкны менежерүүд нь хувьцаагаа нийтэд санал болгооор зэхж буй компанийн удирдлагад хичнээн хувьцаа гаргах, ямар үнээр борлуулах, аль биржид хандах, ямар төрлийн хөрөнгө оруулагчдад санал болгох зэрэг олон чухал асуултад нь хариулж тусалдаг.

Андеррайтерын үүргийг ихэнх тохиолдолд хөрөнгө оруулалтын банк гүйцэтгэдэг. Андеррайтер гэдэг нь үндсэндээ шинээр хувьцаа гаргаж буй компаниас нийтэд санал болгож буй хувьцааг анхдагч зах зээл дээр борлуулах, эсвэл өөрөө худалдан аваад эргүүлэн олон нийтэд худалдах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд юм. Олон улсын практикт андеррайтерууд нь ихэвчлэн хөрөнгө оруулалтын банкууд байдаг. Харин манай улсад андеррайтерын тусгай зөвшөөрөлтэй үнэт цаасны компаниуд анхдагч зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.

З ДУГААР БҮЛЭГ. МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ АСУУЛТУУД

1. Орон сууцаа засахаар болон жижиг үйлдвэрлэл эрхлэхээр тоног төхөөрөмж худалдан авахад зориулж авч байгаа зээл хоёр зарчмын ямар ялгаатай вэ?
2. Банк болон ББСБ-аас зээл авах, ХЗХ-нд гишүүнээр элсэж зээл авахын хооронд ямар ялгаа байгааг тодорхойлон бичнэ үү. Таны хэрэгцээ болон боломжид аль нь илүү тохиромжтой байна?
3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах зээлийн оронд лизингийн үйлчилгээ авах нь яагаад илүү тохиромжтой байдаг вэ?
4. Та зээл авах гэж байгаа бол хэн нэгнээр батлан даалт гаргуулах боломжтой юу? Ямар нөхцөлд батлан даалт гаргах хэрэгтэй вэ?
5. Хөрөнгийн зах зээлээр дамжуулан үнэт цаас гаргах замаар санхүүжилт татахын тулд таны удирдаж байгаа компани наад зах нь ямар шаардлагад нийцсэн байх ёстой гэж бодож байна вэ?

IV БҮЛЭГ.

Санхүүгийн шийдвэр гаргах нь

Энэ бүлгийг судалснаар Та:

- Хөрөнгө оруулалт хийх зэрэг санхүүгийн аливаа шийдвэр гаргахдаа өмнөх бүлгүүдэд дурдсанаас гадна анхаарвал зохих бусад асуудлыг мэдэж, практикт хэрэглэх;
- Аудиторын чиг үүргийг мэдэж, шийдвэр гаргахдаа аудитын дүгнэлтээс чухам юуг нь анхаарах;
- Хөрөнгийн үнэлгээний ач холбогдол, хөрөнгө үнэлэгчийн үйл ажиллагааны зарчмыг мэдэж, үнэлгээний тайланг ашиглах;
- Аливаа санхүүгийн шийдвэр гаргахдаа тухайн компанийн засаглалын талаар өөрийн дүгнэлт хийх талаар мэдлэгтэй болно.

4.1. Харилцагч санхүүгийн байгууллагаа сонгох нь

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгуулагуудын тоо нэмэгдэж, үйлчилгээний төрөл олширч, өрсөлдөөн нэмэгдэж байгаа нь сайн талтай. Гэвч харилцагчийн хувьд найдвартай түншээ олж сонгох нь тийм ч амар хялбар асуудал биш билээ.

Банкны хувьд мэдээж санхүүгийн тайлан балансыг нь үзэх хэрэгтэй. Ялангуяа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангасан болохоо банкууд улирал бүр олон нийтэд мэдээлэх үүрэгтэй байдаг тул уг үзүүлэлтийн биелэлт, танд шаардлагатай байгаа үйлчилгээний нөхцлүүдийг харьцуулан судалж сонголтоо хийх нь зүйтэй.

Даатгалын компани, ББСБ, ХЗХ-ны хувьд СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хэрхэн хангаж байгааг харгалzan үзэх шаардлагатай.

Харин шинэ тулгар хөгжиж буй хөрөнгийн зах зээл, ялангуяа үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдоос түншээ сонгох нь хамгийн түвэгтэй. Үнэт цаас худалдах, худалдан авахад тань хөрөнгийн биржийн гишүүн брокер диллерийн компани зуучилна. Брокер Таны захиалгын дагуу шударга үйлчлэх үүрэгтэй. Тухайлбал, өөрийн компаний захиалгыг биелүүлэхээс өмнө харилцагчдын захиалгыг биелүүлэх буюу өөрөө Таны захиалсан үнэт цаасыг худалдах, худалдан авах сонирхолтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, сонирхлын зөрчил байгаа бол энэ тухайгаа танд шударгаар мэдэгдэх үүрэгтэй байдаг. Хэрэв харилцагч хувьцаа эсвэл бондоо зарах захиалга өгсөн бол брокер зах зээл дээрх боломжит хамгийн өндөр ханшаар, харин авах захиалга өгсөн бол хамгийн хямд үнээр олж өгөх үүрэгтэй. Орчин үеийн олон улсын туршлагаас үзвэл брокерууд дараах нэмэлт үйлчилгээ үзүүлж байна:

- харилцагчийн захиалгыг онлайнаар авах электрон үйлчилгээ
- хувьцаа, бондын судалгаа, шинжилгээний мэдээлэл бэлтгэж харилцагчдад өгөх
- зах зээлийн чиг хандлагын талаар зөвлөгөө өгөх зэрэг болно.

Та үнэт цаасны арилжаанд оролцохоор брокероо сонгох гэж байгаа бол юуны өмнө хөрөнгийн биржийн гишүүн брокерийн компаниудын хаягийг судлаарай.

Брокероо сонгоходоо дараах үзүүлэлтүүдийг шалгуур болгож болно.

- Брокерийн үйлчилгээний шимтгэлийн хэмжээ
- Таны хөрөнгийн хэмжээ
- Брокерийн чадавхи, туршлага
- Брокерийн нэр хүнд
- Брокероос үзүүлэх нэмэлт үйлчилгээ: судалгаа, зөвлөгөө, электрон арилжаа г.м.⁷

Танд хамгийн ойрхон байрладаг брокерийн компаниар ороод үз. Цагийн хуваарийн дагуу ажиллаж байна уу үгүй юу, ажилтнууд нь таныг хэр анхааралтай хүлээн авч сонсож, зөвлөж байна гэдэг нь багагүй чухал шалгуур шүү. “Би үйлчилүүлэх брокероо сонгох сонирхолтой байгаа юм. Танай компаний санхүүгийн үзүүлэлтүүдтэй танилцаж болох уу?” гэж асуугаад үз. Энэ бүхэн Танд эерэг сэтгэгдэл төрүүлж байх нь чухал. Өгч байгаа мэдээлэл нь бодитой юу, үгүй юу гэдгийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн сайтад байгаа мэдээлэлтэй тулган шалгаад үзэх нь зүйтэй.

4.2. Рейтинг буюу зээлжих чадварын үнэлгээ

Олон улсын практикт хувьцаа, бонд гаргагч, санхүүгийн байгууллагууд болон улс орнуудын засгийн газрын зээлжих чадварын үнэлгээ тогтоох үйлчилгээ байдаг. Энэ нь тухайн байгууллага мөнгөө эргүүлэн төлөх чадвар хэр байгааг харуулдаг. Зээлжих чадварын үнэлгээгээр мэргэшсэн *Standard and Poors (S&P)*, *Moody's*, *Fitch Rating* гэх зэрэг компаниуд байдаг. Зээлжих чадварын үнэлгээг *Standard and Poors* болон *Moody's* нь дараах шатлааар тодорхойлдог.

| Үнэлгээний тайлбар | S&P | Moody's |
|---|-----|---------|
| Хамгийн сайн буюу хөрөнгө оруулахад таатай | AAA | Aaa |
| | AA | Aa |
| | A | A |
| | BBB | Baa |
| Хөрөнгө оруулахад төдийлөн тааламжгүй, эрсдэл ихтэй | BB | Ba |
| | B | B |
| | CCC | Caa |
| | CC | Ca |
| Дампуурах магадлал өндөртэй | C | C |

Том гүрнүүдийн Засгийн газар, үндэстэн дамнасан корпорациуд AAA/Aaa зэрэглэлтэй байдаг бол Монгол Улсын Засгийн газар В зэрэглэлтэй байна. АНУ гэх зэрэг өрнөдийн орнуудад ихэнх иргэд хувийн зээлжих чадварын үнэлгээтэй байдаг. Зээлийн түүх сайтай иргэд элдэв барьцаагүйгээр зээлээ богино хугацаанд авах боломжтой байдаг.

Энэ төрлийн үйлчилгээ Монгол Улсад төдийлөн хөгжөөгүй байна. Монголбанкны дэргэд улсын мэдлийн Зээлийн мэдээллийн сан байдаг боловч цар хүрээ бага, үр ашиг сул хэвээр байна. Монголын Банкуудын Холбоо дэргэдээ хувийн өмчийн Зээлийн мэдээллийн сангийн үйлчилгээ үзүүлэх компани байгуулж байгаа нь энэ төрлийн үйлчилгээг Монголд хөгжүүлэх эхлэл болж байна. Таны зээлийн түүх сайн байна гэдэг нь санхүүгийн ямар нэг зөрчил гаргадаггүй, зээлээ хугацаанд нь төлдөг, санхүүгийн үйлчилгээг авч сурсан, сайн харилцагч гэсэн үг.

4.3. Аудит

4.3.1. Ерөнхий ойлголт

Аудитор нь байгууллагын санхүүгийн тайланг шалгаж, нягтлан болдох бүртгэлээ хэр сайн хөтөлсөн, хөрөнгө, үйл ажиллагаагаа бүгдийг нь зохих журмын дагуу зөв бүртгэсэн эсэх, үйл ажиллагаа нь хуулийн дагуу явагдаж уу гэх зэргийг хянадаг. Эцэст нь жил, улирлын санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын санхүүгийн байдал болон үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг бодитой тусгасан эсэх талаар дүгнэлт өгч, баталгаа гаргадаг хараат бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг, тусгай зөвшөөрөл бүхий санхүүгийн зах зээлийн чухал оролцогчийн нэг юм.



Байгууллага бүр санхүүгийн тайлан гаргаж, түүнийгээ өөр өөр зорилгоор хэрэглэгчдэдээ толилуулдаг. Иймээс аудитын гол зорилго бол хэрэглэгчдийг үнэн зөв, баталгаажсан санхүүгийн мэдээллээр хангах явдал байдаг.

Бизнесийн байгууллагын удирдлагад ирээдүйн хөрөнгө оруулалт болон зээлийн шийдвэр гаргахад үнэн зөв санхүүгийн мэдээлэл чухал байдаг. Тухайлбал, зээлдүүлэгч банк зээлдэгчийн санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл авснаар зээлийн эрсдлээ бууруулна. Мөн түүнчлэн тендер зарлаж, гэрээ хийх талаа сонгох гэж байгаа харилцагчийн хувьд нөгөө талынхаа санхүүгийн үнэн зөв мэдээллийг

авах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, санхүүгийн мэдээллийн хэрэглэгч бүр өөр өөр зорилготой боловч мэдээлэл үнэн зөв баталгаатай байх нь тэдний хувьд чухал ач холбогдолтой. Энэхүү мэдээллийн үнэн зөв баталгаатай байдлыг аудитын үйл ажиллагаа хангадаг.

4.3.2. Аудитын үйл ажиллагаанд оролцогч талууд

Аудитын үйл ажиллагаанд үйлчлүүлэгч, аудитор гэсэн хоёр тал оролцдог. Харин баталгаажсан мэдээллийг хэрэглэгчид ашиглана.

Үйлчлүүлэгч гэж гэрээний үндсэн дээр аудит хийлгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч иргэн, бусад эрх бүхий этгээдийг хэлнэ. Жишээлбэл, хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх төрлийн хувьцаат компани, хөрөнгийн биржид бүртгүүлэх зөвшөөрөл хүсч буй компани, 50 сая ба түүнээс дээш төгрөгийн хөрөнгөтэй байгууллага, өөрчлөн шинэчлэгдэж, татан буугдаж байгаа болон бүх хөрөнгөө дуудлага худалдаагаар худалдах гэж байгаа байгууллага зэргийг заавал аудит хийлгэсэн байхыг хуулиар шаарддаг.

Түүнээс гадна Компаний тухай хуулийн 91.2-т заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл, хувьцааны арваас дээш хувийг эзэмшигч нь аудитийн ээлжит бус шалгалтыг хэдийд ч хийлгэх эрхтэй.

Аудитор нь үйлчлүүлэгчийн захиалгын дагуу гэрээ байгуулж, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн үндэслэлийг шалгаж, дүгнэлт гарган, зөвлөгөө өгдөг. Олон улсын стандартын дагуу аудитор нь хараат бус ажиллах үүрэгтэй.

Хэрэглэгч. Аудитын зорилгоос шалтгаалан хэрэглэгч нь хэн ч байж болно. Хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, гэрээний нөгөө тал, эсвэл төрийн зохицуулах байгууллагууд нь аудитын тайлангийн анхдагч хэрэглэгч байдаг.

4.3.3. Аудитын тайлан

Та хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахдаа хувьцаа, бондыг нь худалдан авах гэж байгаа компани, хадгаламж хийх гэж буй банкныхаа санхүүгийн тайлангийн талаар гаргасан аудитын дүгнэлтийг анхааралтай уншиж, ойлгож чаддаг байх шаардлагатай.

Аудитын тайландаа тусгагдах ёстой мэдээллийг аудитын олон улсын стандартад тодорхойлсон байдаг. Үүнд:

- Тайлангийн толгой буюу нэр
- Тайланг хүлээн авагчийн хаяг

- Оршил хэсэг /удирдлага ба аудиторын хариуцлага
- Ажлын цар хүрээний хэсэг
- Дүгнэлтийн хэсэг - Аудитын тайлангийн хамгийн гол хэсэг
- Тайлан гаргасан он сар өдөр
- Аудиторын хаяг
- Аудиторын гарын үсэг

Аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсэг нь ямар стандартын дагуу бичигдсэнийг харгалзан ямар төрлийн дүгнэлт гаргасныг тодорхойлдог. Ерөнхийдөө дөрвөн төрлийн дүгнэлттэй тайлан гаргадаг.

1. Зөрчилгүй тайлан

Аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсгээс

"Санхүүгийн тайлангууд нь 200... оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал ба жилийн үйл ажиллагааны үр дүнг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартын зарчмуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж бид дүгнэж байна". Таны сонирхсон компаний аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсэгт ингэж бичсэн байвал ямар ч алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн санхүүгийн тайлан байна гэж ойлгох хэрэгтэй.

2. Зөрчилтэй дүгнэлт бүхий тайлан

Аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсгээс

"А банк нь бидний шалгасан хугацаанд зээлийн ангиллыг өөрсдийн дотоод журмыг баримтлан хийжээ. Дээрхээс бусад үйл ажиллагааг үнэн зөв бодитой илэрхийлсэн байна" гэж бичсэн тохиолдолд зөрчилтэй дүгнэлт бүхий тайлан гарсан гэж үзнэ. Ер нь аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсэгт "...Үүнээс бусад нь...", "Дор дурдсанаас бусад нь...", "Дээрхээс бусад нь..." гэх мэт өгүүлбэр орсон байвал тодорхой үйл ажиллагааг аудитын хувьд зөв гэж дүгнэж болохооргүй байсан бөгөөд зөрчилтэй дүгнэлт бүхий тайлан гарчээ гэж ойлгох ёстой. Ийм тохиолдолд уг дүгнэлтэд заасан хэсэг нь хөрөнгө оруулагч Танд хэр зэрэг хохирол учруулж болохыг зайлшгүй анхаарах шаардлагатай болно. Ер нь аудитор ийм дүгнэлт гаргасан бол хөрөнгө оруулалтаасаа татгалзах нь зүйтэй.

3. Дүгнэлт өгөхөөс татгалзсан тайлан

Аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсгээс

“Банк аудитын ажлын цар хүрээний боломжийг хязгаарлаж, нөхцөл бололцоог бүрдүүлэгүй, зарим мэдээ материалтай танилцах бололцоо олгоогүй учир бид тус банкны гадаад дахь харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулж чадсангүй”. Ийм дүгнэлт нь аудитор хэдийгээр шалгаж баталгаажуулж чадаагүй ч санхүүгийн тайлангийн хэмжээнд тэрээр материаллаг бус байна гэж үзсэн үед бичигддэг. Энэ жишээний хувьд Банкны гадаадын дансанд мөнгө байгааг аудитор нотолж чадаагүй буюу аудитор нь энэ тухай хангалттай дүгнэлт өгөх боломжгүй байлаа гэсэн утгатай бөгөөд аудитор дүгнэлт өгөхөөс татгалзсан байна гэж ойлгоно.

4. Сөрөг дүгнэлттэй тайлан

Аудитын тайлангийн санал дүгнэлтийн хэсгээс

“Бидний үзэж байгаагаар С банк мөнгөн гүйлгээний тайланг үнэн зөв үйлдээгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг дагаж мөрдөөгүйтэй холбоотой гэж үзэж байна”. Шалгах явцад гарсан тодорхой бус байдал нь материаллаг нөлөө үзүүлнэ гэж үзсэн үед ийм дүгнэлтийг хийдэг. Материаллаг нөлөө үзүүлнэ гэдэг нь санхүүгийн тайланд байгаа алдаанаас болж санхүүгийн мэдээлэл зөв илэрхийлэгдээгүйгээс хэрэглэгчид нь буруу, алдаатай шийдвэр гаргахад хүргэж болохуйц нөлөө гэж ойлгоно.

Дээрх дөрвөн төрлийн аль нэг хэлбэрээр аудитын дүгнэлт бичигдсэн байна. Аудитор нь үйлчлүүлэгчдэдээ зориулан аудитын зөвлөмж гаргадаг. Харин санхүүгийн тайлангийн хэрэглэгч уг зөвлөмжийг тэр бүр авч үзэх боломж бололцоо байдаггүй. Иймд “Хараат бус аудиторын дүгнэлт” гэсэн хуудас цаасыг уншаад ямар төрлийн дүгнэлт болохыг таньж мэдэх нь чухал бөгөөд Та дээр дурдсан хэлбэрүүдийг сайтар мэдсэнээр шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээ олох чадвартай болно. Аудитын байгууллагуудын талаарх мэдээллийг Хавсралт З-аас үзээрэй.

4.4. Хөрөнгийн үнэлгээ

Хөрөнгийн үнэлгээ бол санхүүгийн менежментийн чухал асуудал юм. Аливаа аж ахуйн үйл ажиллагаа ашигтай байхаас гадна түүнд ашиглаж буй хөрөнгийг зүй зохистой ашиглаж, урт хугацаанд үр өгөөжийг нь хүртэх нь чухал. Хөрөнгөө барьцаанд тавих, даатгуулах, даатгалын нөхөн төлбөр авах, хөрөнгө оруулалт хийх, худалдах, түрээслүүлэх, татвар төлөх гэх мэт олон тохиолдолд хөрөнгийн үнэлгээ хийлгэх шаардлага тулгардаг.

4.4.1. Аргачлал

Олон улсын үнэлгээний стандартад үнэлгээний тулгуур ухагдахуун, зарчмыг тайлбарласан байдаг. Мөн үнэлгээнд баримтладаг зах зээлийн жишиг үнийн (үнэлгээний ижил төстэй объектуудын зах зээлд худалдагдсан үнэ), орлого капиталжуулалтын (тухайн объектыг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулснаас орлого олж болох боломжоор тогтоосон үнэлгээ), өртгийн (тухайн хөрөнгийн балансын үнэ буюу худалдаж авсан, эсхүл тийм объектыг барьж байгуулахад гарах зардал) гэсэн гурван аргачлал байдаг. Жишээ нь, А компанийн агуулахын байшинг үнэлгээний Д компани үнэлэхдээ зах зээлийн жишиг үнээр бол 15 сая, орлого капиталжуулалтын үнэ нь 10 сая, өртгийн хандлагаар 12 сая гэжээ. Үнэлгээчин дээрх гурван үнэлгээнд ач холбогдлын хувь тогтоож эцсийн үнэлгээг гаргана. Тухайлбал, зах зээлийн жишиг үнийн хандлагад 60 хувь, нөгөө хоёр хандлагад тус бүр 20 хувийн ач холбогдол өгсөн бол 13,4 сая ($15\text{сая} \times 60\% + 10\text{сая} \times 20\% + 12 \text{сая} \times 20\% = 13.4 \text{ сая}$) гэсэн үнэлгээ тогтооно.

4.4.2. Үнэлгээний зүйл

Өмч, хөрөнгө бүрийг эдийн засгийн эргэлтэд оруулж өгөөжийг нь хүртэж, бүтээмжийг нь нэмэгдүүлж чадсан улс орон хөгжиж, өөдлөн дээшилж байгааг Америк, Европ, Японы туршлага харуулж байна. Эдгээр оронд хэсэгхэн газраас эхлээд, бүх барилга объектууд, машин тоног төхөөрөмжийн эд анги мэт материаллаг эд юмс төдийгүй оюуны өмчийг хүртэл тоолж, хянаж, бүртгэж, үнэлж, тэдгээрийн дүн мэдээг данс, тайландаа тусгасан байдаг. Гэтэл манай улсын иргэд **үл хөдлөх** болон (газар, хашаа, байшин барилга, байгалийн нөөц), **хөдлөх** (мал амьтан, ургамал, санхүүгийн хэрэгсэл) хөрөнгө, оюуны өмч, бизнесийн нэр төр зэргийг бүрэн хэмжээгээр бүртгэж, үнэлж, эргэлтэд оруулж чадаж байна уу гэвэл тийм биш байна. Энэ нь ч ядуурлын нэг шалтгаан болж байна.



4.4.3. Үнийн төрлүүд

Олон улсын үнэлгээний стандартад “**Зах зээлийн үнэ**” гэдэг нь худалдагч, худалдан авагч талууд аль аль нь хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэгэн шахалтгүй, хоорондоо холбоо хамааралгүй байх тохиолдолд тухайн хөрөнгийг худалдаж болох үнэ” гэж заажээ. Худалдагч, худалдан авагч талууд хөрөнгийн талаар хангалттай мэдээлэлтэй, тухайн хөрөнгийг худалдах хэлцэлд сайн дураараа оролцож хөрөнгийг худалдаж авсан, эсхүл авч болох үнийг зах зээлийн үнэ гэж энгийнээр ойлгож болно.

Олон улсын үнэлгээний стандартад **зах зээлийн үнэ** цэнээс гадна зах зээлийн бус үнэ цэнийг тооцож хэрэглэдэг. Зах зээлийн бус үнэд хөрөнгө оруулалтын үнэлгээ, тасралтгүй үргэлжлэх бизнесийн үнэ, даатгалын үнэ, татвар, эсвэл хураамж ногдуулах (тооцох) үнэ, тусгай үнэ гэсэн ойлголтууд хамарагддаг.

4.4.4. Хараат бус үнэлгээчин

Үнэлгээчин гэж өмчийн объектын үнэ цэнийг тогтоох мэдлэг чадвартай, холбогдох төрийн байгууллагаас уг үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан мэргэжилтэн юм. Үнэлгээчин биеэ даасан, хараат бус, хувийн ашиг сонирхолгүй байх ёстой.

Манай Улсад 2009 оны 5 дугаар сарын байдлаар хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй 28 компанийд хөрөнгийн үнэлгээний эрх авсан 134 иргэн хараат бус үнэлгээний үйл ажиллагаа явуулж байна. Үнэлгээний компаний талаарх мэдээллийг Хавсралт 4-өөс үзнэ үү.

Жишээ: АБ хувьцаат компаний дийлэнх хувьцааг эзэмшигчид нь компанияя хязгаарлагдмал хариуцлагатай компани болгооор шийдвэрлэсэн. Тэд компанийяа хөрөнгийн үнэлгээг эрх бүхий О компаниар хийлгэсэн. Уг компаний үнэлгээчид АБ компаний хөрөнгийг 1.5 тэрбум гэж үнэлжээ. Гэтэл АБ компаний жижиг хувьцаа эзэмшигчид энэ үнэлгээг хэтэрхий доогуур тогтоосон гэж үзээд хөрөнгийн үнэлгээний Э компаниар дахин үнэлгээ хийлгэжээ. Э компаний үнэлгээчид АБ компаний хөрөнгийг 2.5 тэрбум гэж үнэлсэн. Энэ хоёр дүгнэлтийн аль нь зөв болох талаар Санхүүгийн зохицуулах хороо тайлбар хүссэн боловч О компани дүгнэлтийнхээ үндэслэлийг тайлбарлаж чадсангүй. Тийм учраас О компани хараат бус, бие даасан дүгнэлт гаргаж чадаагүй, АБ компаний том хувьцаа эзэмшигчдийн нөлөөнд орж тэдний захиалгаар хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг зориуд багаар тогтоосон гэж дүгнэсэн байна. Ийм тохиолдолд үнэлгээчний ёс зүйн асуудал чухал болдог.

Улсын Их Хурал 2010 оны 1 дүгээр сарын 21-нд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийг анх удаа батлан гаргасан бөгөөд энэ хуулиар хөрөнгийн үнэлгээ хийх эрх зүй, зохион байгуулалтын үндсийг тогтоож, энэ чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагатай холбогдсон харилцааг зохицуулж байна.

4.4.5. Үнэлгээний тайлан

Үнэлгээний тайлан гэдэг нь үнэлгээний зүйлийн үнэ цэнэ, түүнийг тогтоосон үндэслэл, нотолгоог агуулсан баримт юм. Үнэлгээний тайланд:

- үнэлгээчний нэр, тусгай зөвшөөрлийн дугаар, хугацаа
- үйлчлүүлэгчийн нэр, хаяг, регистрийн, эсвэл улсын бүртгэлийн дугаар
- үнэлгээ хийсэн үндэслэл, зориулалт
- үнэлгээ хийсэн хугацаа болон үнэлгээний тайлан гаргасан огноо
- үнэлгээ хийлгэж буй зүйлийн төрөл, түүний шинж байдлын тодорхойлолт
- үнэлгээ хийлгэж буй зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаарх мэдээлэл

- үнэлгээнд ашигласан баримт, мэдээлэл, нотолгоо, хийсэн дүн шинжилгээ, таамаглал, түүний үндэслэл
- үнэлгээ хийлгэж буй зүйлийн үнэ цэнийг тогтооход хэрэглэсэн арга, горим, тэдгээрийн нийцтэй байдал
- үнэлгээ хийлгэж буй зүйлийн үнэ цэнэ
- үнэлгээний үйл ажиллагааг хуульд заасан стандартын дагуу гүйцэтгэсэн талаарх үнэлгээчний мэдэгдэл зэргийг тусгасан байна.

Үнэлгээний тайланд үнэлгээчин гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Үнэлгээчин үнэлгээний тайлангийн хувийг таваас доошгүй жил хадгалах үүрэгтэй.

4.5. Компаний засаглал

Сүүлийн үед компаний засаглал, компаний нийгмийн хариуцлага гэх зэрэг урьд өмнө нь байгаагүй үгс сонсогох болсныг анзаарсан биз ээ. “Засаглал” гэснийг бодоход лав удирдлагатай л холбоотой байж таарна гэсэн төсөөлөл бууж байгаа байх. Хэрэг дээрээ засаглал нь удирдлагатай холбоотой. Гэхдээ “сайн удирдлага”, “сайн засаглал” хоёрын хооронд барагүй ялгаа бий. Эдгээр нь чухам юугаараа ялтгаатай, ер нь компаний засаглал гэж юу болох талаар ярилцъя.

Компанийг сайн удирдаж байгаа эсэхийг юуны өмнө борлуулалт нэмэгдэж, ашиг өсөж байгаа эсэхээр дүгнэдэг.

Гэтэл ашиг нь өсөн нэмэгдэж байгаа боловч энэ ашгийг бий болгоход хувира оруулсан, уг компаний жинхэнэ эзэд болох хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилдаггүй, мэдээлэл өгдөггүй, хувьцаа эзэмшигч нь оруулсан хөрөнгийнхөө үр шимийг хүртээгүй байхад захирал нь үнэтэй машин унаад, элдэв хандив өгч зурагтаар “мандаад”, бид компанийхаа нийгмийн хариуцлагад ихээхэн анхаардаг гэж ярих тохиолдол цөөнгүй байдгийг бид мэднэ. Чухам энэ бол муу засаглалтай компани юм.



Компанийг сайн удирдаж, ашигтай ажиллуулахаас гадна хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч банк, харилцагч түншүүд, ажиллагсад зэрэг бүх оролцогчийнхоо эрх ашгийг дээдлэн хариуцлага, сахилгатай ажилладаг Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), гүйцэтгэх удирдлагатай компанийг сайн засаглалтай гэнэ.

Бүх талуудын эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулдаг сайн засаглалтай компаний зах зээлийн нэр хүнд сайн, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээж чаддагаас санхүүжилт татах чадвартай, ажиллагсад нь тогтвортой суурьшилтай, үүний үр дүнд урт хугацаанд тогтвортой, ашигтай ажиллах ирээдүйтэй байдаг.

Компаний засаглалын дараах дөрвөн зарчим байдаг:

- Компаний үйл ажиллагаа олон нийтэд **ил тод** байдаг, өөрөөр хэлбэл, санхүүгийн тайлангаа нийтэлдэг, жил бүр ээлжит хурлаа хийж, хувьцаа эзэмшигчиддээ өнгөрсөн жилийн үйл ажиллагааны үр дүн, ирэх жилд юу хийхээр төлөвлөж байгаагаа тайлагнадаг, компаний хувьцааны ханшид нөлөөлж болох сайн муу талын нөлөөллүүдийн талаар олон нийтэд тогтмол мэдээлдэг байх;
- Компаний гүйцэтгэх удирдлага ТУЗ-дөө, ТУЗ нь хувьцаа эзэмшигчиддээ **тайлагнадаг**, гаргасан шийдвэрийнхээ төлөө тэдний өмнө хариуцлага хүлээдэг байх;

- Компаний удирдлага **хариуцлагатай** ажилладаг байх, өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчид болон харилцагч түнш, зээлдүүлэгчид, хэрэглэгчдийн хууль ёсны эрхийг хүндэтгэн, нийгмийн баялаг бүтээх, ажлын байр бий болгох, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байх;
- Хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашиг зөрчигдсөн үед засаж залруулах арга хэмжээ авдаг **шударга тогтолцоог** бүрдүүлж чадсан байх.

Хувьцаа эзэмшигчийн хувьд компанийхаа засаглалын талаар энэ номын Хавсралт 15-аас илүү дэлгэрэнгүй мэдээллийг уншаарай.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ. МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ АСУУЛТУУД

1. Санхүүгийн үйлчилгээ авах гэж буй байгууллагаа сонгохын тулд Та юу анхаарах шаардлагатай вэ?
2. Аудитор болон үнэлгээчин ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай байж чадах эсэх нь хүн бүрт хамаатай гэдэгтэй санал нийлэх үү?
3. Аудиторын дүгнэлт гэсэн ганцхан хуудас цааснаас хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад чухал мэдээллийг яаж уншиж ойлгох вэ?
4. Ашигтай ажилладаг, ажилчдынхаа нийгмийн асуудалд анхаарал тавьдаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусалдаг, онц сурлагатай оюутнуудад тэтгэмж олгодог зэрэг үзүүлэлт нь тухайн компани сайн засаглалтай эсэхийн шалгуур болж чадах уу?
5. Компаний засаглал сайн муу байх нь хэний эрх ашигт нөлөөлөх вэ?

V БҮЛЭГ.

Эрсдлийн тухай

Энэ бүлгийг судалснаар Та:

- Эрсдлийн төрлүүд, сэргийлэх арга замуудыг ойлгож сонгох;
- Даатгалын ач холбогдолыг тайлбарлах;
- Даатгалын төрлүүдийг мэдэж, даатгуулахдаа анхаарвал зохих асуудлыг тодорхойлох;
- Даатгуулагчийн хувьд эрх ашгаа хамгаалуулах мэдлэг, чадварыг эзэмшинэ.

5.1. Санхүүгийн эрсдэл

5.1.1. Ерөнхий ойлголт

Хүн төрөлхтний түүхийн эхэн үед эрсдэл хүний амьдрах орчинтой холбоотой байсан бол сүүлдээ нийгмийн орчинд тохиолддог болсон байна. Түүхийн эхэн үед хүний амьдралд араатан амьтны халдлага аюул учруулдаг байсан ба гал гаргаж авснаар энэ аюулыг бууруулж чадсан боловч бүрмөсөн алга болгочихоогүй, харин эрсдлийг бууруулсан. Аливаа эрсдлийг бүрмөсөн арилгах буюу алга болгох боломж бараг байхгүй.

Эрсдэл гэдэг нь ерөнхийдөө хор уршиг, гай зовлон учрах, эсвэл алдагдалд орох магадлал юм. Эрсдэлтэй үед ямар нэг үйл явдлын төгсгөл, эсвэл үр дүн нь тодорхойгүй байдаг. Жишээ нь, үндэсний бөхийн барилдаанд өнөөгийн дүрмээр тодорхой хугацааны дараа хоёр бөх хаялцаж чадаагүй бол зоосон мөнгөөр, эсвэл шоо хаяж шоддог билээ. Энэ нь хоёр бөхийг аль алийг нь эрсдэлд оруулдаг. Зоосон мөнгөөр шодж байгаа тохиолдолд барьц сонгох, сонгуулах эрсдэл 50 : 50 хувийн магадлалтай байна.

5.1.2. Хөрөнгө оруулалтын эрсдэл, түүний ангилаал

Хувь хүн хөрөнгө оруулалт хийхдээ олон хүчин зүйлийг харгалзах хэрэгтэй болдог. Тухайн хөрөнгө оруулалтын найдвартай байдал, учирч болох эрсдлийг тооцож сурах хэрэгтэй.

Тодорхой хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэл нь цаг хугацааны явцад өөрчлөгдж болно. Жишээ нь, 2008 оны хавар “Анод” банк анх хувьцаагаа гаргаж байх үед хувьцаа авах сонирхолтой хүмүүс маш олон байв. Тэр хэмжээгээр үнэ нь өсөж байсан бөгөөд тэр үед хувьцаагаа зарсан хүмүүс барагүй ашиг олсон. Түүнээс хойш жил хүрэхгүй хугацаанд “Анод” банкны санхүүгийн байдал хүндэрч, алдагдалд орж эхлэх үед тус банкны хувьцааг авсан хүмүүс түргэхэн шиг буцааж зarah сонирхолтой болж, хувьцааны үнэ унасан. Өөрөөр хэлбэл, хэдхэн сарын өмнө эрсдэл багатай, ашиг унац ихтэй байсан хувьцаа төдөлгүй ихээхэн эрсдэлтэйд тооцогдох болсон байна.

Санхүүгийн эрсдлийг ерөнхийд нь дөрөв ангилаал. Үүнд:

1. *Инфляцийн эрсдэл.* Инфляци өндөр буюу юмны үнэ өсч байгаа үед хөрөнгө оруулалтын өгөөж, ашгийн хувь хэмжээ инфляцийн түвшингээс доогуур байх эрсдэл байдаг. Инфляци худалдан авах чадварыг хэрхэн бууруулдгийг дараах жишээгээр тайлбарлая.

Жишээ: Та 2008 оны 1 дүгээр сарын 1-нд 1,000,000 төгрөгийг жилийн 15 хувийн хүүтэйгээр банкинд хадгалуулсан гэж үзье. Жилийн эцэст Та энэхүү хадгаламжаас 150,000 төгрөгийн хүүгийн орлого олно ($1,000,000 \times 15\% = 150,000$). Хэрэв 2008 онд инфляци 20 хувьтай байсан гэж үзвэл таны худалдан авах чадвар 200,000 төгрөгөөр буурсан байна. Өөрөөр хэлбэл, Та өнгөрсөн жил 1,000,000 төгрөгөөр авдаг байсан зүйлээ одоо 1,200,000 төгрөгөөр авна гэсэн үг. Хэдийгээр хадгаламжийн хүүгээсээ 150,000 төгрөгийн орлого олсон боловч инфляци таны мөнгөний худалдан авах чадварыг 200,000 төгрөгөөр бууруулсны улмаас таны худалдан авах чадвар цэвэр 50,000 төгрөгөөр буурсан байна ($150,000 - 200,000 = - 50,000$). Хэрэв хадгаламжид хийлгүй зүгээр л сейфэндээ хадгалж байсан бол таны хүлээх цэвэр эрсдлийн хэмжээ 200,000 төгрөг байх болно.

2. *Хүүгийн эрсдэл.* Зарим компаний тогтмол хүүтэй бонд, хугацаат хадгаламж зэрэгт хөрөнгө оруулалт хийхэд хүүгийн эрсдэл гарч болно. Жишээ нь, Та “А” компаний гурван жилийн хугацаатай, 10 хувийн хүүтэй, 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бондыг 2009 оны

5 дугаар сарын 1-нд худалдан авсан гэж үзье. Тогтмол хүүтэй гэдэг нь тухайн бондын хүү гурван жилийн хугацаанд өөрчлөгдөхгүй гэсэн үг. "А" компани танд жил бүр 10,000 төгрөгийн бондын хүү төлнө. Энэ хугацаанд бусад бондын хүү өсч 15 хувьтай болвол таны худалдан авсан 10 хувийн хүүтэй бондын үнэ цэнэ буурна. Хэн ч таны авсан бондыг худалдаж авахыг хүсэхгүй. Тиймээс Та "А" компаний бондоо хугацаа нь дуусах хүртэл өөртөө хадгалах, эсвэл 100,000 төгрөгөөс доогуур үнээр худалдах болно. Таны авсан бондын худалдах үнэ ойролцоогоор 66,667 төгрөг болно ($10,000 : 15\% = 66,667$). Таны бондыг ийм үнээр худалдан авсан хүн 15 орчим хувийн ашиг олох боломжтой. Харин Та 33,333 төгрөгийн алдагдал хүлээнэ. Зах зээлийн хүүгийн тувшин ихээхэн хэлбэлзэлтэй байгаа үед нэг жилээс урт хугацаатай, тогтмол хүүтэй бонд худалдан авахаас татгалзах нь эрсдлийг бууруулна. Үүний тулд зах зээлийн мэдээлэлд анхаарлаа хандуулахаас гадна, санхүүгийн мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах нь зүйтэй.

3. *Бизнесийн эрсдэл.* Хувьцаа, компаний бонд худалдаж авах үед бизнесийн эрсдэл тохиолддог. Хувьцаа, бонд гаргасан компаний удирдлага, зохион байгуулалт, эсхүл борлуулалт муудах зэрэг олон хүчин зүйлээс хамааран ашиггүй ажиллаж алдагдал хүлээх нь бий. Ашигтай ажиллаж чадаагүй компани ногдол ашиг тарааж чадахгүй бөгөөд ногдол ашиг өгдөггүй компаний хувьцааны үнэ буурна. Компани ашиг, орлогогүй ажиллавал гаргасан бондынхoo хүү болон үндсэн төлбөрийг төлөх эсэх нь эргэлзээтэй болно. Хэрэв бонд, хувьцаа гаргасан компани дампуурвал түүний хувьцаа, бондыг авсан хөрөнгө оруулагчид бүрэн алдагдал хүлээх магадлал ч бий.

4. *Зах зээлийн эрсдэл.* Хөрөнгө оруулагчдын шийдвэр, зан төлвөөс хамааран хувьцаа, бонд, бусад хэлбэрийн хөрөнгө оруулалтын үнэ байнга өөрчлөгдөж байдаг билээ. Эдийн засгийн өсөлт, бууралтыг урьдчилан таамаглахад бэрх байдаг. Ерөнхийдөө эдийн засгийн өсөлт өндөртэй он жилүүдийн дараа эдийн засгийн бууралт, уналт дагалдаж байдаг. Худалдан авсан үнэт цаас, үл хөдлөх хөрөнгөө хямралын үед зарж борлуулахад Танд ихээхэн бэрхшээлтэй байх болно. Мөн зах зээлийн үнэ ханш нийгэм, улс төр, олон улсын нөхцөл байдлаас ч ихээхэн хамааралтай байдаг.

Аливаа хөрөнгө оруулалтын эрсдлийг үнэлэх, аюулгүй байдал, ашиг орлогыг тооцоход дараах схемийг ашиглаж болох юм. Үүнийг хөрөнгө оруулалтын пирамид гэж нэрлэх ч тохиолдол байдаг.

Дараах схемээр хөрөнгө оруулалтын хэлбэрүүдийн эрсдлийг харуулав. Пирамидын суурь буюу I хэсэгт байгаа хөрөнгө оруулалтууд

нь хамгийн эрсдэл багатай, найдвартай хэлбэр бол пирамидын дээд хэсэг буюу IV хэсгийн хөрөнгө оруулалтын хэлбэрүүд нь хамгийн эрсдэл өндөртэйд тооцогддог байна.



5.1.3. Эрсдлээс сэргийлэх ба эрсдлийг бууруулах

Байгууллага, иргэд өөрийн хөрөнгө, санхүүгээ эрсдлээс хэрхэн сэргийлэх, хамгаалах, эрсдлийг бууруулах талаар стратеги боловсруулж, хэрэгжүүлэхийг эрсдлийн удирдлага хэмээдэг. Ямар ч хүн бүх төрлийн эрсдлээс өөрийгөө бүрэн хамгаалж чадахгүй тул аль болох түүнийг багасгах арга замыг хайх хэрэгтэй. Ихэнх хүмүүс эрсдлээс сэргийлэхийн тулд зөвхөн даатгалд хамрагдах хэрэгтэй гэж боддог. Гэвч даатгал нь эрсдэл, тодорхойгүй байдлыг зохицуулах цорын ганц арга зам биш юм. Энд эрсдлийн удирдлагын ерөнхий гурван арга замын талаар товч тайлбарлая. Эдгээр нь эрсдлээс сэргийлэх, эрсдлийг бууруулах, эрсдлийг шилжүүлэх арга замууд болно.

Эрсдлээс сэргийлэх. Эрсдэлтэй алхам хийхгүй байх нь түүнээс сэргийлэх арга зам болно. Жишээ нь, Та хувийн дэлгүүртэй бол хаалга, цонхондоо дохиолол, тусгай цоож хийх, эсвэл хамгаалагч авч ажиллуулан бараагаа хулгайд алдахаас сэргийлдэг. Ер нь хэн бүхэн гэр орон, ажлын байраа сайтар хамгаалан эд хөрөнгөө хулгайд алдахаас сэргийлэх хэрэгтэй.

Хувьцаагаар хийх хөрөнгө оруулалтын талаар өөрөө ямар ч мэдлэг мэдээлэлгүй байж, хувьцааны үнэ их өсөж байна гэсэн хэн нэгний мэдээллээр сэтгэлийн хөөрөлд автан хувьцаа худалдан авч болохгүй.

Эрсдлийг бууруулах. Урьдчилан сэргийлэх боломжгүй эрсдэлтэй үед уг эрсдлийг бууруулах, цар хүрээ, учрах хохирлыг багасгах арга хэмжээ авч болдог. Жишээ нь, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийхдээ зөвхөн нэг төрлийн, эсвэл нэг компанийн үнэт цаас авах биш олон төрлийн, өөр өөр компанийн үнэт цаас худалдан авбал таны хөрөнгө оруулалтын эрсдэл буурна. Олон төрлийн үнэт цааснаас аль нэг төрлийнх нь үнэ унаж болно. Эсвэл олон зуун компаниудаас нэг, эсвэл хэд хэдэн компани дампуурч болно. Харин бүх төрлийн үнэт цаасны үнэ нэг дор унах, бүх компаниуд нэгэн зэрэг дампуурах магадлал бага билээ.


Эрсдлийг шилжүүлэх. Эрсдлийн удирдлагад хамгийн түгээмэл хэрэглэдэг аргуудын нэг бол эрсдлийг даатгалын компани, эсвэл өөр ямар нэг байгууллагад шилжүүлэх арга зам юм. Мөнгөө хадгалуулсан банк дампуурахад таны хадгаламж даатгагдаагүй бол Та бүх хадгаламжаа алдана. Хэрэв хадгаламжаа ямар нэг хэлбэрийн даатгалд хамруулсан бол банк дампуурсан тохиолдолд таны хохирлыг даатгалын байгууллага нөхөн олгоно. Дараагийн сэдэвт даатгалын тухай илүү дэлгэрэнгүй тайлбарлах болно.

5.2. Даатгалын тухай

5.2.1. Ерөнхий ойлголт

Эрт дээр үед Хятадын тариачид үр тариагаа усан завиар тээвэрлэн худалддаг байжээ. Энэ үед үр тариагаа тээвэрлэсэн завь усанд живэх явдал нэг биш удаа тохиолддог байж. Тэгэхээр нь нэг завинд нэг өрх бүх үр тариагаа ачих биш олон завинд хувааж ачаад тээвэрлэдэг болсон байна. Ингэснээр нэг завь живэхэд нэг өрх бүх үр тариагаа алдаж хохирох бус багахан хэмжээний алдагдал хүлээдэг болжээ. Ийнхүү учрах хохирлоо олон өрхөд хуваарилснаар нэг өрх санхүүгийн хувьд сүйрэл амсахаас сэргийлэх арга олсон нь даатгалын үндсэн санааг бий болгосон гэж судлаачид үздэг.

Даатгал нь үндсэндээ хэн нэгэнд учрах санхүүгийн эрсдлийг олон хүнд тархаан байршуулдаг нийгмийн нэг арга хэрэгсэл юм.



Үндсэндээ хоёр төрлийн эрсдэл байдгаас нэгийг нь даатгах боломжтой нөгөөг нь даатгах боломжгүй байдаг. Даатгах боломжгүй эрсдлийн жишээнд мөрийтэй тоглоом, үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийх зэрэг хамаардаг. Мөрийтэй тоглоом тоглоход нэг бол хожино, эсхүл алдана. Энэ төрлийн эрсдлийг даатгах боломжгүй. Харин эрсдлийг нэг бол хожих, эсвэл алдах бус гагцхүү хохирол учрах магадлалтай эрсдлийг л даатгах боломжтой. Жишээлэхэд, гал түймрийн улмаас зөвхөн хохирол л амсана.

Даатгалын гол үүрэг нь даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн олгож, эрсдэлд орохос өмнөх санхүүгийн байдлыг нь сэргээхэд чиглэдэг ба харин даатгуулагчид ашиг олгох зорилго агуулдаггүй. Өөрөөр хэлбэл, гай зовлон тохиолдоход таныг болон танд хамааралтай хүмүүсийг хамгаалах нэг арга нь даатгал юм. Гамшиг зовлон, аюул осол тохиолдохгүй байж болох хэдий ч тохиолдох эсэх нь биднээс шалтгаалахгүй учраас даатгалын ачаар түүнийг хохирол багатай давах боломжтой.



5.2.2. Даатгалын зарчим

Америкт 1800-гаад оны сүүлээр нэгэн ноцтой хэрэг гарчээ. Зургаан залуу нийлж нэгэн настай хүнийг даатгуулан түүнийг нас барагад даатгалын нөхөн төлбөрийг хувааж авахаар тохиролцон гэрээ хийсэн байна. Тэд сар бүр маш өндөр даатгалын хураамж төлж эхэлсэн. Нилээд хугацаанд их хэмжээний хураамж төлсөөр сүүлдээ бухимдаж, хөгшний амийг хөнөөж, шийтгэгдсэн байна. Энэ үеэс хойш аливаа этгээд өөрт хамааралгүй хүний өмнөөс амь насыг нь даатгуулж, гэрээ байгуулахыг хоригложээ. Ийнхүү даатгалыг мөрийтэй тоглоомоос ялгасан **даатгуулагчийн ашиг сонирхлыг илэрхийлсэн байх** гол зарчим үүссэн байна. Өөрөөр хэлбэл, даатгал нь тухайн этгээдийн өөрийнх нь болон гэр бүлийнх нь ашиг сонирхлыг хамгаалсан байхаас биш өөрт хамааралгүй хүний өмнөөс даатгуулахгүй гэсэн үг.

Даатгуулагч даатгалын байгууллагад даатгуулах зүйлийнхээ талаар үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээлэл өгөх үүрэгтэй байдаг. Үүнийг **ил тод, итгэл үнэмшилтэй байх** зарчим гэж нэрлэдэг. Даатгуулагчийн өгсөн мэдээлэл нь даатгалын гэрээ байгуулах үндэслэл болдог учраас даатгуулагч өөрийн мэдэж байгаа болон мэдэх ёстой бүх мэдээллийг

үнэн зөв өгнө. Даатгуулсан зүйлд нь хохирол учирвал хохирлын бодит хэмжээгээр даатгалын байгууллагаас нөхөн төлбөр авахаас бус илүү авах боломжгүй. Ингэхдээ тухайн нөхөн төлбөр нь даатгалын гэрээнд заасан үнэлгээнээс хэтрэх ёсгүй байдаг. Үүнийг **нөхөн төлбөрийн зарчим** ч гэж нэрлэдэг. Энэ нь мөнгөө зээлдүүлж оронд нь байшин барьцаалсан этгээдээс зээлүүлсэн мөнгө, хүү, зайлшгүй гарсан зардлаасаа илүүг авах ёсгүй байдагтай адил юм.

Даатгалын компани нэгдүгээрт, хохирол нь тодорхой, санхүүгийн хувьд хэмжих боломжтой эрсдлийг даатгадаг. Даатгах боломжгүй эрсдлийг даатгавал үр ашиггүй байх болно. Хэн нэгэнд учруулсан сэтгэл санааны хохирлыг үнэлэх боломжгүй байдаг. Энэ тохиолдолд хураамж болон үнэлгээг тооцох боломжгүй юм. Хоёрдугаарт, хохирол нь санамсаргүй байх эрсдлийг даатгадаг. Хохирол хэзээ, хаана, ямар тохиолдолд болох нь тодорхойгүй байх нөхцөлд бас даатгадаг. Жишээ нь, Дорж таксины үйлчилгээ эрхэлдэг бөгөөд түүнд замын хөдөлгөөнд оролцож явахдаа осолд орох эсэхийг таамаглах боломжгүй. Харин Доржид учирч болох санамсаргүй хохирлыг даатгах боломжтой.

5.2.3. Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалт

Монгол Улсын Даатгалын тухай хууль анх 1997 онд батлагдаж, дараа нь 2004 онд шинэчлэгдсэн. Энэ хуулийн дагуу 2009 оны байдлаар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ердийн даатгалын 15, урт хугацааны буюу амьдралын даатгалын 1, давхар даатгалын 1 компани, даатгалын зуучлагч 4 компани, даатгалын 1167 төлөөлөгч даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих замаар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо юм. Та энэ байгууллагын талаар болон бусад нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл www.frc.mn вэб сайтаар орж үзэх эсвэл тус Хороон дээр биеэр ирж аливаа мэдээлэл зөвлөгөө авах боломжтой. Даатгалын компаниудын хаяг, утас вэб хаягийг Хавсралт 6, 7-оос үзнэ үү.

5.2.4. Даатгалын зуучлагч, төлөөлөгч

Даатгалын үйлчилгээг “даатгалын зуучлагч” ба “даатгалын төлөөлөгч” харилцагчдад хүргэдэг. Та даатгуулагчийн хувьд зөвлөгөө авахыг хүсвэл даатгалын зуучлагчид хандаарай. Даатгалын зуучлагч нь даатгуулагчид үйлчилж зөвлөгөө, заавар өгөх чиг үүрэгтэй байдаг бол даатгалын төлөөлөгч нь даатгалын байгууллагыг төлөөлөн төв байрнаасаа өөр газарт үйлчилгээг нь хүргэдэг. Тухайлбал, Монгол даатгал компани нь бүх аймагт төлөөлөгчтэй.

Даатгалын зуучлагч нь

- Тодорхой төрлийн даатгал нь ямар эрсдлийг даатгах вэ?
- Ямар эрсдлийг даатгалд хамааруулахгүй вэ?
- Бусад ямар онцлогийг мэдэх шаардлагатай вэ?
- Та энэ гэрээг хийх нь зүйтэй юу?
- Таны хэрэгцээнд илүү тохирох өөр төрлийн даатгал байна уу? гэх зэрэг асуултад хариулт авахад тань туслах болно.

Даатгалын зуучлагч нь даатгал хийлгэхээр зорьж буй даатгуулагчид мэргэжлийн зөвлөгөө өгөх, эрсдлийг нь үнэлж хамгийн тохиромжтой даатгалыг санал болгох үндсэн үүрэг хүлээнэ.

Харин даатгалын төлөөлөгч нь даатгалын компанийхаа нэрийн өмнөөс борлуулалт хийх үүрэг хүлээдэг.

5.2.5. Даатгалын хэлбэр

Даатгал нь сайн дурын ба заавал гэсэн хэлбэртэй байдаг. Заавал даатгалыг хуулиар тогтооно. Жишээ нь, олонхи улс орнуудад жолоочийн хариуцлагын даатгалыг заавал даатгал гэж хуульчилсан байдаг. Уг хуулиар жолооч хариуцлагаа даатгуулаагүй нөхцөлд замын хөдөлгөөнд оролцохыг хориглосон байдаг.

Сайн дурын даатгалын хэлбэрүүдийг дор дурдсанаар ангилдаг:

Ердийн даатгал:

- гэнэтийн осол, эмчилгээний зардлын
- хөрөнгийн
- автотээврийн хэрэгслийн
- ачааны
- барилга угсралтын

- газар тариалангийн
- мал амьтдын
- агаарын хөлгийн
- авто тээврийн хэрэгслийн
- жолоочийн хариуцлагын
- санхүүгийн Г.М.

Урт хугацааны даатгал:

- хугацаат
- насан туршийн
- хуримтлалын
- тэтгэврийн
- эрүүл мэндийн Г.М.

Даатгалын байгууллагад эдгээр даатгал хийх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгодог. Хөрөнгийн даатгал дотроо гэр хашаа байшингийн, эд хогшлын, цахилгаан хэрэгслийн гэх мэтээр хуваагдана. Дэлгэрэнгүй мэдээллийг www.frc.mn сайтаас үзнэ үү.

5.2.6. Давхар даатгал

Даатгалын компани нь өөрийн хүчин чадлаас хэтэрсэн хэмжээний эрсдлийг даатгасан тохиолдолд энэ эрсдлээ багасгах зайлшгүй шаардлагатай болдог. Иймд даатгалын компани өөрийн эрсдлийн зарим хэсгийг дахин өөр компанид даатгуулдаг. Энэ үйл ажиллагааг давхар даатгал гэж нэрлэдэг. Давхар даатгалын үндсэн зорилго нь даатгуулагчийн өмнө хүлээх үүргээ баталгаажуулж байгаа хэрэг юм.

Даатгалын үндсэн баримт бичиг нь даатгалын гэрээт баталгаа байдаг бол давхар даатгалын хувьд энэ баримт нь давхар даатгалын гэрээ байдаг. Энэ гэрээнд давхар даатгагч, даатгуулагчийн нэр хаяг, даатгалын зүйлийн талаарх мэдээлэл, даатгалын хугацаа, эрсдэл, зарим хасалтууд, үнэлгээ, анхны даатгагчид ногдох шимтгэл зэрэг мэдээллийг тусгасан байдаг.

5.2.7. Бичил даатгал

Дунд болон түүнээс дээш орлоготой хүмүүс өвдөх, хөрөнгө нь гэнэтийн ослоор устаж гэмтэх зэрэг эрсдэл тохиолдсон үед хадгаламжаасаа мөнгө гаргах зэргээр эрсдлийг давах чадавхи

харьцангуй гайгүй байдаг бол эмзэг бүлгийн хүмүүст ийм боломж бараг байдаггүй. Бичил даатгал нь аливаа улс орны ядуу буурай, өрх толгойлсон эхчүүд, нийгмийн эмзэг хэсэгт зориулсан даатгал юм. Бичил даатгал нь энэ утгаараа нийгмийн аль ч салбарт үйлчилж, зээлийн, гэнэтийн ослын, эд хөрөнгийн гэх мэт олон чиглэл хэлбэрийг агуулж байдаг.

5.2.8. Малын индексжүүлсэн даатгал

Манай улсын хувьд мал аж ахуй нь эдийн засгийн нэг чухал салбар бөгөөд малын хорогдоос учрах эдийн засгийн хохирол маш өндөр байдаг. Гэтэл даатгалын уламжлалт хэлбэрүүд малын даатгалд тохирдоггүй. Тухайлбал, 1999-2002 онд ган зудад нийт 11,2 сая мал хорогдож, 333 тэрбум төгрөгийн шууд хохирол учирчээ. Мөн энэ үеэр 12,100 өрх огт малгүй болж, малчин өрхийн тоо 26,7 мянгаар цөөрчээ. Мөн энэ байгалийн гамшгийн үеэр мал сүргээ хариулж яваад нийт 41 малчин амь насаа алдсан байдаг.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банк болон бусад гадаад, дотоодын өндөр мэргэшсэн зөвлөхүүдийн тусlamжтайгаар 2001 оноос малыг даатгахад тохиромжтой шинэ арга механизмыг судалж, “Малын индексжүүлсэн даатгал” төслийг хэрэгжүүлж байна.

Индекст суурилсан даатгал нь байгалийн гамшгаас учрах эрсдлээс хамгаалах зорилготой, тодорхой индекст үндэслэн хохирлын нөхөн төлбөрийг олгодог даатгалын хэлбэр юм. Даатгуулагчийн хохирлыг төлөхдөө бус нутгаар ялгаатай тогтоосон хохирлын дундаж түвшин, хохирол учрахад нөлөөлсөн хүчин зүйлийн хэмжээ зэрэг үзүүлэлтэд тулгуурлан нөхөн төлбөрийг индексжүүлэн төлдөг үндсэн зарчимтай.

5.2.9. Авто машины даатгал

Бидний амьдралд хамгийн түгээмэл байдаг даатгалын нэг нь авто тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгал юм. Жолоочийн хариуцлагын даатгал нь дийлэнх улс орнуудад заавал даатгалд хамарагддаг.

Компани тус бүрийн даатгалын гэрээ өөр өөрийн онцлогтой. Ихэнх тохиолдолд даатгалын компаниуд жолоочийн хариуцлагын болон тээврийн хэрэгслийн даатгалыг багцаар нь хэрэглэгчдэд санал болгодог. Жолоочийн хариуцлагын даатгал нь даатгуулагчаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирлыг төлөх

зорилготой байдаг. Мөн зарим даатгалын компани тээврийн хэрэгслээр зорчигчдын гэнэтийн ослын даатгалыг жолооч наарт санал болгодог. Энэ нь тухайн осолд орсон тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд учирч болох хохирлыг нөхөн төлөх зорилготой. Автотээврийн хэрэгслийн даатгал нь даатгуулагчийн авто тээврийн хэрэгсэлд учирч болох аливаа аюул ослоос үүсэх хохирлыг нөхөн төлөх зорилготой.

Тухайн даатгалын компани нь таны автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцох болон оролцоогүй үед, байгалийн гамшиг, галын эрсдэл болон шил хагарах аливаа тохиолдоос даатгадаг. Эдгээр эрсдлийн аль нэг нь тохиолдоход даатгалын байгууллага танд тодорхой хэмжээний мөнгөн төлбөрийг өгөхөөр гэрээ хийдэг. Үүнийг нөхөн төлбөр гэж нэрлэдэг. Гэхдээ энэхүү нөхөн төлбөрийг тодорхой дүнгээр хязгаарлаж өгдөг. Уг хязгаарласан дүнг даатгалын үнэлгээ гэж нэрлэдэг. Даатгалын үнэлгээг Иргэний хуульд заасны дагуу даатгагч болон даатгуулагч тал харилцан тохиролцож тогтооно. Хариуцлагын даатгалын хувьд даатгалын үнэлгээний оронд даатгалын хязгаар гэсэн нэр томьёог ихэвчлэн хэрэглэдэг. Жишээ нь, жолооч автомашиныхаа даатгалын үнэлгээг 5 сая гэж үнэлсэн нөхцөлд аливаа хохирол учирвал олгох нөхөн төлбөр нь 5 сая төгрөгөөс хэтрэхгүй.



Даатгалын гэрээнд гэрээний хүчинтэй байх хугацааг заана. Даатгалын хугацаа гол төлөв нэг жил байдаг. Өөрөөр хэлбэл, нэг жилийн хугацаанд гарах бүх нөхөн төлбөрийг гэрээнд заасны дагуу даатгагч хариуцна. Даатгалын компанид ийнхүү эрсдлээ шилжүүлэхдээ тодорхой хэмжээний мөнгө буюу даатгалын хураамж төлнө. Ихэнх даатгалын компаний хувьд тээврийн хэрэгслийн зориулалтаас хамаараад үнэлгээний дүнгийн 1-1.2 хувьтэй тэнцэх хураамж тогтоосон байдаг.

Даатгалын компани гэрээндээ нөхөн төлбөр олгох боломжгүй нөхцлүүдийг заавал зааж өгдөг. Тухайлбал:

- Тээврийн хэрэгслээ ашиглан гэмт хэрэг үйлдсэн
- Тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүнд шилжүүлсэн
- Тээврийн хэрэгслийг согтуугаар жолоодож явсан
- Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гарсан эрсдэл
- Даатгуулсан тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэл эзэмшсэн үеийн эрсдэл
- Сургалтын болон уралдаан тэмцээний үеийн
- Байгаль орчин бохирдуулахтай холбогдон гарсан хохирол
- Даатгалын хураамжийг бүрэн төлөөгүй үеийн нөхөн төлбөрийг тус тус олгохгүй байхаар гэрээний нөхцөлдөө тусгана.

Даатгалын компани болон даатгуулагч нар үнэлгээний жишиг доод хязгаарыг харгалzan даатгалын үнэлгээг харилцан тохирч тогтоох бөгөөд түүнд ногдох хураамжийг даатгагчийн тогтоосон хувиар тооцдог. Хураамжийг жилээр буюу нэг удаа, эсвэл сар сараар төлж болно.

Даатгалын компани нь хуулийн хэллэгээр “даатгалын тохиолдол” гэх аюул осол тохиолдоход гэрээнд заасны дагуу даатгуулагчид нөхөн төлбөр өгөх бөгөөд хэрэв даатгуулж буй хөрөнгийнхөө талаар Та буруу мэдээлэл өгсөн бол энэ нь даатгалын компаниас танд учирсан хохирлыг нөхөн төлөхгүй байх буюу төлбөрийн хэмжээг бууруулах үндэслэл болдог.

5.2.10. Урт хугацааны буюу амьдралын даатгал

Сүүлийн үед бидний мэдэх ердийн даатгалаас гадна урт хугацааны даатгал үүсч хөгжиж байна. 2008 онд амьдралын даатгалын анхны компани болох “Нэйшнл лайф даатгал” байгуулагдсан.



Хөгжингүй орнуудад амьдралын даатгал нь хүмүүсийн зайлшгүй хэрэгцээ болж хөгжсөн байдаг.

Жишээ: Иргэн А хашаа байшин авахаар банкнаас 5 сая төгрөгийн зээл авчээ. Ам бүл дөрвүүлээ, өрхийн орлогын 40 хувийг зээлийн төлбөрт, үлдсэнээ хоол хүнс бусад зүйлд зарцуулдаг аж. Зээл төлж дуусах хүртэл байнгын орлоготой байх хэрэгтэй. Гэвч үүнийг баталгаатай хэлэх боломжгүй. Энэ тохиолдолд Иргэн А-д урт хугацааны даатгал буюу зээлийн даатгал туслах болно.

Үүнтэй холбогдуулан амьдралын буюу урт хугацааны даатгалын ерөнхий ойлголтыг товч танилцуулья. Амьдралын даатгал нь хүн өөрийгөө болон гэр бүлээ санхүүгийн бэрхшээлээс хамгаалах зорилготой даатгал юм. Тухайлбал, гэр бүлээ тэжээж ажил эрхэлдэг хүн амь насаа алдах тохиолдолд түүний гэр бүл, үр хүүхэд санхүүгийн хувьд хүндрэлд орох болно. Харин амьдралын даатгалтай бол түүний үр хүүхдүүд нөхөн төлбөр авна. Олон төрлийн амьдралын даатгал байдаг бөгөөд өргөн сонголт бүхий баталгааг санал болгодгоороо даатгуулагчийн нийгэм-эдийн засгийн цогц асуудлыг шийдвэрлэх боломж олгодог. Иймээс амьдралын даатгалын зорилгыг ерөнхийд нь нийгмийн болон санхүүгийн гэж хоёр ангилж болно.

Нийгмийн зорилго нь:

- Гэр бүл тэжээгчээ, эсвэл нэг гишүүнээ алдан орлогогүй болох тохиолдолд санхүүгийн хамгаалалт болох

- Түр хугацаанд, эсвэл бүрмөсөн хөдөлмөрийн чадвараа алдсан үед хангамж эдлэх
- Насан өндөр болох үедээ нэмэгдэл тэтгэвэр авах
- Үр хүүхдээ насанд хүрэхэд нь эд материалын туслалцаа үзүүлэх зорилгоор хуримтлал үүсгэх
- Оршуулгын зардлыг нөхөх гэх мэт.

Санхүүгийн зорилго:

- Хөрөнгө оруулалтын орлого олохтой холбоотой хуримтлал үүсгэх
- Аж ахуйн нэгжийн удирдагч, хөрөнгө оруулагч зэрэг нь нас барсан тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг нь хамгаалах
- Гэрээслэлийг баталгаажуулах
- Өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх г.м.

Урт хугацааны даатгалын гэрээг үндсэн гурван төрөлд ангилдаг.

1. Хугацаат даатгал
2. Насан туршийн даатгал
3. Хуримтлалын даатгал

Хугацаат даатгал. Даатгалын хугацаанд даатгуулагч нас барсан тохиолдолд нөхөн төлбөр олгодог даатгалын хэлбэр юм.

Жишээ: Иргэн Б бага насын хоёр хүүхэдтэй. Эднийх хашаа байшингаа таван жилийн хугацаатай зээлээр худалдан авсан байна. Б энэ хугацаанд ямар нэг байдаар хөдөлмөрийн чадваргүй болсон ч зээлийн төлбөрөө төлөх л учиртай. Иймд тэрээр таван жилийн хугацаанд амь нас, эрүүл мэндээ даатгуулах боломжтой. Хэрэв Б даатгалтай байх хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдах юмуу нас барвал түүний зээлийн төлбөрийг даатгалын байгууллага хариуцна.

Насан туршийн даатгал. Энэ нь бүхий л амьдралын хугацаанд хийгдэх даатгал бөгөөд даатгуулагч нь хэзээ ч нас барсан нөхөн төлбөр олгодог даатгалын хэлбэр юм. Энэ тохиолдолд даатгуулагчийн өв залгамжлагчид буюу үр хүүхэд нь санхүүгийн хамгаалалтад орж байна гэсэн үг юм.

Хуримтлалын даатгал. Энэ даатгал нь нөхөн төлбөрөө хугацааны эцэст даатгуулагч өөрөө авах нөхцөлтэй бөгөөд даатгуулагч гэрээгээр тогтоосон хугацаанаас өмнө нас барвал нөхөн төлбөрийг гэр булийн гишүүд нь авна.

Үүнээс гадна урт хугацааны даатгалын нэмэгдэл багцууд буюу тэтгэврийн даатгал, иргэдийн хадгаламжийн даатгал, аннуит гэрээ зэрэг хэлбэрүүд байдаг. Аннуит нь хураамж төлсний үндсэн дээр даатгуулагчид тодорхой хугацааны туршид мөнгөн төлбөр төлөх хэлбэр юм. Мөн нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдвал гэрээний нөхцлөөс хамааран тодорхой наснаас эхлэн насан туршдаа, эсвэл тодорхой хугацаанд сар бүр тэтгэвэр авах боломж олгодог. Жишээ нь, бид нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн даатгалын хураамжийг сар бүр цалингаасаа 7 хувиар бодож төлдөг. Тэтгэврийн насанд хүрэх үед таны авах тэтгэвэр хангалтгүй гэж үзвэл хувийн даатгалын компаний нэмэлт тэтгэврийн даатгалд хамрагдаж болдог.

5.2.11. Даатгалын бүтээгдэхүүнээ сонгох нь

Даатгалын байгууллагуудын санал болгодог олон төрлийн даатгалаас хэрхэн сонголт хийх талаар товч зөвлөе.

Нэгдүгээр алхам. Бидний олонхи нь ирээдүйд эрсдэл учирвал юу хийх, яах тухайгаа бодохгүй амьдардаг. Хэрэв Та ажлаасаа халагдвал, эсвэл өвдөвөл танайх санхүүгээ хямралгүй авч явах чадвартай юу? Дараах асуултуудыг уншаад одоогийн байдлаа тодорхойлж, ямар үед нэмэлт тусламж шаардлагатай болохыг доорх асуултуудын хүрээнд тодорхойлоорой.

Танд даатгал хэрэгтэй юу?

Танд юу ч тохиолдсон гарч болох бүх зардлаа төлж чадах хүрэлцээтэй орлого байгаа эсэхээ тооцож үзээрэй. Энэ нь эд зүйлээ хулгайд алдах, эvdэрч гэмтэх, эсвэл орлогоо алдах үед санхүүгийн асуудлаа шийдэхэд тань туслах болно.

Хэрэв Та, эсвэл таны гэр булийн гишүүн өвдөж хөдөлмөрийн чадваргүй болвол яах вэ?

Энэ төрлийн хамгаалалтын даатгалууд байдаг хэдий ч хязгаарлагдмал цаг хугацаанд хүчинтэй байх бөгөөд бүх өвчнийг хамардаггүй. Иймээс даатгуулахын өмнө гэрээний нөхцөл, хасалтуудыг сайн судлах хэрэгтэй.

Хэрэв Та, эсвэл таны гэр бүлийн хүн гэнэт нас барвал яах вэ?

Та, эсвэл таны хань ганцаараа гэр бүлээ тэжээх чадвартай юу? Амьдралын даатгал таны ард үлдэх гэр бүлд тодорхой хэмжээний санхүүгийн хамгаалалт бий болгодог. Мөн тэтгэврийн даатгалаас таныг нас барвал танай гэр бүлд хэдий хэмжээний мөнгө өгөх вэ гэдгийг тооцож үзэх нь зүйтэй.

Та орон сууц, эсвэл хашаа байшин, гэр өмчилдөг үү?

Та зээлээр хашаа байшин авсан гэж бодье. Уг хашаа байшин гал, үерт автсан ч тэрээр барьцаат зээлийн мөнгөө төлөх ёстой. Ихэнх зээл олгогч зээл өгөхдөө зээлээр авч буй хашаа байшинаа заавал даатгуулсан байхыг шаарддаг.

Таны эдэлж хэрэглэдэг зүйлсийн тухайд?

Эд хөрөнгөө хамгаалах нь таны үүрэг. Тавилга, цахилгаан хэрэгсэл, телевиз, компьютер, радио, камер, үнэт эдлэл гэх мэт эд зүйлсийг эд хөрөнгийн даатгалд даатгуулж болно. Эдгээрийн үнэ өргтийг зөв тодорхойлох хэрэгтэй. Багаар үнэлж даатгуулах нь хямд тусах хэдий ч танд хохирол учирвал нөхөн төлбөр нь бага байх болно.

Та автомашин эзэмшдэг үү?

Машинаа даатгуулах нь зүйтэй. Мөн жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдаж болно. Даатгуулахын өмнө гэрээгээ сайтар судал. Ихэнх даатгал сайн дурын байдаг. Энэ нь ямар даатгалыг, аль хэр хэмжээгээр авах хүсэлтэй байна түүгээрээ шийдэх боломжийг танд олгож байгаа юм.

Хоёрдугаар алхам. Дээр заасан мэдээлэлд тулгуурлан Танд ямар даатгал хэрэгтэйг мэдэх болно.

Шинээр даатгуулах гэж байгаа бол дараах зүйлийг сайтар судлах нь зүйтэй.

- Гэрээний нөхцөл болон хасалтуудаа хянаж үзээд таны хэрэгцээнд тохирч байгаа эсэхийг хяна.
- Хамрагдах эрсдэл, даатгалын үнэлгээг сайтар үзэх, хэрэв таны оршин суугаа хаяг өөрчлөгдөх зэрэг нөхцөлд даатгалын үнэлгээ, хураамжид өөрчлөлт орох эсэхийг асуу.
- Үндсэн даатгалын хамралтаас гадна нэмэлт нөхцлийг сайтар үзэх нь зүйтэй. Тухайлбал, өрхийн эд хөрөнгийн даатгалд тухайн эд хөрөнгийг хулгайд алдсантай холбогдон гарах бусад зардлын эрсдлийг зарим компани даатгасан байдаг.

Гуравдугаар алхам. Худалдан авах даатгалаа сонгосон бол хэд хэдэн компаний нөхцлийг олж үз. Тэдгээрийг хураамжийн хэмжээгээр нь харьцуулж үзэхээс гадна хамралт, үнэлгээ, хасалтаар нь харьцуулаарай.

Одоо хашаа, байшингаа даатгуулах жишээн дээр ямар алхам хийх талаар авч үзье.

- Та хашаа байшингаа даатгуулах компания сонгоно. Уг даатгалын компани Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй эсэхийг үз.
- Сонгосон компани дээрээ очиж “Хашаа, байшингийн даатгалын нөхцөл заавар”, даатгалын гэрээнд заасан нөхцлийг унш.
- Хашаа байшингаа хэдээр үнэлж даатгуулах талаар өөрөө сонголтоо хийнэ. Та аль болох зах зээлийн үнээр нь даатгуулбал учирсан аливаа хохирол бүрэн төлөгдөх боломжтой. Харин бодит үнээс илүү үнэлж даатгуулбал даатгалын гэрээ хүчингүй болдгийг анхаараарай.
- Үнэлгээгээ даатгалын компаний ажилтантай тохиролцоно.
- Хашаа байшингаа үер ус, бороо цас, шуурга, гал гэх мэт ямар эрсдлээс даатгуулахаа тохиролц.
- Даатгалын гэрээний бусад хэсгүүдийг сайтар хар. Даатгалын компани нөхөн төлбөрөө ямар нөхцөлд өгөх, эсвэл өгөхгүй болох, мөн бууруулж өгөхийг сайтар ярилц.
- Даатгалын компани болон таны хүлээх үүрэг, эдлэх эрхийг гэрээнд хэрхэн тусгасан талаар үзэж танилц.
- Даатгалын тохиолдол бий болсон буюу эрсдэл учирахад ямар хугацаанд ямар журмаар даатгагчид мэдэгдэх талаар лавла.
- Даатгалын хураамж хэдэн хувиар төлөхөө тодруулж асуугаад хураамжаа төлөх нь зүйтэй.
- Сүүлийн шатанд даатгалын гэрээ болон даатгалын баталгаагаа баттай, мартахгүй газар хадгал.

Эцэст нь зөвлөхөд танд хэрэггүй даатгалд бүү хамрагдаарай. Амархан гэмтэж, хохирол учруулах зүйлүүдээ эхний ээлжинд даатгуулах нь ашигтай. Өөрийн хүлээж чадахаас илүү их хэмжээний алдагдалд өөрийгөө хэзээ ч бүү оруул. Багахан хэмжээний ашиг бодон даатгалын хураамж хэмнэх гэж өөрийгөө асар их хэмжээний эрсдэлд бүү оруулаарай.

5 ДУГААР БҮЛЭГ. МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ АСУУЛТУУД

1. Та есөн давхар орон сууцанд амьдардаг гэж бодьё. Танай СӨХ-оос сар бүр даатгалын хураамжид 500 төгрөг төлөх санал тавьжээ. Та үүнийг зөвшөөрсөнгүй, харин танай яг дээр амьдардаг хөрш энэ хураамжийг төлдөг байна. Гэтэл хөрш тань танайх уруу ус алдаад танайд засвар хийхэд гарсан 50,000 төгрөгийн зардлыг даатгалын компани төлж барагдуулсан байна. Сар бүр 500 төгрөг төлөхөөс татгалзсан таны шийдвэр зөв байж уу?
2. Та 40 настай, эмэгтэй, сарын 350 мянган төгрөгийн цалин авдаг. 10 жилийн дараа тэтгэвэрт гаражад сард энэ мөнгөнийхөө 30-40 хувьтай тэнцэхүйц хэмжээний тэтгэвэр авна гэж үзье. Гэтэл энэ мөнгө таны амьдралд дутуу дулимагхан л хүрэх байх, энэ тохиолдолд та яах вэ? Та амьдралын урт хугацааны даатгалыг сонирхож үзсэн үү?
3. Танай хөрш хашаа байшингаа даатгуулжээ. Энэ нь хашаа байшинд учирч болох бүх төрлийн эрсдлээс (үер ус, салхи шуурга, гал түймэр, хулгай зэрэг) учирсан хохирлыг нөхөн төлж барагдуулна гэсэн үг мөн үү? Биш гэж бодож байгаа бол ямар тохиолдолд учирсан хохирлыг барагдуулахыг яаж мэдэх вэ?
4. Ямар хөрөнгөө даатгуулах вэ, даатгалын хураамж нь хэдий хэмжээтэй байх вэ? Ямар тохиолдолд хэдий хэмжээний нөхөн төлбөр авч болох вэ? гэх зэрэг асуултад хэн зөвлөж чадах вэ?
5. Даатгуулах хөрөнгөө сонгоод даатгалын байгууллага дээр очиж санал болгосон нэг хэвийн маягтаар гэрээ байгуулаад, даатгалын төлбөрөө төлчихөөд санаа амарч болох уу? Даатгалын гэрээг сайн судалж үзэхийн ач холбогдлыг тунгааж бодсон уу?

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хувийн санхүүгийн зорилгоо тодорхойлох хүснэгт

Та өнөөгийн санхүүгийн байдал, ирээдүйн хүлээлт дээрээ үндэслэн урт болон богино хугацааны 2 зорилгыг дараах зааврын дагуу тодорхойлно уу.

1. Өнөөгийн амьдралын нөхцөл байдалдаа үндэслэн зорилгоо бодитой тодорхойлох

А. Богино хугацааны зорилго

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Б. Урт хугацааны зорилго

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

1. А, Б зорилгуудаа тодорхой, хэмжиж болохуйц байдлаар илэрхийл.

А.
.....
.....
.....
.....

2. Зорилгоо хэрэгжүүлэх хугацааг тодорхойл.

А.
.....
.....
.....
.....

4. Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойл.

А.
.....
.....
.....
.....

Хавсралт 2. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын мэдээлэл

| Мэргэжлийн байгууллагын нэрс | Хариуцсан аймаг, нийслэл чиглэл | Эрхлэх үйл ажиллагааны чиглэл | Гүйцэтгэх захирал нэр | Утас | Хаяг |
|------------------------------|---------------------------------|--|-----------------------|-----------------------------|--|
| 1 Монголын хөрөнгийн бүрж | Улаанбаатар | | P.Содхүү | 310501 | УБ хот Сүхбаатарын талбай-2 |
| 2 ЦТТТХТ | Улаанбаатар | | Т.Гандулам | 99110251 | Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай-2, Хөрөнгийн бирж 2 давхар |
| 3 СанлавМэд | Улаанбаатар | хөрөнгө оруулалтын зөвлөх | Л.Оюун | 992776104 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 14а байр 41 тоот |
| 4 Масдак | Улаанбаатар, Сэлэнгэ | брокер, диллер | В.Баттулга | 998881008 | СБД-ийн 2-р хороо "Монгол шаазан" ХК-ийн байр 2 давхар 201 тоот |
| 5 Санар | Улаанбаатар, Дундговь, Дорнговь | брокер, диллер | Б.Энхбаяр | 462634, 99114027, 966669730 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороо, "Санар ХХК-ийн байр |
| 6 Эрэгэд | Улаанбаатар | брокер, диллер | Ш.Эрдэнэ | 99297779, 367609, 99172256 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 5-24. |
| 7 Мэргэн санаа | Улаанбаатар | брокер, диллер | П.Ган-Очир | 99193878, 451626 | БЗД 7-р хороо 15-р хороолол 30-67 тоот |
| 8 Би Ди Сек | Улаанбаатар, Төв | брокер, диллер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх | Д.Даянбилигүүн | 99112846, 313108 | СБД 8-Р Хороо залуучуудын өргөн чөлөө 27-1 |

| | | | | | | |
|----|-------------------------|---|----------------|-----------------|-------------------------------|---|
| 9 | Өндөрхаан инвест | Улаанбаатар, Хэнтий | брокер, диллер | Н.Оюунтунгалааг | 99081660, 318590 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, “Аэргеодези” ТӨХК-ийн байр 301 тоот. |
| 10 | Алтанхоромсог | Улаанбаатар | брокер, диллер | Т.Монхор | 99114511, 450899 | БЗД-ийн Үндэсний хоршоолчдын холбоо, 317 тоот |
| 11 | Булган брокер | Улаанбаатар, Булган | брокер, диллер | Д.Амгалан | 96655849, 99194913, 322708 | Сүүлийн гудамж “Монгол ном” компанийн байр 5 тоот |
| 12 | Дархан брокер | Улаанбаатар, Дархан-Уул | брокер, диллер | Ж.Очирсүх | 99083716, 362542 | Дархан-Уул аймаг Дархан сум 10-р баg, Залуучуудын өргөн чөлөө 380-1 |
| 13 | Эрдэнэст | Улаанбаатар, Эрдэнэт | брокер, диллер | У.Болдбаатар | 99116322, 96776490, 315582 | ЧДИЙН 1-р хороо “Мончел” ХХК-ийн 403 тоот |
| 14 | Монсек | Улаанбаатар, Дорнод, Сүхбаатар | брокер, диллер | М.Огтонбаатар | 91918840, 70153090 | Баянзүрх дүүрэг, хөдөө аж ахуйн хоршоолчдын холбооны 501 тоот |
| 15 | Тулгат чандмань баян | Улаанбаатар, Увс | брокер, диллер | Б.Батсайхан | 99193878 | БГД, 4-р хороо “Өгөөмөр” СӨХ-н байранд. |
| 16 | Бумбат алтай | Улаанбаатар, Ховд | брокер, диллер | О.Ширэндэв | 99431202 | Ховд аймаг, Жаргалант сум, III-р 60 байр, 51 тоот |
| 17 | Алтан сан | Улаанбаатар, Баянхонгор, Архангай | брокер, диллер | Б.Цэндсүрэн | 99091811, 311558 | Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гранд оффис, 1 давхар |
| 18 | Таван богд | Улаанбаатар, Баян-Өлгий | брокер, диллер | Кагбатын Алия | 99089224, 313291 | Баян-Өлгий аймаг Өлгий сум 5 дугаар баg 2-12 дугаар байр 03 тоот |
| 19 | Аргай бест | Улаанбаатар, Говь-Алтай | брокер, диллер | Д.Ариунболд | 99113297, 327026 | Чингэлтэй дүүрэг 3 дугаар хороо, 2-р 40000-ийн 1-33 тоот |

| | | | | | | |
|----|---------------------------|----------------------------|--|----------------|-----------------------------|---|
| 20 | Дэлгэрхангай секоритиз | Улаанбаатар | брокер, диллер | М.Бат-Оргил | 99114648, 55252453 | БГД 5-р хороо энхтайвны өргөн чөлөө-89 |
| 21 | Ники | Улаанбаатар | брокер, диллер | Ө.Түвшинжартал | 99112460, 324790 | СБД Гэндэнийн гудамж, гэрлэх ёсполын ордон 304 тоот |
| 22 | Гендекс | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Б.Батхуяг | 91914767, 77224777 | СБД-ийн 5-р хороо, Сөүлийн гудамж-31, Аэрофлотын байр 1 тоот |
| 23 | Монет | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Л.Жавзмаа | 91916713, 320773, 321899 | УБ хот, СБД, Ерөнхий сайд Амарын гудамж, "ҮНЭН" сонины байр 201, 202 тоот |
| 24 | Ханш инвест | Улаанбаатар | брокер, диллер | Ц.Алтанчимэг | 91999728, 99875387, | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Муэхороо, 202 тоот |
| 25 | Монгол секортиес | Улаанбаатар, Өвөрхангай | брокер, диллер, андеррайтер | О.Гүндэгмаа | 99116215, 462130 | БЗД 8-р хороо 22-р бааз ХК- ийн "Б" байр 101 тоот |
| 26 | Ворлдкей | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Н.Мянганбаяр | 99114220, 330594 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Зоосбанк 5-6 |
| 27 | БАТС | Улаанбаатар | брокер, диллер | Д.Батнасан | 99111134, 321013 | СБД 7-р хороо, 11 хороолол, 9-97 |
| 28 | Глобал asset | Улаанбаатар | брокер, диллер, хөрөнгө оруулалтын зөвлөх | Ким Бом Сок | 320889 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Орентал плаза 401 |
| 29 | Си Си Пи | Улаанбаатар, Өмнөговь | брокер, диллер | С.Гантулга | 91910191, 331754 | Баянгол, 1-р хороо, 2-р хороолол, Богд Ар-7А-77 |
| 30 | Фронтier | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Масатерү Игата | 345965 | ХУД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Нарлаг хотхон, 4А байр-26 тоот |

| | | | | | | |
|----|-----------------------------|-------------|--|----------------|--------------------|--|
| 31 | Блумсбюрии секьюритис | Улаанбаатар | Брокер, диллер, андеррайтер | Б.Мягтмарсүрэн | 91101066 | Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж, "lighthouse center" 402 |
| 32 | Ди Си Эф | Улаанбаатар | Брокер, диллер | Т.Жигмэддэвага | 70110138 | ЧД 4-р хороо хүчинчий НЭГИЙН ард 12-14 тоот |
| 33 | MICC | Улаанбаатар | Брокер, диллер, андеррайтер | Д.Ачид-Эрдэнэ | 99110641, 70112023 | Чингэлтэй, 1-р хороо, Худалдааны гудамж, "АНОД" банкны байр-01 |
| 34 | Арта Инвест | Улаанбаатар | Брокер, диллер | М.Тэмүүжин | 99098637 | Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, 39-в-37 |
| 35 | Санхүүгийн хөгжил инвест | Улаанбаатар | Брокер, диллер | Я.Баттотох | 352698, 70111563 | СБД, 7-р хороо, 11-р хороолол, 4-105 |
| 36 | Эф Си Икс | Улаанбаатар | Брокер, диллер, андеррайтер | Л.Нямдагва | 88117001, 70163109 | Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, 19-52 |
| 37 | ТТСек | Улаанбаатар | Брокер, диллер | Ц.Бүрэнжаргал | 966663123 | Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 15-р хороолол, 376-1 тоот |
| 38 | Зюс Капитал | Улаанбаатар | Брокер, диллер, хөрөнгө оруулалтын зөвлөх | А.Тамир | 99111183, 331436 | Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Хатансүйх үйлдвэрлэл, Үйлчилгээний барилгын 4 давхар |
| 39 | Нортон сек | Улаанбаатар | Брокер, диллер, андеррайтер | М.Ганзориг | 99119854, 88832337 | Баянгол, 17-р хороо, 4-р хороолол, 18 байшин – 301, 302, 303 |
| 40 | Эм Ай Би Жи | Улаанбаатар | Брокер, диллер, андеррайтер | Б.Дуламсүрэн | 99102487, 70111403 | Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 15А/5, Амбассадор Оффис бизнесийн төвийн 501 тоот |
| 41 | Гаули | Улаанбаатар | Брокер, диллер, андеррайтер | Ким Сын Квон | 91920776, 70153302 | Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Токио гудамж Сөүл-бизнес төвийн 202 тоот |

| | | | | | | |
|----|--------------------------------|-------------------------|--|--------------------|----------------------|--|
| 42 | Лайф тайм инвестмент | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Ж.Цэдэнрагчаяа | 458256, 98018899 | БЗД, 7-р хороо, 15-р хороолол, 2-132 |
| 43 | Евразия капитал Монголия | Улаанбаатар | брокер, диллер | Э.Тэмүүлин | 99005646 | Худ, Чингисийн өргөн чөлөө, жигүүр гранд "Sun town" 1-р корпус 2 давхар |
| 44 | Финанс линк групп | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Д.Түүл | 50059355, 314417 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 29 |
| 45 | Гүдсек | Улаанбаатар, Хөвсгөл | брокер, диллер, хөрөнгө оруулалтын зөвлөх | Ш.Гантулга | 99195815, 331878 | ЧД, Энхтайваны өргөн чөлөө, "Найман шарга интернейшнл" ХХК-ийн байр, 301 тоот |
| 46 | Монхантрейд | Улаанбаатар | брокер, диллер | Ким Ёо Су | 91910404, 70160000 | БЗД, 1-р хороо, 12-р хороолол, ХААХҮХ-ийн байр, 216 |
| 47 | Лондон азия капитал | Улаанбаатар | брокер, диллер, андеррайтер | Д.Бадамдаш | 99111279, 312307 | Бодь цамхаг, Сүхбаатарын талаи, Улаанбаатар-210620A |
| 48 | Тэнгри сөюритиес | Улаанбаатар | брокер, диллер | JOHN CHOMEL DOE | 8811-6290, 70130695 | Чингэлэй дүүрэг, 1 дүгээр хороо Жуулчны гудамж 22А- д орших "Тэнгри групп" ХХК- ийн охин компани болох "Мөнгөн хэтээс" ХХК-ийн байр |
| 49 | Өү Си Би | Улаанбаатар | брокер, диллер | П.Энхсайхан | 88116289 | Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9-р хороо 22-831 тоот. |
| 50 | Эм даблью ти эс | Улаанбаатар | брокер, диллер | Л.Энхтунгалаг | 9910-6030, 7011-6030 | Уб хот СБД 14201 Бага тойруу-2 6-р хороо 1/20 тоот |

Хавсралт 3. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй аудитын компаниудын жагсаалт

| № | Аудитын компаний нэрс | Захирлын нэр | e-mail | Утас | | Ажил | Факс |
|----|---------------------------|-----------------|---|----------------------------------|--------------------|--------|------|
| | | | | Гар | Гар | | |
| 1 | Далай ван- Аудит | Ц. Жигдэн | info@dalaivanaudit.mn, ceo@dalaivanaudit.mn, marketing@dalaivanaudit.mn | 99115430 | 305401-5 | 305403 | |
| 2 | Баталгаа онош – Аудит | Э.Гэрэлхүү | batalgaa_onosh_audit@yahoo.com | 88119360 99094773 | 99175870 | 315380 | |
| 3 | Их Наяд - Аудит | Б. Хорлоо | horloo@cpa.mn | 99125283 | 450410 | 450410 | |
| 4 | Ситико - Аудит | Л. Энхжаргал | citico@mongol.net | 91916406 99116406 | 330918 70116494 | 318318 | |
| 5 | Тэд Аудит | П. Болормаа | boloroo24@yahoo.com, oyunchime- gv@cpa.mn | 99190483 99280443 | 324610 | 324610 | |
| 6 | Итгэлт - Аудит | Г. Баянмөнх | itgelt_audit@mbox.mn | 91114040 | 451150 | 451150 | |
| 7 | Алтанжолоо – Аудит | П. Рэнцэнмэдаг | altanjoloo_audit@yahoo.com | 99124186 99237346 99005380 | 451072 | 451072 | |
| 8 | SM - Аудит | Ш. Сувдаа | suvdaa@cpa.mn | 99089081 | 311111 | 311111 | |
| 9 | Пантер Мидланд – Аудит | Б. Бямбасүрэн | panther_ub@yahoo.com, ololt@mail.mn | 99111770 99184746 | 319836 | 319836 | |
| 10 | Координат - Аудит | П. Баярмаа | ordinat@magicnet.mn, mgbayarmaa@yahoo.com | 99112171 99193732 | 686131 | 686131 | |
| 11 | Таван эрдэнэ – Аудит | П. Батсуурэн | batsuren@cpa.mn | 99090928 | 632834 | 682911 | |
| 12 | Улаанбаатар – Аудит | Б. Осоргарав | ubaudit_corp@mongol.net | 99113795 | 329430 | 321844 | |
| 13 | НИММ- Аудит | Ц. Гунгаанямбуу | nimmaudit@mongol.net | 99117589 | 463882 | 463882 | |
| 14 | Бисофт - Аудит | Т. Одончимэг | odonchimegt@cpa.mn | 99659029 99309002 | 323715 | 323715 | |

| | | | | | | |
|----|----------------------------|---|--|-----------------------|------------------|--------|
| 15 | Интер - Аудит | Л. Долгорсүрэн | interaudit@chinggis.com | 99116268 | 315318 | 315318 |
| 16 | Ди Эй Би Жи – Аудит | Н. Дэлгэрмаа | Buijdmaa@cpa.mn delgermaa@cpa.mn | 99112793 91910954 | 331759 | |
| 17 | Мэдээлэл - Аудит | Д. Товуудорж | info_audit@mobinet.mn | 91119511 99049511 | 369511 | 369511 |
| 18 | Бизон - Аудит | Л. Отгонбаяр | otgonbayar@bizcon.mn, info@bizcon.mn, | 99119107 | 312773 | 312773 |
| 19 | Жононван - Аудит | Б. Барбаатар | bb6356@yahoo.com | 91916921 | 310487 | 310487 |
| 20 | Монгексол - Аудит | Т. Энхтуул | tenkntuul@magicnet.mn | 99148495 992633879 | 344521 | 344521 |
| 21 | Энич - Аудит | Г. Чинтуяа | enich@magicnet.mn, chintuya@cpa.mn | 91918420 | 322115 | 322115 |
| 22 | Онч- Аудит | Д. Ончинсүрэн Д. Сайнбаяр | onch@onchaudit.mn sainbayar@onchaudit.mn | 99090450 99005072 | 329611 329611 | 329611 |
| 23 | Актив - Аудит | Ж. Оюунхаа | activaudit@mongolnet.mn, active.audit@yahoo.com | 99090549 99089815 | 330656 | 462051 |
| 24 | Эрнст энд Янг - Аудит | Alexander Chin | altansukh.ganbaatar@my.ey.com | 99702046 91918985 | 312005 | 312042 |
| 25 | Сулд - Аудит | Ч. Гундбаяр | gundbayar@cpa.mn | 91910113 55252512 | 344773 | |
| 26 | Конфиденс-Аудит | П. Ариуннаа | confid_audit@magicnet.mn | 96660444 | 322431 | 322431 |
| 27 | Нийслэл- Аудит | Т. Сугарсүрэн | city_invest@yahoo.com | 99115395 | 318918 | 318918 |
| 28 | Энхмэнх Хиймарь - Аудит | Төмөртогоо | | 99805734 | | |
| 29 | Багануур - Аудит | П.Уранчимэг | uranchimeg@cpa.mn | 99187473 | | |
| 30 | Тэнцвэр оргил Аудит | Шиванандхан Нитхиабала Амарсайхан | admin@toa.mn saixnaa3843@yahoo.com | 324496 99088202 | 324496 | |

| | | | | | |
|----|------------------------|---|---|--|----------|
| 31 | АЗУРИГТ АУДИТ | Бадамбазар Гантуяа | gantuya@cpa.mn | 99098727 | 323141г |
| 32 | МОН АУДИТ | ОТГОН ЧУЛУУНБААТАР ДЭШИГЖАВ НОРЖИН | | 99888102 | |
| 33 | Б ЭНД С АУДИТ | ДАШХОРЛОО БУРМАА | OUUN_@yahoo.com, ouungerel@cpa.mn | 99278085 96688102 99099155 966633284 | 50880878 |
| 34 | ГОЛДЕН ПЭЙЖ - АУДИТ | С.ОЮУНГЭРЭЛ Б.ЛХАГВАДУЛАМ, У.ОЮУНАА | ouulaa@cpa.mn, lhagvadulam@cpa. mn, mukhtsetseg@cpa.mn | 99087446 88007172 | 88007172 |
| 35 | ОД БУРТГЭЛ АУДИТ | Ё.ЛХАГВАДУЛАМ, У.ОЮУНАА | lhavga@yahoo.com | 99057603 99051826 | 96661828 |
| 36 | НЬЮ БАЛАНС - АУДИТ | Б.ЛХАГВАДОРЖ | | 99101901 | 70145542 |
| 37 | АКПАР - АУДИТ | Х.БАЯНБАЙ | bayanbai_havdan@yahoo.com | 91919758 | 462131 |
| 38 | АККУРЕЙТ- АУДИТ ХХК | Б.БУРМАА | burmaa@cpa.mn | 96663284, 99730808, 99801551 | 32 37 43 |
| 39 | МОНСТА АУДИТ ХХК | Т.БАГБААТАР | batbaatar@cpa.mn | 99199226 99082367 99117932 99059226 99192130 | 452944 |
| 40 | БАЛХАН-АУДИТ ХХК | Б.ЭРДЭНЭ-ОЧИР | ochiroo_b@yahoo.com | 99098173, 99093542 | |
| 41 | ЮНИСТАР-АУДИТ ХХК | Б.ТЭРБИШ | unistar-audit@mail.mn | 96655079, 99198825, 96685259, 99168961 | 327835 |

Хавсралт 4. Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээний компаниуд

| Nº | Харьяа байгууллага | Овог нэр | Хөрөнгийн үнэлгээний тусгай № | Сангийн сайдын тушаал | Регистр № | Улсын № | Бүртгэлийн утас | Байршил, Хаяг |
|----|--------------------------------------|----------------|-------------------------------------|-----------------------------|--------------|---------------------|---------------------|--|
| 1 | "Далайван" ХХК | Р.Буйвээбаатар | № 01 | | | | 305405 | |
| 2 | "НИММ"-аудит" ХХК | Ц.Гунгаанямбуу | № 02 | | | 463882, 99117589 | | |
| 3 | "Итгэлт -аудит" ХХК | Г.Баянмөх | № 03 | | | 363987, 91114040 | | |
| 4 | "Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК | Р.Зоригт | № 04 | | | 91916503 | | |
| 5 | "Дельтамон" ХХК | С. Доржсүрэн | № 05 | | | 99185604, 317581 | | |
| 6 | "Мон-Үнэлгээ" ХХК | Б.Минжмаа | № 06 | 2006/149 | 2580802 | 35/4188 | 333170, 99199610 | ЧД, 4-р хороо, Барилгачидын талбай, Барилга корпорацийн байр 01 тоот |
| 7 | "Лэндс" ХХК | Д.Ганхуяг | № 07 | | | 99116570, 316824 | | |
| 8 | "Бээгэ" үнэлгээний төв | Д.Санж | № 08 | | | 310076, 99194339 | | |
| 9 | "Эрдэнэс- аудит" ХХК | А.Өнөржаргал | № 09 | | | 350993 | | |
| 10 | "Ю Би Пропертиз" ХХК | Д. Энхбаатар | № 10 | | | 99115140 | | |
| 11 | "ЭМ ЭМ СИ ЭС" ХХК | Л.Пүрэв | № 11 | | | 302278, 99092099 | | |

| | | | | | |
|----|---------------------------|-----------------|------|----------|---|
| 12 | "Золач" ХХК захирал | Д.Алтанцэцэг | № 12 | | 91918844, 311746 |
| 13 | "Ситико-Аудит" | Л.Энхжаргал | № 13 | 2006/149 | 9011012054 Их тойруу-86 /Өөрийн байранд/ (Монгол 3-р сургуулийн зүүн тала) |
| 14 | "Итгэлт -бээс" ХХК | Ц.Баатар | № 14 | | 315637, 99151209 |
| 15 | "Итгэлт эстимэйт" ХХК | Ө. Эрдэнэбаатар | № 15 | | 99115638, 459958, 455088 |
| 16 | "Дабль дөрөөт" ХХК | Д.Бадамлянхуа | № 16 | | 99193268, 99890421 Сүхбаатарын талбай, Үнэн сонинь байр 408 тоот |
| 17 | "Мөнгөн капитал" ХХК | Д.Энхтайван | № 17 | | 360047 |
| 18 | "Хос од сервис" ХХК | М.Билэгтайхан | № 18 | | 91913289, 450814 |
| 19 | "Мөнх-Оргил трейд" ХХК | Б.Эрдэнэбаатар | № 19 | | 320523, 99183220 |

Хавсралт 5. Арилжааны банкуудын вэб хаяг

www.khanbank.com - Хаан банк
www.postbank.mn - Монгол шуудан банк
www.golomtbank.com - Голомт банк
www.tdbm.mn - Худалдаа Хөгжлийн Банк
www.savingsbank.mn - Хадгаламж банк
www.creditbank.mn - Кредит банк
www.capitalbank.mn - Капитал банк
www.ubcbank.mn - Улаанбаатар хотын банк
www.capitronbank.mn - Капитрон банк
www.xacbank.mn - Хас банк
www.transbank.mn - Тээвэр хөгжлийн банк
www.erelbank.mn - Эрэл банк
www.chinggiskhaanbank.com - Чингис хаан банк
www.nibank.mn - Үндэсний хөрөнгө оруулалтын банк

Хавсралт 6. Тусгай зөвшөөрөлтэй даатгалын компаниудын хаяг

| № | Даатгалын компаниудын нэр | Хаяг |
|----------|--------------------------------------|---|
| 1 | МОНГОЛ ДААТГАЛ | Сөүлийн гудамж, Улаанбаатар-210644, Утас: 976-11-313615 www.mongoldaatgal.mn |
| 2 | БОДЬ ДААТГАЛ | ЧД Сүхбаатарын талбай, бодь цамхаг 303 тоот Утас:70110280 www.bodiinsurance.mn |
| 3 | МИГ ДААТГАЛ | Чингэлтэй дүүрэг, 1хороо, Энхтайваны өргөн чөлөө ш/х-200 Утас: 330130, 330131 www.mig.mn |
| 4 | АРД ДААТГАЛ | СБД , Амарын гудамж -1 Таван богд плаза 15 тоот Утас:330083 www.arddaatgal.mn |
| 5 | ПРАЙМ ЖЕНЕРАЛ ДААТГАЛ | Амарын гудамж-8, Петровис компаний байр, Улаамбаатар хот Утас:312234 www.primedaatgal.mn |
| 6 | ТУШИГ ДААТГАЛ | УБ хот ЧД бага тойруу Зоос банкны байр 702 тоот Утас:316119 www.tushigdaatgal.mn |
| 7 | НОМИН ДААТГАЛ | УБ хот ЧД З хороо УИД 6-р давхар, Утас:330023 www.insurance.nomin.net |

| | | |
|----|------------------------------|--|
| 8 | УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ | УБ хот ЧД 1 хороо Жигжиджавын гудамж-4 Нийслэлийн өмчийн газар, Утас:70779827 www.ulaanbaatar.mn |
| 9 | УБ ДААТГАЛ | УБ хот СБД 6 хороо бага тойруу 37Б ОУХТ 302 тоот Утас:324828, 324176 www.ubdaatgal.mn |
| 10 | МОНГОЛ ТРАСТ ХОЛДИНГ ДААТГАЛ | УБ хот СБД Үнэн сонины байр 4-р давхар, Утас:330291 |
| 11 | МӨНХ ДААТГАЛ | УБ хот СБД бага тойруу 49-1-603 тоот Утас: 305254, 331332 www.munkhdaatgal.mn |
| 12 | ПРАКТИКАЛ ДААТГАЛ | УБ хот БГД Үндсэн хуулийн гудамж-24, Рокмон билдинг 304 тоот Утас:331525 www.practical.mn |
| 13 | ГАН ЗАМ ДААТГАЛ | УБ хот БГД ТЗУГ 3 давхар Утас:242634 |
| 14 | ЖОНОН ДААТГАЛ | УБ хот ЧД 1 хороо Жигжиджавын гудамж-6, Утас: 88112516 |
| 15 | НИЙСЛЭЛ ДААТГАЛ | УБ хот СБД 8 хороо Утас:331176, 99114278 www.niisleldaatgal.mn |
| 16 | НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ | УБ хот, СБД, Энхтайваны өргөн чөлөө 15А/5 Утас:70110784, 70110783 |

Хавсралт 7. Даатгалын зуучлагч компаниуд

- | | |
|---------------------|----------|
| 1. Аме ХХК | 70110449 |
| 2. Скай-Эрдэнэ ХХК | 88118171 |
| 3. Ачит ундарга ХХК | 55154006 |
| 4. Эм Жи Ай Би | 99092433 |
| 5. Асимон брокерс | 70116240 |

Хавсралт 8. Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд

Мөнгөний зах зээлд дараах гол хэрэгслүүд буюу үнэт цаас арилжаалагддаг. Үүнд:

1. Банк хоорондын зээл. Түр зуурын мөнгөний хомсдлоо нөхөх зорилгоор банкууд өөр хоорондоо болон Төв банкнаас богино хугацаатай зээл авахыг хэлнэ.

2. Арилжааны үнэт цаас. Ихэвчлэн санхүүгийн чадвар сайтай томоохон компаниуд, арилжааны банкууд богино хугацааны санхүүжилт олох зорилгоор арилжааны үнэт цаас гаргах бөгөөд хоёрдогч зах дээр өөр хоорондоо хямдруулан арилждаг.

3.Хадгаламжийн сертификат. Хадгаламжийн сертификатыг банкууд гаргадаг бөгөөд энэ нь мөн чанараараа хадгаламжтай адилхан, нэрлэсэн үнийнх нь дүнтэй тэнцүү хэмжээний хадгаламж гэсэн үг. Тодорхой хугацаатай, хүйтэй байдаг. Дараа нь мөнгөний хоёрдогч зах дээр өөр хоорондоо хямдруулан худалддаг.

4.Засгийн газрын богино хугацаат үнэт цаас. Засгийн газар төсвийн түр зуурын мөнгөний хомсдлыг нөхөх зорилгоор гаргадаг богино хугацаат санхүүжилтийн хэрэгсэл юм. Аль ч улсад Засгийн газрын үнэт цаас нь эрсдэлгүй, найдвартай үнэт цаасанд тооцогддог. Мэдээж хүү нь бага байдаг.

5.Төв банкны үнэт цаас. Манай Монголбанк болон бусад орны Төв банкуудаас нэг жил хүртэл хугацаатай гаргадаг үнэт цаасыг Төв банкны үнэт цаас гэдэг. Үүнийг гаргах үндсэн зорилго нь зах зээл дээр илүүдэлтэй байгаа мөнгөн хөрөнгийг татаж авах замаар мөнгөний хатуу бодлого явуулах, өөрөөр хэлбэл, мөнгөний нийлүүлэлтийг багасгах явдал юм. Төв банк гаргаж буй үнэт цаасныхаа хэмжээ, хүүг өсгөн банк хоорондын зах дээрх илүүдэл мөнгөн хөрөнгийг татаж авдаг. Үнэт цаасны арилжаанд зөвхөн банкууд оролцох эрхтэй тул банк хоорондын зах дээрх мөнгийг татаж авахад ашиглана. Эсрэгээр мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилго тавьсан тохиолдолд Төв банк үнэт цаасныхаа хүүг бууруулах, мөнгөний зах зээлд гаргасан үнэт цаасаа буцаан худалдан авч, хэмжээг багасгах арга хэмжээ авдаг.

Хавсралт 9. Хөрөнгө оруулалтын үндсэн шалгуурууд

Аюулгүй байдал, эрсдэл. Аюулгүй байдал, эрсдэл бол нэг зоосны хоёр тал юм. Хөрөнгө оруулалт хийхэд хэр найдвартай, аюулгүй байх вэ гэдэг нь эрсдлийн хэмжүүр болно. Аюулгүй байдал гэдэг нь хамгийн бага эрсдэл гэж ойлгож болно. Хамгийн эрсдэл багатай, аюулгүй хөрөнгө оруулалтад Засгийн газрын бонд, хадгаламж, зах зээлд найдвартай байр суурь эзэлсэн, санхүүгийн чадвар сайтай томоохон компаний гаргасан хувьцаа, бонд ордог. Нөгөө талаас, техник технологийн цоо шинэ салбарт үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан шинэ компаний хувьцаа өндөр эрсдэлтэй боловч ихээхэн ашиг өгч болно. Ямар түгээмэл эрсдлүүд байдаг, түүнээс хэрхэн сэргийлэх, эрсдлийг бууруулах аргуудын талаар тавдугаар бүлгээс уншаарай.

Хөрөнгө оруулалтын ашиг, өгөөж. Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цааснаас хэдий хэмжээний хүү, ашиг орлого олж болохыг тооцож түүнийг худалдан авдаг. Өмнө дурдсанчлан хамгийн аюулгүй, тооцоолсон хэмжээгээр найдвартай ашиг, өгөөж өгөх хөрөнгө оруулалт бол Засгийн газрын бонд юм. Та Засгийн газрын бонд худалдан авахдаа хэдэн хувийн хүүтэй вэ, сард, эсвэл жилд хүүгийн орлого хэдэн төгрөг болох вэ гэдгээ урьдчилж тооцох боломжтой. Дараа нь банкны хадгаламж орно. Компаний хувьцаа, бонд худалдан авах гэж байгаа бол эдгээрийг гаргаж байгаа компани хэр ашигтай ажилладаг, ирээдүйн ашиг нь ямар байх, ногдол ашиг тараах бодлого нь ямар байдаг талаар, мөн түүнчлэн тухайн компаний засаглал нь ямар байгааг зайлшгүй судлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын сонголт хийхээс өмнө Та ямар төрлийн хөрөнгө оруулалт хийвэл эрсдэл багатай, өгөөж өндөртэй байхыг юуны түрүүнд тооцох хэрэгтэй. Гэхдээ ийнхүү тооцох нь банкны хадгаламж, Засгийн газрын бондоос бусад тохиолдолд тусгайлсан мэдлэг боловсрол, туршлага шаардана.

Хөрөнгө оруулалтын өсөлт. Хөрөнгө оруулалтын өсөлт гэдэг нь тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ нэмэгдэхийг хэлнэ. Жишээ нь, Та 2009 оны 5 сарын 1-нд “Говь” компаний 100 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,050 төгрөгөөр авлаа гэж бодьё. Нэг сарын дараа 2009 оны 6 дугаар сарын 1-нд Хөрөнгийн Бирж дээр “Говь” компаний нэг хувьцааны үнэ 1,200 төгрөг болвол таны хөрөнгө оруулалт өсөлттэйд тооцогдоно.

Хөрвөх чадвар. Хөрвөх чадвар гэдэг нь тухайн хөрөнгө богино хугацаанд бэлэн мөнгө болж худалдагдах боломжийг илэрхийлдэг. Хөрөнгө оруулалт бүрийн хөрвөх чадвар өөр өөр байдаг. Хадгаламж, Засгийн газрын бонд, алт зэргийг хүссэн үедээ бэлэн мөнгө болгох боломжтой. Тиймээс эдгээр нь хөрвөх чадвар сайтайд тооцогддог. Ихэнх хөрөнгийн хувьд түүний төрөл, тухайн үеийн эдийн засгийн байдал, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал зэргээс хамаарч хөрвөх чадвар нь өөр өөр байж болно.

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын хэлбэрийн харьцуулалт

| Хөрөнгө оруулалтын хэлбэрүүд | Аюулгүй байдал | Эрсдэл | Ашиг Өгөөж | Хөрвөх чадвар |
|--------------------------------|----------------|--------|-------------|---------------|
| Банкны харилцах данс | Өндөр | Бага | Бага | Сайн |
| Энгийн хувьцаа | Дунд | Дунд | Дунд | Дунд |
| Давуу эрхтэй хувьцаа | Дунд | Дунд | Их | Дунд |
| Компаний бонд | Дунд | Дунд | Их | Дунд |
| Засгийн газрын бонд | Өндөр | Бага | Бага | Сайн |
| Үл хөдлөх хөрөнгө | Дунд | Дунд | Дунд | Muu |
| Деривативууд | Muu | Их | тодорхойгүй | Дунд |
| Түүхий эд | Muu | Их | тодорхойгүй | Дунд |
| Опцион | Muu | Их | тодорхойгүй | Дунд |
| Үнэт металл, чулуу, үнэт эдлэл | Muu | Их | тодорхойгүй | Muu |

Хүснэгт 1-д хөрөнгө оруулалтын янз бүрийн хэлбэрүүдийн учирч болох эрсдэл, өгөөж хөрвөх чадвар зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулан үзүүллээ. Хүснэгтээс харахад Засгийн газрын бонд хамгийн аюулгүй, найдвартай, эрсдэл багатай, хөрвөх чадвар сайтай боловч түүний өгөөж харьцангуй бага байгаа нь харагдаж байна. Харин компанийн бонд, давуу эрхтэй хувьцаа зэрэг нь дунд зэргийн эрсдэлтэй байж болох боловч илүү өгөөжтэй байдаг байна. Түүнчлэн төрөл бүрийн деривативуд, алт, үнэт металл, опцион зэрэг нь ихээхэн эрсдэлтэй учир өгөөж нь өндөр байж болно, эсвэл ихээхэн алдагдал хүлээх магадлалтай. Тиймээс өгөөжийг тэр бүр урьдчилан тооцоолох боломжгүй юм.

Эдгээр үзүүлэлтүүдийг харьцуулан үзэж, өөрийн хөрөнгө оруулалтын зорилгод нийцүүлэн хамгийн оновчтой хувилбарыг сонгож хөрөнгө оруулалт хийхийг зөвлөж байна.

Хавсралт 10. СЗХ-д хандах жишээ

Иргэн Бат өмч хувьчлалын үеэр Б компаний нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 70 ширхэг хувьцааг эзэмших болсон ажээ. Олон жилийн дараа тухайн компаний нэг хувьцааны үнэ 25,000 төгрөг болсныг биржийн мэдээнээс олж хараад брокерийн компани дээрээ очиж худалдах захиалгаа өгөх гэтэл олон жилийн өмнө 70 ширхэг хувьцаа нь худалдагдихсан байв.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хаана хандах вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Иймд иргэн Батад учирсан хохирлыг арилгах талаар харилцагч брокерийн компани зохих арга хэмжээ аваагүй бол тэрээр Санхүүгийн зохицуулах хороонд хандаж өргөдлөө гаргах боломжтой.

Санхүүгийн зохицуулах хороо нь Улаанбаатар, Бага тойруу-9, Засгийн газрын 4 дүгээр байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 263425 утсаар Хорооны олон нийттэй харилцах албатай холбогдож болно. Мөн Хорооны www.frc.mn вэб сайтын “Хэрэглэгчийн булан” руу орж “Санал хүсэлт илгээх” гэдгийг сонгож асуултаа илгээж, хариулт авч болно.

Санхүүгийн зохицуулах хороо нь Улсын Их Хурлаас байгуулагддаг бөгөөд банкнаас бусад санхүүгийн салбар (хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн үйлчилгээ, хадгаламж, зээлийн хоршоо)-ын хяналт зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Хороо нь дараах зорилгоор хөрөнгийн зах зээлийг зохицуулдаг:

- үнэт цаасны салбарт шударга, үр ашигтай, өрсөлдөөнтэй, ил тод, дэг журамтай байдлыг хэвшүүлэх, дэмжих;
- үнэт цаасны зах зээлийн талаархи иргэдийн боловсролыг дээшлүүлэх, үүнд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих;
- харилцагч хөрөнгө оруулалтын шийдвэрээ өөрөө хариуцах ерөнхий зарчмыг баримтлан харилцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих түвшинд хамгаалах;
- үнэт цаасны салбарт гэмт хэрэг, зөрчлийг бууруулах;
- үнэт цаасны салбарын системийн эрсдлийг бууруулах.

Хороо хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах бүрэн эрхтэй байна.

- Хөрөнгийн зах зээлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Эрх хэмжээнийхээ хүрээнд хэм хэмжээ тогтоож зах зээлийг зохицуулах
- Хяналт шалгалт хийх
- Шүүхийн өмнөх маргаан шийдвэрлэх Г.М.

Хороо иргэн Батын өргөдлийг хянаж, үнэхээр түүний хувьцааг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр худалдсан нь тогтоогдвол учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх, буруутэй этгээдэд хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авна.

Хавсралт 11. Орон сууцны зээл авах үе шат

Орон сууцны зээл авахын тулд:

- Худалдан авах гэж байгаа байрны үнийн тодорхой хувийг төлсөн байх шаардлагатай, үлдсэнийг банкнаас зээлнэ.
- Орон сууцны төлбөрт өөрөөс төлөгдж байгаа хэсгийг төлөхөөсөө өмнө банкинд хандана. Банкинд мэдэгдэхгүй төлбөрөө хийвэл төлбөр хийсэн эсэхэд эргэлзэх тул зээл олгохгүй байх магадлалтай.
- Урьдчилсан төлбөрөө хийсний дараа орон сууцаа худалдаж байгаа хүнтэйгээ хамт банкин дээр ирээд тэр хүний байрыг авах гэж байгаа тухайгаа өргөдөл гаргана.
- Өргөдөл дээр заасан байрны үнэ бодитой эсэхэд банк судалгаа хийгээд зээл олгох талаар шийдвэр гаргана.
- Зээл олгохоор болвол худалдах гэж байгаа байрны талаар Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газраас лавлагана авна.
- Худалдагч байр өмчлөх эрхийн гэрчилгээгээ худалдан авч байгаа хүний нэр дээр болгон шилжүүлнэ.
- Орон сууц худалдаж байгаа тал нь (үл хөдлөх хөрөнгийн) татвар төлсөн баримтаяа банкинд авчирч үзүүлнэ.
- Банк орон сууцны зээлд олгож байгаа мөнгийг орон сууцаа худалдаж байгаа хүний дансанд шилжүүлнэ.

Хөрөнгийг эргэлтэд оруулж байж капитал болно, өөрөөр хэлбэл, өгөөж өгнө.

Жишээ. Америкчууд орон сууцаа зээлээр аваад, олон жилийн турш сар бүр тодорхой төлбөр төлж дуусгаад дараа нь орон сууцаа барьцаалан бизнесийн зээл авч нэмэлт хөрөнгийнхөө шаардлагыг хангаж капитал /орон сууц/-аа байнга эргэлтэнд байлгадаг байна.

Хавсралт 12. ХЗХ: Зээл хүссэн өргөдлийг шийдвэрлэх

Хэрвээ Та хадгаламж зээлийн хоршооны гишүүн бол хоршооноосоо зээл авч болно. ХЗХ гишүүдийнхээ зээл хүссэн өргөдлийг дараах байдлаар хянадаг. Үүнд:

- Зээл хүссэн өргөдлийг “Зээлийн журам”-ын дагуу бичсэн эсэх;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Хоршооны гишүүний дэвтэр;
- Зээлийн барьцаа хөрөнгийг тухайн этгээд эзэмшдэг эсэхийг нотлох гэрчилгээ түүний хуулбар;
- Хэрвээ тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагаанд зээл авахыг хүсч байгаа бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, лиценз;
- Оршин байгаа хаягийн тодорхойлолт;
- Зээлийг зарцуулах үйл ажиллагааны тооцоололт;
- Аж ахуйн нэгж бол сүүлийн жилүүдийн санхүүгийн тайлан тэнцэл.

Мөн дор дурдсан асуудлуудаар ярилцлага хийдэг. Үүнд:

- Эрхэлж буй үйл ажиллагааных нь төрөл, чиглэл, түүх;
- Хамтран ажиллагсад болон хувь нийлүүлэгчид;
- Үйл ажиллагааных нь орлого, зарлагын байдал;
- Борлуулалтын хэлбэлзэл;
- Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчид;
- Тухайн зах зээлийн өрсөлдөөн, цаашдын зорилго;
- Зээл авах болсон шалтгаан, зориулалт;
- Зээл авснаар үйл ажиллагаа нь хэрхэн өргөжих;
- Ашиг олохоор тооцоолж буй төлөвлөгөөний хэрэгжих боломж;

- Өрхийн орлого, зарлагын тооцоо;
- Зээл авахыг гэр булийн гишүүд дэмжиж буй эсэх;
- Зээлийн барьцаанд тавих хөрөнгө нь зээлдэгчийн өмчлөл мөн болох, хөрөнгийн үнэлгээ зөв хийгдсэн эсэх гэх зэрэг.

Энэ нь нэг талаас Та зээл аваад үйл ажиллагаа явуулахад учирч болох эрсдлээс, нөгөө талаас зээл эргэн төлөгдөхгүй байж болох эрсдлийг бууруулахад чиглэдэг. ХЗХ-ны зээлийн үйлчилгээ нь бүх гишүүдийн хурлаар баталсан “Зээлийн журам”-ын дагуу явагдана.

Журамд зээлийн төрөл, зээл олголт, зээлд тавих хяналт, зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой зохицуулалтын асуудлуудыг тусгасан байна. Тухайлбал, Зээлийн үйлчилгээнд мөрдөх хууль, журмын нэр, зээлийн төрөл, хугацаа, хүү, зээл олгох, төлүүлэх үйл явц, хяналт, зээл, барьцаа хөрөнгийн гэрээнд тусгах заалтууд гэх зэрэг.

Хавсралт 13. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа

Банк бус санхүүгийн байгууллага гэж жижиг, дунд бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн хэрэгцээг хангах үүднээс дараах нэр төрлийн санхүүгийн үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлдэг хуулийн этгээд юм. ББСБ нь СЗХ-ноос холбогдох тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах үйлчилгээг үзүүлэх боломжтой.

Үүнд,

1. **Зээлийн үйлчилгээ:** мөнгөн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд тодорхой зориулалтын дагуу хүү, хугацаа, барьцаа эсхүл батлан даалтын үндсэн дээр эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлдүүлэх
2. **Факторингийн үйлчилгээ:** төлбөр тооцооны баримтыг үндэслэн авлагыг нь хямдруулан худалдан авах буюу нотлогдсон авлагаар нь барьцаалан зээл олгох
3. **Төлбөрийн баталгаа:** ББСБ-ын харилцагч нь бусдын өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргээ гүйцэтгээгүй нөхцөлд түүнийг ББСБ харилцагчийнхаа нэрийн өмнөөс хийж гүйцэтгэнэ гэж баталгаа гаргах
4. **Төлбөр тооцооны хэрэгсэл:** вексель, баталгаажсан нэрийн чек, цахим карт зэрэг төлбөр тооцоонд ашиглаж болох санхүүгийн хэрэгслийг гаргах

5. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулга: ББСБ-аас харилцагчийн мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог гүйцэтгэх
6. Гадаад валютын арилжаа: гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах
7. Итгэлцлийн үйлчилгээ: тухайн ББСБ-д итгэсэн харилцагчийнхаа хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалан ашиг олж өгөх зорилгоор тохиролцсон хугацаанд ашиглах, захиран зарцуулах
8. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт: тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийг нэг жил хүртэл хугацааны үнэт цаас болон түүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэл худалдан авахад зарцуулах
9. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө: иргэд, хуулийн этгээдэд тэдний хүсэлтийн дагуу хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээлэл өгөх
10. Санхүүгийн түрээс/лизинг: харилцагчийн захиалсан буюу сонгосон эд хөрөнгийн үнийг төлөөд өөрийн нэр дээр худалдан авч, цаашид харилцагчдаа тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэйгөөр түрээслэх үйл ажиллагааг тус тус хэлнэ.

Хавсралт 14. Интернетээр арилжаанд оролцох нь

Бид мэдээллийн технологийн эрин үед амьдарч байна. Монголын насанд хүрсэн хүн амын гуравны нэг нь хөдөлгөөнт холбооны хэрэгсэл болох гар утас хэрэглэж, нийт айл өрхийн багагүй хувь нь гэрийн болон зөөврийн компьютер ашиглаж, интернет хэрэглэгчдийн тоо жилээс жилд хурдтай өсч байна. Интернетэд холбогдоход заавал утас кабелийн хэрэгцээгүй болж байна. Ингэснээр зөвхөн хот суурин газарт төдийгүй, аймаг, сум, малын бэлчээрт ч интернетээр үйлчилгээ авах боломжтой боллоо.

Дэлхийн олон сая хэрэглэгчид банк санхүү, хөрөнгийн зах зээлийн төрөл бүрийн үйлчилгээг интернетээр дамжуулан авч гэрээсээ, ажлын байрнаасаа, аян замд яваа үедээ арилжаа наймаа, төлбөр тооцоогоо хийж байна.

Сүүлийн үед манай залуучууд валютын арилжаа /Forex/, түүнчлэн NASDAQ, NYSE, LSE гэх мэт дэлхийн томоохон бирж дээрх үнэт цаасны

арилжаанд шууд оролцож байна. Энэ бол олон жилийн туршлагатай, нарийн мэргэжлийн хүний хийдэг ажил, тэгээд ч компьютер дээр ажиллаж үзээгүй, эсхүл муухан ажилладаг хүмүүст хүртээмжгүй, мөрөөдөл төдий зүйл гэж олон хүн боддог. Гэтэл энэ нь тийм ч боломжгүй зүйл биш ажээ. Нарийн төвөгтэй асуудлууд байгаа. Гэсэн хэдий ч үндсэн арга, аргачлал нь энгийн зүй тогтолтой. Түүнийг судалж мэдэх л хэрэгтэй.

Зах зээлд шилжсэн 1990-ээд оны үед бараг хүн бүр гахай чирээд хойш, урагш явж наймаа хийхдээ хямд үнээр авч ахиухан үнээр зарж ашиг олдог, хэдийд юу авч, хэдийд юугаа зарвал ашигтай байдгийг бараг хэнээр ч заалгалгүй ойлгосон. Олон хүн "шатах, хожих", "унах, босох"-ын бүхэл бүтэн түүхийг туулж, манай өнөөдрийн үндэсний хөрөнгө оруулагчид, том бизнес эрхлэгчид төрсөн.

Интернетээр дэлхийн том, том бирж дээр болж байгаа үнэт цаасны арилжаанд шууд оролцож наймаа хийхэд нөгөө л хямд үнээр авч ахиухан үнээр зарж ашиг олдог, хэдийд юу авч, хэдийд юугаа зарвал ашигтай байдгийг мэдсэн байх суурь зарчим л үйлчилнэ. Тэр байтугай үнэт цаасны ханш цаашид унана гэсэн магадлал дэвшүүлж байгаа бол уг үнэт цаасаа брокероосоо зээлээр аваад унасан хойно нь хямдханаар худалдан авч зээлсэн хувьцаагаа буцаан төлж өөртөө ашиг олох боломжтой. Бирж дээр ямар хувьцааг, ямар үнээр, хэдэн ширхэгийг авах гэж байгаа, зarah гэж байгааг ил тод харж, өөрийн шийдвэрийг гаргах боломжтой байдгаараа илүү шударга, ил тод систем байдаг. Мөн эхлэн суралцагчдад зориулсан сургалтын програм болох "демо" ашиглаж бэлтгэл хийх боломжтой байдаг.Интернетийн ийм үйлчилгээ үзүүлдэг гадаадын интернет компаниуд олон байдаг. Манай хэсэг залуучууд мөн электрон бирж байгуулах талаар судалгаа хийж байгаа мэдээ бий.

Арилжаанд оролцогчдын сэтгэл зүй, үйлдлийг олон жилийн турш судалж, зүй тогтлыг нь тодорхойлсон байдаг. Тэр зүй тогтол, үндсэн зарчмуудыг таньж мэдсэн байх шаардлагатай. Жишээ нь, арилжаанд оролцоход:

- Шунахай байж болохгүй
- Аймхай байж болохгүй
- Төлөвлөгөөгүй байж болохгүй
- Орлогоосоо ямар хэмжээний хөрөнгийг үүнд зориулах вэ гэдгээ эрсдлээ тооцож шийдсэн байх хэрэгтэй гэх мэт чухал зөвлөмжүүд байдаг. АНУ-д тэтгэврийн насны хүмүүсийн мөнгөө арвижуулах,

цагаа зугаатай өнгөрөөх нэг түгээмэл хэлбэр нь интернет арилжаа болсон тухай олон хүн ярьдаг. Мэдээллийн эрин үед энэ боломж манайд ч бий.

Хавсралт 15. Компаний засаглалын тухай

2007 оны оны эцсээр “Монголын компаний засаглал кодекс”-ийг Санхүүгийн зохицуулах хороо батлан гаргасан билээ. Энэ кодекст нийцүүлэн хувьцаат компаниуд компаний засаглалын өөрийн дотоод журмыг батлан мөрдөх ёстой.

Эдгээр журмуудаас хувьцаа эзэмшигч бүрт хамаатай хоёр журмыг товч тайлбарлай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журамд юу тусгагдах ёстой вэ?

- хувьцаа эзэмшигчдийн хурлаар заавал хэлэлцэх асуудлууд;
- жил бүрийн ээлжит хурлын өмнө хувьцаа эзэмшигчдэд ямар мэдээлэл, тайланг заавал хүргүүлэх, хурлын материал болон зарыг хувьцаа эзэмшигчдэд хэдийд, хэрхэн хүргэх;
- хурлаар хэлэлцэх асуудлаар эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс саналыг нь яаж авах;
- хурлыг хэдийд, хэрхэн олон нийтэд зарлах;
- хувьцаа эзэмшигч хуралд биеэр оролцож чадахгүй бол саналын хуудсаар саналаа хэрхэн өгөх, өөр этгээд төлөөлөн оролцох бол яаж оролцох;
- хурлын явцад хувьцаа эзэмшигч асуулт тавих, хариулт авах эрхийг яаж хэрэгжүүлэх;
- ТУЗ-ийн бүх гишүүд, гүйцэтгэх захирал болон бусад албан тушаалтнууд, аудиторууд, компаний хянан шалгах зөвлөлийн гишүүд хуралд заавал оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах үүрэгтэй байх, оролцоогүй бол ТУЗ-ийн дарга шалтгааныг хуралд оролцогчдод тайлагнадаг байх;
- хурлыг компаний төв байранд юмуу, эсвэл хувьцаа эзэмшигчдийн олонхи нь оршин суудаг газар хуралдуулдаг байх;
- хурлын цаг, байрыг аль болох олон хувьцаа эзэмшигч оролцох боломжийг хангахуйцаар товлосон байх зэрэг асуудлыг тусгах ёстой.

Ногдол ашгийн бодлогод юу тусгах вэ?

Та аль нэг компаний хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөсөн нь мэдээж. Ийм учраас компаний ашиг хуваарилалтын бодлого, цэвэр ашгийнхаа доод тал нь хэдэн хувийг ногдол ашигт хуваарилахаар дүрэмдээ заасан, ашиг хуваарилах хэлбэр зэргийн талаар тодорхой мэдээлэл авахыг хүснэ.

“Ногдол ашгийн бодлого”-д эдгээр асуудал бүрэн тусгагдсан байх ёстой. Хуваарилж байгаа ногдол ашгийн хэмжээ нь компаний бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур байж болохгүй. Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэлийг нь хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнах ёстой.

Компаний засаглалыг үнэлэх нь. Та чухам ямар компаний үнэт цаасыг худалдан авах вэ, нэгэнт авсан үнэт цаасаа зарах уу, нэмж авах уу гэдэг шийдвэр гаргахдаа тухайн компаний засаглалын байдлыг хялбархан олддог мэдээлэлд тулгуурлан үнэлж чаддаг байх нь чухал. Энэ тийм ч хэцүү асуудал биш.

Хувьцаа эзэмшигчдийн хурал. Юуны өмнө хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа жил бүр хуралдуулж, тайлан, төлөвлөгөөгөө танилцуулдаг уу гэдгийг анхаар. Жил бүрийн ээлжит хурлаа ч хийдэггүй, эсхүл алдаг оног хийдэг, ёс төдий тайлан тавьдаг компаний тухайд сайн засаглалын талаар яриад ч хэрэггүй.

Ногдол ашиг. Дараа нь ногдол ашиг хуваарилдаг эсэх, хуваарилдаг бол хир олон удаа хуваарилсан, ногдол ашгийн хэмжээ нь өсөн нэмэгдэж байгаа эсэхийг анхаараарай. Өсөн хөгжиж байгаа шинэ залуу компаний хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх зэрэгт их хэмжээний санхүүжилт шаардлагатай болдог. Үүнд зориулан банкны зээл авна гэхээр өндөр хүүтэй учраас алдагдалд орох магадлалтай байдаг. Иймээс ашгаа хуваарилалгүй компанидаа үлдээж, санхүүжилт хийдэг гэдгийг анхаараарай. Монголын компаниуд бүгд л дээд тал нь 20 орчим жилийн түүхтэй залуу компаниуд байгаа. Тэгэхлээр ногдол ашиг хуваарилахгүй байгаа нь хэтдээ өндөр ашиг олох боломжоо нэмэгдүүлэхэд чиглэж байгаа байж болох юм шүү. Харин энэ тухайгаа хувьцаа эзэмшигчиддээ мэдээлдэг байх ёстой.

Ил тод нээлттэй байдал. Компаний үйл ажиллагаа хэр зэрэг ил тод байна вэ гэдэгт анхаарлаа хандуул. Өөрөөр хэлбэл, Та компаний талаарх мэдээллийг олж авч чадаж байна уу үгүй юу, авч байгаа

мэдээлэл чинь сайн засаглалын зарчимд нийцсэн бүрэн дүүрэн мэдээлэл байна уу үгүй юу гэдгийг анхаарна.

Хэрвээ дээрх гурван асуудлаар “хангалттай” гэсэн үнэлгээ өгсөн бол дараагийн шатанд шилжиж, нилээд нарийн үнэлгээ өгөх шаардлагатай. Тухайлбал, үүний өмнө ярилцсан компанийн засаглалын дотоод журмууд байна уу үгүй юу, байгаа бол түүнд дээр ярьсан асуудлууд бүрэн тусгагдсан эсэх, журмаа хэрхэн мөрдөж байгаа талаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнасан эсэхийг мэдээд аваарай. Тийм дотоод журмуудтай бөгөөд уг журмаа мөрдөж ажилладаг гэж дүгнэж болохоор бол муугүй засаглалтай гэж үзэж болох юм.

Та хэрэв идэвхитэй хувьцаа эзэмшигч бол...

Компанийн засаглалыг дүгнэхийн тулд хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцох нь тун ч ач холбогдолтой. Та хувьцаа эзэмшигч бол хуралд орох эрхтэй, харин хувьцаа эзэмшдэггүй боловч аль нэг компанийг сонирхож байгаа бол цөөхөн хувьцаа худалдаж аваад хуралд оролцож болно шүү дээ.

Та идэвхитэй хувьцаа эзэмшигч бол компанийхаа засаглалыг сайжруулахад хувь нэмрээ оруулж чадна. “Компаний тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-д өргөн бариад байгаа. Энэ хуулинд компанийн засаглалыг сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр олон заалтууд орсон. Тухайлбал, ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс цөөнгүй нь хараат бус гишүүн байх ёстой гэж заасан. Энэхүү хараат бус гишүүдийг болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгоход хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааны тооноос үл хамааран нэг санал өгөх замаар сонгоно гэж хуульчлахаар тусгасан байгаа.

Тэгэхлээр Та өөрийгөө эсхүл Таны эрх ашгийг хамгаалж чадах мэдлэг боловсролтой, шударга сайн хүнийг ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэн сонгох /гэхдээ Та ганцаараа бол юунд ч хүрч чадахгүй шүү!/ замаар ТУЗ-ийн гишүүнээр дамжуулан компанийн сайн засаглалын практикийг хэвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж чадна. Харин нэр дэвшүүлэх хугацаа нь жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор байх ёстой гэдгийг анхаараарай.

ТУЗ-ийн хараат бус гишүүн. Компаний хяналтын багц хувьцааг эзэмшдэг этгээд болон гүйцэтгэх удирдлагаас хараат бус, жижиг хувьцаа эзэмшигчид болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй ТУЗ-ийн гишүүн мөн.

Компаний засаглал нь таны олох ашигт яаж нөлөөлөх вэ? Сайн засаглалтай компани нь зээлдүүлэгчид болон бизнесийн түншийнхээ итгэлийг хүлээдэг учраас санхүүгийн нэмэлт эх үүсвэр хэрэгтэй болсон үед хялбархан олж чаддаг. Өөрөөр хэлбэл, банкнаас зээл авахад олдоцтой, найдвартай учраас бусдаас арай бага хүйтэй авах боломжтой байгаа. Мөн түүнчлэн бизнесийн түнш нь төлбөрөө дараа авахаар бараа, түүхий эдээ зээлээр нийлүүлдэг байх нь ч бий.

Бараа, үйлчилгээгээ хялбар борлуулж чаддаг, худалдан авагч үйчлүүлэгч олонтой байдаг нь сайн засаглалтай компаний давуутал. Ингэхээр сайн засаглалтай компаний хувьд санхүүгийн болон борлуулалтын хүндрэл аль аль нь бусдаас хавьгүй бага байдаг. Ийм болохоор ашиг орлого сайтай байх нь мэдээж. Ашиг өндөр бол ногдол ашиг сайн хуваарилна.

Сайн засаглалтай компаний хувьцаа, бонд нь эрэлт ихтэй байдаг. Эрэлт ихтэй бол Та хүссэн үедээ хувьцаагаа худалдах боломжтой байхаас гадна үнэ нь ч өсөж байдаг. Аливаа эд хөрөнгийн үнэ нь эрэлт нийлүүлэлтээс шалтгаалдагийг Та сайн мэдэж байгаа. Сайн хувьцааг зарах хүн цөөн, авах сонирхолтой хүн олон байх учраас үнэ нь өндөр л байна.

Ийм учраас ногдол ашгийн хэлбэрээр юмуу, авсан зарсан хоёр үнийн зөрүүгээр ашиг олох боломжтой.

Сайн засаглалтай компаний үнэт цаас Танд илүү өндөр ашиг авчирна.

Таны авсан хувьцааг нь эзэмшиж байгаа компани муу засаглалтай бол яах вэ?

Зах зээлийн ханш харж байгаад зарах л хэрэгтэй гэж зөвлөх байна. Гэхдээ компаний засаглалын талаар Таны хийсэн дүгнэлт зөв гэдэгтээ итгэлтэй байх хэрэгтэй. Мэдлэг, мэдээлэл дутмагаас сайн, муу засаглалтай алин болохыг нь мэдэхгүй байгаа бол Та гэрээ байгуулсан брокерийн компанидаа найдаж болох юм. Үгүй ядахдаа хувьцааны чинь үнэ ханш өсөж байгаа, буурч байгаа алин болохыг судлаарай.

Мэдээлэл авах нь чухал. Та өөрийн хувьцаа эзэмшдэг компанийхаа веб сайтын хаягийг заавал мэдэж аваарай. Ер нь үнэт цаасны арилжаа явуулдаг байгууллагад /манайд одоохондоо ганцхан Монголын хөрөнгийн бирж л байгаа/ бүртгэлтэй, тэнд хувьцаа, бонд нь арилжигддаг бүх компаний веб сайт, Хөрөнгийн биржийн веб

сайтад орж үзээд байвал, ямар үнэт цаас авах вэ, ямар үнэт цаасаа зарах вэ, хэдийд ямар үнээр авах, зарах вэ гэдэг шийдвэр гаргахад тань ихээхэн нэмэртэй.

Мөн Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Танд үйлчилдэг брокерийн компаний веб сайтын хаягийг мэдэж байх шаардлагатай. Эдгээр байгууллагын хаяг, веб сайтыг хавсралтаас үзнэ үү. Түүнчлэн 2009 оны дундуур Компайин засаглалын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, компаний удирдлага, их, дээд сургуулийн багш оюутан, төрийн байгууллагын ажилтнуудыг компаний засаглалын янз бүрийн түвшний, төрөл бүрийн сургалтанд хамруулж, монголын компаниудын засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Монголын компаний засаглалын хөгжлийн төв үүсгэн байгуулагдсан. Энэ төвийн сургалт болон бусад үйл ажиллагааны талаар www.cgdc.org.mn хаягаар орж үзэж болно.

Хавсралт 16. Салбарын хуулийн холбогдох заалтууд

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

2005 оны 11 сарын 17 өдөр Төрийн ордон. Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь Санхүүгийн зохицуулах хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

- 3.1. Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараахь үйл ажиллагаа хамаарна:
 - 3.1.1. банк бус санхүүгийн байгууллагын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа;
 - 3.1.2. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;
 - 3.1.3. даатгагчийн Даатгалын тухай хуульд заасан үйл ажиллагаа;
 - 3.1.4. даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;
 - 3.1.5. хоршооны Хоршооны тухай хуульд заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаа;
 - 3.1.6. хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагаа.
- 3.2. Банкны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг банкны тухай хууль тогтоомжоор зохицуулна.

4 дугээр зүйл. Санхүүгийн зохицуулах хороо

- 4.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

6 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

- 6.1. Хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 6.1.1. санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;
 - 6.1.2. бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох;
 - 6.1.3. санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл / цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 6.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг шалгах;
 - 6.1.5. тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;
 - 6.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх;
 - 6.1.7. Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих.
 - 6.1.8. даатгалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, түүнд тавих шаардлагыг тогтоох. /Энэ заалтыг 2009 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн/
- 6.2. Хороо энэ хуулийн 6.1-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна үйл ажиллагааныхаа чиглэл тус бүрээр дараахь хуулиудад заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 6.2.1. банк бус санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан;
- 6.2.2. үнэт цаасны зах зээлд оролцогчийн үйл ажиллагааны чиглэлээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан;
- 6.2.3. даатгалын үйл ажиллагааны чиглэлээр Даатгалын тухай хуульд заасан;
- 6.2.4. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны чиглэлээр Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан;
- 6.2.5. хадгаламж, зээлийн үйл ажиллагааны чиглэлээр Хоршооны тухай хуульд заасан.

11 дүгээр зүйл. Хорооны дарга, гишүүн, түүнийг томилох

- 11.1. Хороо нь дарга, б гишүүнээс бүрдэнэ.
- 11.2. Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас томилно.
- 11.3. Хорооны дарга болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооноос нэр дэвшүүлсэн тус бүр 1 гишүүн орон тооны, бусад дөрвөн гишүүн нь орон тооны бус байна.

12 дугаар зүйл. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа

- 12.1. Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

- 22.1. Энэ хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах, худалдах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаархи мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

4 дүгээр зүйл. Үнэт цаас гаргагч

- 4.1. Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд Компаний тухай хууль болон энэ хуулийн дагуу үнэт цаас гаргаж болно.
- 4.2. Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрлөөр, аймаг, нийслэлийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр нийтэд санал болгон үнэт цаас гаргаж болно.
Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргасан үнэт цаас нь бусад үнэт цаасны нэгэн адил Хороо болон Хөрөнгийн биржид бүртгэлтэй байна.
- 4.3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргах үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахад энэ хуулийн 5-9 дүгээр зүйл хамаarahгүй.

13 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад үнэт цаасны зах зээл дээр тавигдах хязгаарлалт

- 13.1. Хөрөнгө оруулагчийн өмчлөлд байгаа үнэт цаасны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг мэдээлэх, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгохыг хориглоно.

- 13.2. Энэ хуулийн 13.1-д заасныг үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулдаг этгээд зөрчсөн нь уг этгээдийн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

14 дүгээр зүйл. Хөрөнгө оруулагчид үнэт цаасны гүйлгээтэй холбогдох мэдээлэл хүргэх

- 14.1. Үнэт цаас гаргагч холбогдох хууль тогтоомжид заасан мэдээллийг нийтэд хүргэх, хөрөнгө оруулагчид өгөх үүрэгтэй.
- 14.2. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага хөрөнгө оруулагчийн шаардсанаар дараах баримт бичиг болон мэдээллийг өгөх үүрэгтэй:
- 14.2.1. үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээтэй холбогдсон баримт бичиг;
- 14.2.2. мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн өөрийн хөрөнгийн болон өр, зээл, санхүүгийн байдлын талаархи мэдээлэл;
- 14.2.3. ажилтан нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн тухай мэдээлэл;
- 14.2.4. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан сүүлийн зургаан сарын үнэт цаасны арилжааны үнэ, ханш болон арилжааны тухай мэдээ.
- 14.3. Энэ хуулийн 14.2-т заасныг зөрчиж, хөрөнгө оруулагчид буруу мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх нь хөрөнгө оруулагч болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн хооронд байгуулсан гэрээг хуульд заасан журмын дагуу өөрчлөх, цуцлах үндэслэл болно.
- 14.4. Хөрөнгө оруулагч нь үнэт цаасыг худалдан авах, худалдах явцад хууль тогтоомжид заасан мэдээллийг үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс шаардах эрхтэй.

15 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаархи Хорооны шийдвэр

- 15.1. Хорооноос хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэрийг үнэт цаасны зах зээлд оролцогч бүх этгээд биелүүлэх үүрэгтэй.

- 15.2. Хорооны шийдвэрийг биелүүлээгүй үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үүрэг биелүүлэх тухай мэдэгдэл өгөх, энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

34 дүгээр зүйл. Хорооны эрх хэмжээ

- 34.1. Хороо дараахь эрх хэмжээтэй байна:

- 34.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
- 34.1.2. үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;
- 34.1.3. эрх хэмжээнийхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;
- 34.1.4. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 34.1.5. үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 34.1.6. хөрөнгө оруулагчийн эрх ашигт хохиролтой гэж үзсэн нөхцөлд үнэт цаасны арилжааг түр зогсоох;
- 34.1.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх, бүртгэлгүй үнэт цаасны арилжааг зогсоох, хориглох;
- 34.1.8. хувьцаат компаний хувьцааны хяналтын багц буюу түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээд худалдан авахаар гаргасан тендер саналыг энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрөх, бүртгэх, хянах;
- 34.1.9. үнэт цаас гаргагч, үнэт цаас эзэмшигч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журамд заасан мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа эсэхэд хяналт тавих;

- 34.1.10. үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлан, мэдээ, түүний тайлбар тодруулгад зайлшгүй тусгагдах үзүүлэлт, тайлан, мэдээний маягт хэрэглэх талаар журам тогтоож мөрдүүлэх;
- 34.1.11. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах үүднээс зөрчилтэй гэж үзсэн буюу арилжаанд оролцогч аль нэг талын хүсэлтийг үндэстэй гэж үзвэл тухайн үнэт цаасны арилжааг түр зогсоон шалгах, зөрчилтэй нь нотлогдвол түүний арилжааны хэлцлийг хүчингүй болгох;
- 34.1.12. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох, энэ тухайгаа нийтэд мэдээлэх;
- 34.1.13. үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, бусад баримтыг аудитын болон үнэлгээний байгууллагаар шалгуулан баталгаажуулахыг шаардах;
- 34.1.14. Хорооны гишүүн, ажлын албаны болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, тэдэнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа үнэт цаасны талаар мэдээлэл гаргуулах;
- 34.1.15. үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх олгох, хүчингүй болгох;
- 34.1.16. олон нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, тогтоосон журмын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид мэргэжлийн зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Компаний ТУХАЙ

1999 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, компаний удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг тогтоох болон компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

9 дүгээр зүйл. Компаний болон хувь нийлүүлэгчдийн хариуцлага

- 9.1. Компаний эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 9.2. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- 9.3. Хувьцаа эзэмшигч нь компаний хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 9.4. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компаний хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон бусад хэлбэрээр компаний үйл ажиллагааг тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанийд учирсан эд хөрөнгийн хохирлыг уг этгээд өөрийн хөрөнгөөр компаний өмнө хариуцна.
- 9.5. Хувь нийлүүлэгчийн компанийд оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувь нийлүүлэгч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компаний өр төлбөрийг давхар хариуцна.

35 дугаар зүйл. Компаний энгийн хувьцаа эзэмшигчдийн эрх

- 35.1. Компаний энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
 - 35.1.1. хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 35.1.2. давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсөний дараагаар компаний төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
 - 35.1.3. компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
 - 35.1.4. хувьцаат компаний энгийн хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 39 дүгээр зүйл болон компаний дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
 - 35.1.5. компаний дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компаний энгийн хувьцаа эзэмшигчид нь хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг энэ зүйлд заасан бусад журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдэлнэ.
- 35.2. Компаний дүрмээр хувьцаа эзэмшигчийн эзэмшиж болох энгийн хувьцааны тоог хязгаарлаж болохгүй.
- 35.3. Энгийн хувьцааг компаний давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно.
- 35.4. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлаж болно. /Энэ хэсгийн “хязгаарлагдмал хариуцлагатай компаний дүрмээр” гэсэн заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2002 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

*36 дугаар зүйл. Компаний давуу эрхийн хувьцаа
эзэмшигчдийн эрх*

- 36.1. Бүх төрлийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:
 - 36.1.1. эрх бүхий байгууллагаас тогтоосон давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжинд авах;
 - 36.1.2. энэ хууль, компаний дүрэм болон тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан асуудлаар хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох;
 - 36.1.3. компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсан орлогоос хуримтлагдсан ногдол ашиг болон эзэмшиж байгаа хувьцааны татан буулгалтын үнийг авах.
- 36.2. Компаний дүрэм, эсхүл тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт дор дурдсан зүйлийг тусгана:
 - 36.2.1. татан буулгах үед түүнд төлөх төлбөр, төлөх журам, дэс дараалал;
 - 36.2.2. увь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, давуу эрхийн нэг хувьцаанд ногдох саналын тоо;
 - 36.2.3. давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх бол түүний нөхцөл;
 - 36.2.4. давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшилд байгаа давуу эрхийн хувьцаагаа компанийд эргүүлэн авахыг шаардах нөхцөл.
- 36.3. Компани нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн болон эргүүлэн авах үүрэг бүхий давуу эрхийн хувьцааг авсаны дараа энгийн хувьцааг эргүүлэн авах буюу худалдан авах, түүнд ногдол ашиг төлөх эрхтэй болно.
- 36.4. Энэ хуулийн 48.3.-т заасан нөхцөл үүсээгүй бол компани нь давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашгийг дүрэмд заасан хэмжээ болон хугацаанд төлнө.
- 36.5. Компанийг татан буулгах тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох хөрөнгийг олгохоос өмнө дарааллын дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд уг хувьцааны татан буулгалтын үнэ, төлөгдөөгүй ногдол ашгийг төлнө.
- 36.6. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид нь хувь нийлүүлэгчдийн

хуралд дараахь тохиолдолд саналын эрхтэй оролцоно:

- 36.6.1. компаний дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахдаа тэдгээрийн эрхийг хязгаарласан заалтыг оруулж байвал;
- 36.6.2. компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаа, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөрөнгөнд хөрвүүлж байвал.
- 36.7. Энэ хуулийн 36.6.-д заасны дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн хурлын уг асуудлаарх шийдвэрийг компаний дүрэмд дээгүүр тогтоогоогүй бол зөвхөн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана.
- 36.8. Хувьцаат компаний төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийг дараахь нөхцөлд саналын эрхтэй оролцуулахаар компаний дүрэмд зааж болно:
 - 36.8.1. компаний дүрэмд энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөгчийг оруулж болохоор заасан бол;
 - 36.8.2. давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол.

47 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах

- 47.1. Компаний дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / гаргана. Энэ байгууллага нь ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.
- 47.2. Ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлохдоо хязгаарлагдмал хариуцлагатай компаний хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан өдрөөр тасалбар болгон тодорхойлно.Харин хувьцаат компаний хувьд энэ бүртгэлийн өдрийг шийдвэр гарсан өдрөөс хойш тусгайллан тогтоох бөгөөд энэ тухай нийт хувь нийлүүлэгчдэд яаралтай зарлан мэдэгдэнэ.
- 47.3. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

- 47.4. Компаний дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компаний болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 47.5. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.
- 47.6. Хэрэв компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаандаа ногдол ашгаа төлөх үүрэгтэй. Ногдол ашгаа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр компани нь алданги төлөх бөгөөд үүнээс компанийд учирсан хохирлыг компаний гүйцэтгэх удирдлага хариуцна.

48 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- 48.1. Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:
 - 48.1.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
 - 48.1.2. ногдол ашиг төлсний дараа компаний өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
 - 48.1.3. компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 48.2. Компани эргүүлэн авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.
- 48.3. Компани нь дор дурдсан тохиолдолд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:
 - 48.3.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
 - 48.3.2. компани нь эргүүлэн авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх.
- 48.4. Ногдол ашиг төлсний дараа компаний өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор

өөрийн зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

- 48.5. Компани ногдол ашиг хуваарилаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд шалтгааныг тайлагнах үүрэг хүлээнэ.

49 дүгээр зүйл. Компаний эд хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хязгаарлалт

- 49.1. Зээлдүүлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор компаний өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан хэмжээнээс бага болох, эсхүл компани төлбөрийн чадваргүй болохоор байвал компаний эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бусдад зах зээлийн үнээс доогуур үнээр худалдахыг хориглоно.
- 49.2. Энэ хуулийн 49.1.-г зөрчиж хийсэн хэлцэл шүүхийн шийдвэрээр хүчингүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХОРШООНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1. Энэ хуулийн зорилт нь хоршооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршооны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа

48¹ дугаар зүйл. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа

- 48¹.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо 20-иос доошгүй гишүүнтэй байна.
- 48¹.2. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь дараахь асуудлыг дүрэмдээ тусгана:
 - 48¹.2.1. хадгаламж авах, зээл олгох журам;
 - 48¹.2.2. хоршоо болон гишүүдийн харилцан хүлээх эрх, үүрэг;
 - 48¹.2.3. хоршооны зээлийн сан, зээлийн эрсдлийн сан болон бусад санг байгуулах, зарцуулах журам;
 - 48¹.2.4. зээлийн хороо болон хоршооны бүтэц дэх бусад байгууллагаас хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд оролцох журам.
- 48¹.3. Хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

48¹.4. Энэ хуулийн 481.3 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна. /Энэ хэсгийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

48² дугаар зүйл. Хоршооны хадгаламжийн үйл ажиллагаа

48².1. Хоршоо нь өөрийн гишүүнээс мөнгөн хөрөнгийн хадгаламж авч болно.

48².2. Хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь Иргэний хуулийн 454-456 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр мөнгөн хөрөнгө хадгална.

48².3. Хоршооны хадгаламжид авсан мөнгөн хөрөнгө нь тухайн хоршооны эд хөрөнгөд хамаarahгүй. Хадгаламж дахь хөрөнгийг зөвхөн хоршооны зээлийн сангийн эх үүсвэр болгон ашиглаж болно.

48².4. Хоршоонд хадгалуулахаар өгсөн хөрөнгө нь хамтран эзэмшигчтэй бол хадгаламж бүхий гишүүн нь энэ тухай хадгаламжийн гэрээ байгуулахаас өмнө хоршоонд мэдэгдэх үүрэгтэй.

48².5. Дүрэмд өөрөөр заагаагүй бол хадгаламж, зээлийн хүүг тодорхойлох журмыг бүх гишүүдийн хурлаас тогтооно.

48².6. Хоршооны гишүүн нь өөрийн насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр хоршоонд хадгаламж нээж болно. Энэ тохиолдолд гэрээг тухайн хүүхдийг насанд хүрэх хүртэлх хугацаагаар байгуулна.

48³ дугаар зүйл. Хоршооны зээлийн үйл ажиллагаа

48³.1. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь гишүүндээ хоршооны зээлийн сангийн хөрөнгөөс дүрэмд заасан журмын дагуу зээл олгож болно.

48³.2. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь зээлийн сан, зээлийн эрсдлийн сан байгуулна. Зээлийн сан нь хоршооны хөрөнгөөс хуваарилсан хөрөнгө болон хоршооны гишүүдээс авсан хадгаламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

Хоршооны зээлийн санд хоршооны өөрийн хөрөнгөөс хуваарилах хөрөнгийн хэмжээ болон зээлийн эрсдлийн сангийн хөрөнгийн хэмжээг дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлаас тогтооно.

48³.3. Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоо нь гишүүддээ Иргэний хуулийн 451-453 дугаар зүйлд заасны дагуу гэрээний үндсэн дээр зээл олгоно.

48³.4. Зээлийн буцаан төлөлтийг гишүүний хоршоонд оруулсан хувь хөрөнгө болон хадгалуулсан хөрөнгөөр баталгаажуулж болно.

48⁴ дугаар зүйл. Зээлийн хороо, түүний бүрэн эрх, бүрэлдэхүүн

48⁴.1. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь зээлийн хороотой байна. Зээлийн хороо нь З-аас доошгүй гишүүнтэй байна. Зээлийн хорооны гишүүдийг бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтын үндсэн дээр сонгоно. Зээлийн хорооны гишүүн нь тэргүүлэгч гишүүн, хяналтын зөвлөлийн гишүүн байж болохгүй.

48⁴.2. Зээлийн хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

48⁴.2.1. зээл авахаар хүсэлт гаргасан хоршооны гишүүний өргөдлийг шалгах;

48⁴.2.2.зээл олгох эсэхийг шийдвэрлэх, зээл олгох;

48⁴.2.3. олгосон зээлийг эргэн төлүүлэх;

48⁴.2.4. шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг хуралдуулах;

48⁴.2.5. хууль болон хоршооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

48⁴.3. Зээлийн хорооны хурал гишүүдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно. Дүрмээр үүнээс дээгүүр хувь тогтоож болно.

48⁴.4. Дүрэмд энэ хуулийн 484.3-т зааснаас өндөр хувь тогтоогоогүй бол зээлийн хорооны шийдвэрийг санал хураалтад оролцсон хорооны гишүүдийн олонхийн саналаар гаргана.

48⁴.5. Зээлийн хорооны даргыг тухайн хоршооны Тэргүүлэгчдийн хурал зээлийн хорооны гишүүдээс томилно..

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дугээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, түүнд зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа

- 7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараах үйл ажиллагааг ойлгоно:
 - 7.1.1. зээл;
 - 7.1.2. факторингийн үйлчилгээ;
 - 7.1.3. /Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/
 - 7.1.4. төлбөрийн баталгаа гаргах;
 - 7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;
 - 7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ;
 - 7.1.7. гадаад валютын арилжаа;
 - 7.1.8. итгэлцлийн үйлчилгээ;
 - 7.1.9. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
 - 7.1.10. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.
 - 7.1.11. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа. /Энэ хэсгийн 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ДААТГАЛЫН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)
2004 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

6 дугаар зүйл. Даатгалын ангилал, төрөл, хэлбэр

- 6.1. Даатгалыг урт хугацааны даатгал, ердийн даатгал гэж ангилна.
- 6.2. Даатгал нь сайн дурын болон заавал гэсэн төрөлтэй байна.
- 6.3. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд заавал даатгах даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.
- 6.4. Заавал даатгуулах даатгалын эрсдэл, нөхцөлийн талаархи нарийвчилсан зохицуулалтыг уг даатгалыг заавал даатгуулах даатгал гэж тодорхойлсон хуулиар зохицуулна.
- 6.5. Сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.
- 6.6. Даатгагчийн үйл ажиллагаа нь энэ хуулийн дагуу тодорхойлсон ангилал, төрөл, хэлбэрээс өөр байна гэж үзвэл энэ хуульд нийцүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо даатгагчид даалгаж болно.

7 дугаар зүйл. Даатгалын хураамж

- 7.1. Заавал даатгалын хураамжийн хэмжээг Монгол Улсын хуулиар тогтооно.
- 7.2. Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 14.2.5-д заасан аргачлалын дагуу даатгагч тогтооно.

8 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөр

- 8.1. Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 8.4-т заасан баримтыг үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.
- 8.2. Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.
- 8.3. Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.
- 8.4. Даатгалын нөхөн төлбөрийг дараахь баримтыг үндэслэн олгоно:
 - 8.4.1. даатгуулагчийн өргөдөл;
 - 8.4.2. даатгалын баталгааны эх хувь;
 - 8.4.3. учирсан хохирлын тухай хохирол үнэлэгчийн бичгээр гаргасан дүгнэлт, акт материал;
 - 8.4.4. шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт.
- 8.5. Даатгагч дараахь үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно:
 - 8.5.1. даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;
 - 8.5.2. даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
 - 8.5.3. даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;
 - 8.5.4. гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
 - 8.5.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 8.6. Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгднэ.
- 8.7. Даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

9 дүгээр зүйл. Даатгагчийн эрх, үүрэг

- 9.1. Даатгагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
 - 9.1.1. энэ хуулийн 8.5-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;
 - 9.1.2. даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;
 - 9.1.3. даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
 - 9.1.4. даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;
 - 9.1.5. даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;
 - 9.1.6. даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;
 - 9.1.7. Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;
 - 9.1.8. даатгалын эрсдлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;
 - 9.1.9. даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;
 - 9.1.10. гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
 - 9.1.11. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх.

10 дугаар зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг

- 10.1. Даатгуулагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
 - 10.1.1. даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;
 - 10.1.2. даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
 - 10.1.3. даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;
 - 10.1.4. даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;
 - 10.1.5. даатгалын зүйлийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;
 - 10.1.6. даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх.

11 дүгээр зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

- 11.1. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 11.1.1. даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;
 - 11.1.2. Засгийн газрыг даатгалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;
 - 11.1.3. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

12 дугаар зүйл. Даатгалын зохицуулах байгууллага

- 12.1. Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ хэрэгжүүлнэ.
- 12.2. Зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын бүтцийг Улсын Их Хурал баталж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

- 12.3. Зохицуулах хороо Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

- 13.1. Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 13.1.1. энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 13.1.2. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 13.1.3. даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
 - 13.1.4. даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаархи албан ёсны мэдээлэл гаргах;
 - 13.1.5. даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн нэгдсэн бүртгэл хөтлөх;
 - 13.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
- 13.2. Зохицуулах хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсч болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

1995 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд мөнгөн хөрөнгө хадгалуулах, хоорондын төлбөр тооцоогоо банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх, банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл авах, түүнийг эргүүлэн төлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/ 3 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн тухай ойлголт

1. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд /цаашид “хадгалуулагч” гэх/-ийн мөнгөн хадгаламжийн гэрээний үндсэн дээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “хадгалагч” гэх/-д хадгалуулсан үндэсний болон гадаад валютыг мөнгөн хадгаламж /цаашид “мөнгөн хадгаламж” гэх/ гэнэ. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/
2. Хадгалагч нь хадгалуулагчтай мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулах үедээ өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үнэн зөв мэдээлэл өгнө.
3. Хадгалагч мөнгөн хадгаламжийн хүү, хугацааг нийтэд зарлах бөгөөд уг нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн хадгалуулагч мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж, мөнгөн хөрөнгөө хадгалуулна.
4. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс эрхлэх мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

20 дугаар зүйл. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох

1. Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх барьцаа, эсхүл батлан даалттайгаар өөрийн болон түүнд хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийн зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээд /цаашид “зээлдэгч” гэх/-д олгохыг банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох /цаашид “зээл” гэх/ гэнэ. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

28 дугаар зүйл. Зээлийн батлан даалт

1. Зээлдэгч нь авсан зээл, түүний хүүг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлж чадахыг зээлдүүлэгчийн өмнө баталж, хэрэв төлж чадахгүй бол түүний нэрийн өмнөөс уг төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх үүргийг гуравдагч этгээд хүлээхийг зээлийн батлан даалт, батлан даалт гаргасан этгээдийг батлан даагч гэнэ.
2. Зээлдэгч нь Иргэний хуулийн 459 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу батлан даагчтай гэрээ байгуулна. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/
3. Батлан даагч хүлээсэн үүргээ хууль, гэрээнд заасны дагуу биелүүлж, зээлдэгчийн нэгэн адил хариуцлага хүлээнэ.
4. Батлан даагч нь санхүүгийн хувьд уг зээлийн төлбөрийг хийх чадвартай, үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөтэй этгээд байна. Батлан даагчийн санхүүгийн чадварын талаар үйлчлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, улсын бүртгэлд бүртгэсэн байгууллага тодорхойлолт гаргаж болно. /Энэ хэсэгт 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/
5. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр буюу батлан даагч зээлдэгчийн өмнөөс хүлээсэн үүргээ биелүүлснээр батлан даалт дуусгавар болно.

29 дүгээр зүйл. Зээлийн барьцаа

1. Зээлдэгч зээлийн гэрээнд заасан хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй тохиолдолд үүргийн биелэлтийг хангуулахаар зээлдэгчээс барьцаалсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь зээлийн барьцаа болно.
Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд найдвартай гэж үзвэл зээлдэгчийн үйл ажиллагаанаас олох орлого, үр шимийг гэрээ, батлан даалтын үндсэн дээр зээлийн барьцаанд авч болно. Зээлдэгчийн үйл ажиллагаанаас орох орлого, үр шимийг зээлийн барьцаанд авах журмыг Монголбанк тогтооно. /Энэ догол мөрийг 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн/
2. Зээлийн барьцаанд бариулах эд хөрөнгийн үнэлгээг зээлийн гэрээ байгуулахдаа харилцан тохиролцно.
3. Зээлийн барьцаалсан эд хөрөнгө нь хуулиар хориглоогүй бөгөөд иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөөр баригдсан орон сууц, үл хөдлөх эд хөрөнгө, түргэн борлогдох бараа материал, үнэт эдлэл, үнэт цаас болон зээлдүүлэгчээс хүлээн зөвшөөрсөн бусад хөрөнгө байж болно. Зээлийн барьцаанд бариулах үл хөдлөх эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. /2 дахь өгүүлбэрийг 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн/
4. Зээлдэгч зээлийн гэрээнд заасан хугацаандаа гэрээнийхээ үүргийг биелүүлээгүй бол зээлийн гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлийн барьцаалсан эд хөрөнгийг худалдах эрх зээлдүүлэгчид үүснэ. /Энэ хэсгийг 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/
5. Иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийн гэрээний үүргийг баталгаажуулж үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ байгуулсан тохиолдолд зээлдэгч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан журмаар барьцаалбар үйлдэж болно. /Энэ хэсгийг 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/
6. үүргийн гүйцэтгэлийг барьцаалбараар гэрчилсэн тохиолдолд барьцааны зүйлийг хуульд заасны дагуу шүүхээс гадуур худалдаж болно. /Энэ хэсгийг 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/
7. Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, бусдын өмчлөлд шилжүүлэхтэй холбоотой харилцааг хууль, зээлийн

- гэрээнд заасны дагуу зохицуулна. /Энэ хэсгийн дугаарыг 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/
8. Зээлийн барьцаалсан эд хөрөнгө үрэгдэж, устгагдсан тохиолдолд түүнээс үүдэн гарах маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ. /Энэ хэсгийн дугаарыг 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчилсөн/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС /ЛИЗИНГ/-ИЙН ТУХАЙ

2006 оны 06 сарын 22 өдөр Төрийн ордон. Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хууль нь санхүүгийн түрээс /лизинг/-тэй холбогдсон харилцааг зохицуулна.

3 дугаар зүйл. Санхүүгийн түрээс, түүний төрөл

- 3.1. “Санхүүгийн түрээс” гэж түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалгын дагуу энэ хуулийн 6.1-д заасан эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх буюу гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, эсхүл түүнээс худалдан авч гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, төлбөртэйгээр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөхийг ойлгох бөгөөд үүнийг “анхдагч түрээс” гэж үзнэ.
3.2. Санхүүгийн түрээс нь энэ хуулийн 3.1-д зааснаас гадна дараахь төрөлтэй байж болно:
 - 3.2.1. түрээслүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түрээслэгч өөрөө түрээслүүлэгчийн эрх, үүргийг хүлээж түрээсийн зүйлийг гэрээний дагуу бусдад түрээслүүлэх санхүүгийн “дамжуулах түрээс”;
 - 3.2.2. түрээслүүлэгч санхүүгийн түрээсийн гэрээ дуусгавар болсны дараа анхдагч түрээслэгчээс түрээсийн зүйлийг буцаан авч өөр түрээслэгчид түрээслүүлэх санхүүгийн “хоёрдогч түрээс”;
 - 3.2.3. санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээсийн зүйл түрээслэгчийн өмчлөлд шилжсэний дараа түрээслэгч түрээслүүлэгчийн эрх, үүргийг хүлээж гуравдагч этгээдэд буцаан түрээслэх санхүүгийн “эргэх түрээс”.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Улаанбаатар хот

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Аж ахуйн эсрэг гэмт хэрэг

156 дугаар зүйл. Банкны тухай хууль тогтоомж зөрчих

156.1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр банк нээсэн, банкны үйл ажиллагаа хууль бусаар явуулсны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156.2. Банкны байгууллагын ажилтан шунахайн буюу хувийн ашиг сонирхлын үүднээс банкны болон мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156.3. Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

156¹ дүгээр зүйл. Хоршооны тухай хууль тогтоомж зөрчих

156¹.1. Хоршооны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад бага бус хэмжээний хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Дээрх 1561 дүгээр зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/

156² дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих

156².1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн, өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийсэн, худал мэдээлэл өгсөн, банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашигласны улмаас бусдад бага бус хэмжээний хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

/Дээрх 1562 дугаар зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/

157 дугаар зүйл. Банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох

157.1. Албан тушаалтан банкны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлж албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцсоны улмаас банкны төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

157.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учруулсан бол эд хөрөнгийг хурааж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158 дугаар зүйл. Үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчих

- 158.1. Үнэт цаас гаргах, гүйлгээнд оруулах, худалдах, арилжих, түүгээр төлбөр тооцоо хийх, брокер, дилердиллерийн үйл ажиллагаа явуулах журмыг зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 158.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

158¹ дүгээр зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж зөрчих

- 158¹.1. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 158¹.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Дээрх 1581 дүгээр зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/

159 дүгээр зүйл. Аудитын тухай хууль тогтоомж зөрчих

159.1. Хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхлэгч иргэний санхүүгийн үйл ажиллагааг шалгаж баталгаажуулах, дүгнэлт гаргах талаар тогтоосон аудитын үйл ажиллагааны журмыг санаатай зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

159.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

160 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомж зөрчих

160.1. Төрийн эрдэнэсийн сангийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөний улмаас их хэмжээний хохирол учирсан бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

161 дүгээр зүйл. Хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх

161.1. Хууль тогтоомжоор хориглосон, тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг дур мэдэн эрхэлж, үлэмж буюу их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

161.2. Энэ хэргийг урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг буюу гэмт бүлэглэл үйлдсэн,

түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/

162 дугаар зүйл. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах

162.1. Банкнаас зээл авах, татвар төлөхөөс зайлсхийх, хууль бус орлого олох, хориглосон буюу тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэхийн тулд зохиомол аж ахуйн нэгж байгуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наян нэгзэс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

162.2. Энэ хэргийг давтан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

163 дугаар зүйл. /Энэ зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

164 дүгээр зүйл. Санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулах

164.1. Шунахайн буюу хувийн бусад сэдэлтээр аж ахуйн нэгж, байгууллага, банкны санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээ баримтыг хууль бусаар олж авсан, ашигласан, задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгзэс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

164.2. Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгзэс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

165 дугаар зүйл. Санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах

- 165.1. Аж ахуйн нэгжийг түүний эзэн буюу эрх баригч шунахайн буюу хувийн бусад сэдэлтээр санаатайгаар төлбөрийн чадваргүй болгосны улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 165.2. Аж ахуйн нэгжийг түүний эзэн буюу эрх баригч шунахайн буюу хувийн бусад сэдэлтээр санаатайгаар зээлийн өр төлөхийг хойшлуулах, түүнийг төлөх нөхцөлийг хөнгөрүүлэх, зээлийн өрийн хүүг багасгах, эсхүл төлөхгүй байхын тулд төлбөрийн чадваргүй болсон гэж харилцагч талд мэдэгдэх, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргах зэргээр зохиомлоор дампууруулсны улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166 дугаар зүйл. Татвар төлөхөөс зайлсхийх

- 166.1. Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдээлэх, байнга оршин суугаа газар, хаягаа өөрчлөх зэргээр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 166.2. Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

1661 дүгээр зүйл. Мөнгө угаах

- 166¹.1. Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 166¹.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 166¹.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Дээрх 166¹ дүгээр зүйлийг 2009 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн хуулиар нэмсэн/

167 дугаар зүйл. /Энэ зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

168 дугаар зүйл. Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах

- 168.1. Өөрийн болон гадаад улсын ижил нэр төрлийн бүтээгдэхүүний барааны тэмдгийг хуурамчаар үйлдсэн, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

169 дүгээр зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх

- 169.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
- 169.2. Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

170 дугаар зүйл. Хууль бусаар шан харамж авах

- 170.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан албан үүргийн дагуу ажил гүйцэтгэж үйлчилгээ үзүүлэх үүргээ далимдуулан хясан боогдуулах замаар удаа дараа буюу их хэмжээний шан харамж авсан нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

171 дүгээр зүйл. Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах

- 171.1. Аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, эрх баригч, албан тушаалтан заавал мөрдөх улсын стандартад нийцээгүй, чанарын баталгаажуулалт хийлгээгүй, гологдол, чанар муутай, иж бүрдэл

дутуу бүтээгдэхүүнийг худалдсанаас бусдын эрүүл мэндэд хохирол учирсан, эсхүл удаа дараа худалдсан, худалдаанд гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

- 171.2. Энэ хэргийн улмаас бусдад үлэмж буюу их хэмжээний хохирол учирсан бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

- 171.3. Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, онц их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/

172 дугаар зүйл. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах

- 172.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллага, иргэн эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг худалдсанаас бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан, эсхүл удаа дараа худалдсан, худалдаанд гаргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

- 172.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/

173 дугаар зүйл. Согтууруулах ундааг хориглосон зүйлээр бэлтгэх

173.1. Согтууруулах ундааг хүнсний зориулалтын бус зүйлээр их хэмжээтэйгээр бэлтгэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

174 дүгээр зүйл. Чанар муутай барилга бариулах, ашиглалтад оруулах

174.1. Барилга барьж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, эрх баригч, түүнчлэн барилгын чанарт хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан чанар муутай, дутуу болон батлагдсан зураг төсөлд тохироогүй барилга бариулсан буюу ашиглалтад хүлээлгэн өгсний улмаас их хэмжээний хохирол учирсан бол хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

174.2. Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

175 дугаар зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх

175.1. Хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг бага бус хэмжээгээр, ховор амьтан, түүнчлэн их хэмжээний валют, валютын үнэт зүйл, эрдэнэс, эрдэс, түүнчлэн байгалийн төрцийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

175.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн, түүнчлэн түүх соёлын дурсгалт

зүйл, музейн үзмэр, эртний амьтны болон ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн ба палентологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

175.3. Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн онц их хэмжээтэйгээр үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах
/Энэ зүйлийн гарчигт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

176.1. Монгол Улсад төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгсэл, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж ашигласан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон/

176.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьд нь энэ хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

176.3. Энэ хэргийг зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас бусдад онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж арваас дээш арван таван жил хүртэл хорих ял шийтгэнэ.

